

가락국 (駕洛國, Garakguk-gi)→ 가야(伽倻)

가사 *Каса* (歌辭, Gasa) Корйөгийн сүүл үе, Чосөн-ий эхэн үеэр бүрэлдэн тогтсон яруу найргийн нэг хэлбэр. *Садэбү* буюу бичгийн түшмэд давхаргынхны дунд өргөн тархжээ.

가야 *Каяа* (伽倻, Gaya) Каяагийн оршин нутаглаж байсан Нагдон голын доод хэсгээр уг нь Пйөнъ Ханъ-ы арван хоёр хот улс байсан ба эдгээр нь Жинъ ванд үл захирагдан бие даасан холбоо, эвслийн байдалтай тогтнож байв. Эдний дунд анхны өвгөө Сүро(수로; 首露) гэж тооцдог Кимхэ хавиар нутагтай Күяа улс(구야국; 狗倻國), мөн дээд өвгөө И жинъ а ши(이진아시; 伊珍阿歧) гэж үздэг Корйөн(고령; 高靈) хавиар нутагтай Миуяама улс байв. Хожим Күяа нь Понъ Каяа(본가야; 本加耶), Миуяама нь Тай Каяа(대가야; 大加耶) болон хөгжиж, орчин тойрны хэд хэдэн хот улстай нэгдэн Каяагийн холбоог байгуулсан байна. Нагдон голын цутгалан хавьцаа оршиж байсан Понъ Каяа нь Каяагийн холбоог тэргүүлэх байр суурьтай байсан ба тэнгис далайд идэвхтэй үйл ажиллагаа явуулж, Солонгосын хойгийн баруун тэнгисийн эрэг хавиар Награн, Тайбан зэрэг Хан улсын мужууд, зүүн тэнгисийн эрэг хавиар Йэ болон өмнө зүгт Ва улстай харилцаж байжээ. Гэвч Пайгжэ, Шилла хоёр улсын дунд орших учир хоёр талаасаа байнгын довтолгоонд өртөж, нийгмийн хөгжлийн хувьд тун дорой байв. Пайгжэчүүд Вагийн цэргийг урин ирүүлж, Каяагийн нутаг дэвсгэрээр дамжин Шилла руу довтолход Шилла, Каяа хоёр улсын харилцаа ихэд хурцаджээ. Эцэстээ Шиллад туслахаар Когүрйөгийн цэрэг нэвтрэн орж ирмэгц Каяагийн байдал эрс муудав. Тийнхүү Пөбхын ван(법흥왕; 法興王)-гийн 19-р(532) онд Понъ Каяа, Жинъхын ван(진흥왕; 眞興王)-гийн 23-р(562) онд Тай Каяа тус тус Шиллад дагаар орон Каяагийн холбоо мөхжээ.

각간 *Кагганъ* (角干, Gaggan) бол Шилла улсын түшмэлийн 17 зэрэг дэвийн хамгийн дээд нь бөгөөд түүний дор буюу удаахи хэргэм нь Ицанъ 이찬(伊飡) болой.

간도 Каньдо (間島, Gando Island) Хятадын зүүн хойд нутагт, Жилин мужид орших газрын нэр.

Ялу мөрөн, Түмэн мөрний умард хэсэг буюу Манжуурын зүүн урд хэсгийг хэлнэ. Ялу мөрнөөс хойшхи нутгийг Баруун Кандо, Түмэн мөрнөөс хойшхи нутгийг Зүүн Кандо гэнэ. Зүүн Кандогийн умард нутгийг Умард Кандо гэх ба зүүн болоод умард Кандог ерөнхийд нь Кандо гэж нэрлэж иржээ. 17-р зуунаас Каньдод солонгосчууд суурьшин амьдарч иржээ. Когүрйө, Бохайн нийслэл хотууд энд оршиж солонгосчуудын эртний соёл цэцэглэн хөгжиж байв. Харин Чин улсын үед Энх-Амгалан хаан энэ нутгийг Нурхачи баатрын төрсөн нутаг хэмээн дарлажээ. Энэ үед Хамгйөн мужийн тариачид Түмэн мөрнийг гатлан Кандод очиж газар тариалангийн шинэ арга эрхлэн сууршижээ. 1712 оноос эхлэн Хятадтай хилийн шугам тогтоох тал дээр маргаантай явж ирсэн бөгөөд 1962 онд Хятад, Умард Солонгосын хэлэлцээрээр Каньдо нутаг Хятадын нутаг болжээ.

간석기 Гялтсан чулуун зэвсэг (磨製石器, A rough stone tood) Чулууг хагалж, бүх ирмэгийг

эсвэл нэг талыг нь ирлэж зассан зэвсэг. Солонгосын хойгт шинэ чулуун зэвсгийн үеэс хэрэглэж эхлээд хүрэл зэвсгийн үед түгээмэл хэрэглэх болжээ. Төмөр зэвсэг хэрэглэх болсноор хэрэглээнээс гарчээ.

강감찬 Кан Гамцань (姜邯贊, 姜邯瓚, Gamchan Kang) билгийн тооллын 948 оны 11-р сарын 19

~ 1031 оны 8-р сарын 20) нь Корйө улсын бичгийн түшмэл. Уг нэр нь Ыньцөнъ. Кымчөнъ нутгаас гаралтай. Кан Гүн жинь-ий хүү бөгөөд 983 онд орогсдын шалгалтад тэнцэж, 1009 онд Ёслолын яамны жигүүрийн сайд, Орогсдын шалгалтын шалгагч багш болж байжээ. Хятангийн зүгээс Корйөгийн ванг өөрийн хаанд бараалхах, Кандоны зургаан мужийг өгөхийг шаардан 1018 онд гурав дахь удаагаа Корйө руу довтложээ. Энэ үед Күижү гэдэг газарт Кан Гамцань жанжины удирдсан цэрэгт бут цохиулсан байна. Солонгосын түүхэн дэх гурван том ялалтын нэг юм.

강동 육주 Кандоны зургаан муж (江東六州, Gangdong 6 states) нь 993 оны(Корйө улсын

Сөнжон вангийн 12-р он) Ляо улс (Хятан) -ын анхны довтолгооноор Сө Хый, Ляо улсын жанжин Со Соньнийөн-тэй хэлэлцээр хийн эзэмших эрхээ хүлээн

зөвшөөрүүлсэн Корйөгийн баруун хойд хэсгийн газар нутаг. Уг хэлэлцээрт “Аньбүгбү 안북부(安北府)-гээс Амног мөрний зүүн тал хүртэл нийт 280 ли газрын хооронд тодорхой газар” хэмээгээд, хожим тэр газар хэрэм байгуулж Кандоны зургаан муж гэх болсон ба энэ нь Хынхважинь 흥화진(Ыйжү-의주), Ёнжү 용주(Ёнцөнъ-용천), Тхонжү 통주(Сөнъцөнъ-선천), Цөлжү 철주(Цөлсанъ-철산), Квүйжү 귀주(Күсөн-구성), Квагжү 광주(Квагсанъ-광산) юм.

강수 Кансү (强首, Gang Su ?-692 он) Уг нэр нь Чадү (字頭).Чүнвөнъгйөн-ий Сарян нутгаас гаралтай. Нэгдсэн Шилла улсын үеийн күнзийн сурталтан. Нэма хэмээх Сөгцэгийн хөвүүн бөгөөд Тэкаяа хүн болно. Кансү гэдэг нь бөх толгойт гэсэн утгатай үг бөгөөд Тайзун Мүйөл вангийн өгсөн нэр ажээ. Тэрбээр бүддийн шашныг шүүмжилж, күнзийн суртлыг эрхэмлэх үзлээр ном сургаалиа түгээсэн бөгөөд Тайзун Мүйөл вангийн үед Тан улстай харилцах гадаад харилцааны бичгийг хариуцдаг байжээ. Гурван улсыг нэгтгэхэд гавьяа байгуулсан хэмээн Мүнъмү вангийн үед алба тушаал дэвшиж явжээ. Шиллагийн дунд үеийн төр засах үзэл суртал болсон күнзийн сурталд ихээхэн нөлөө үзүүлсэн хүн болно.

강조의 정변 Канжо-гийн төрийн эргэлт (康兆政變, Gang Jo's coup) Корйөгийн Могжон вангийн үед цэргийн түшмэл Канжогийн хийсэн төрийн эргэлт. 1009 (Могжоны 12-р) онд Могжоны эх хатан Цөнцү тайхоу Ким Ци ян гэгчтэй нөхцөн төрүүлсэн хүүгээ вангийн угсаа залгамжлагч болгох гэж оролджээ. Өөрийн амь биед аюул учрах вий хэмээн эмээсэн Могжон Канжод зарлиг буулган амь биеэ хамгаалуулахаар дууджээ. Канжо таван мянган цэргээ удирдан нийслэл Кэгйөнд ирж Ким Ци ян нарыг устгаад Могжон-г ван суурьнаас огцруулаад Сүнъ гэгчийг вангаар өргөмжилсөн нь даруй Хйөнъжон болно. Төрийн эргэлтийг амжилттай хийсэн Канжо нь төр улсын шинэчлэлт хийх гэж зорьсон боловч уг төрийн эргэлт нь Хятангийн зүгээс түрэмгийлэл хийх шалтгаан болжээ. 1010 (Хйөнъжон-ы тэргүүн) онд Хятангийн зүгээс Канжогоос ял асуух нэрийдлээр дөрвөн зуун мянган их цэргээр дайлан иржээ.

개경 *Кайгён* (開京, Gaegyeong) нь Тайзу Ван Гёнъ-ы байгуулсан Корйё улсын нийслэл. 919

онд Ван Гёнъ Сон-аг болон Кайсён хйёнъ-ы зарим хэсгийг нэгтгэн, Кайжү хэмээгээд тийш нийслэлийг шилжүүлснээр Кайгён байгуулагджээ. Канхва арал руу шилжсэн үеийг эс тооцвол 436 жил 8 сарын турш Корйё улсын нийслэл болж байсан. Сөнжон вангийн үед Кайжү-г Кайсёнбү гэх болсон ба Чосёнъ улс байгуулагдсанаар Ханъ-ян руу төвлөн нийслэх болж улмаар Кайсён нэртэй болжээ. Эдүгээ ч Сон-аг уулын урд орших ордны болоод хааны ордны хэрэм, цайз тэдгээрийн гадна дотоодын сабар өргөө, ордны их бага хэрмээс бүрдсэн хана хэрмүүд, буддын сүм хийд ба кунзийн суртлын байгууламжууд зэрэг соёлын үнэ цэн бүхий туурь дурсгал, эд өлгийн зүйлс ихээхэн үлдсэн буй. Кайгён нь Корйё улсын нийслэлийн хувьд улс төр, эдийн засаг, соёлын төв болоод зогсохгүй Кайсён-ы үеийн олон туурь дурсгал, эд өлгийн зүйлсийг тээн үлдсэн соёлын асар их үнэ цэнтэй газар юм. Мөн Кайсён орчмын нутаг нь солонгосын дайнаас өмнө Өмнөд Солонгост харьяалж байсан ч дайны дараа Хойд Солонгосын нутаг дэвсгэрт хамаарах болсон онцлогтой бөгөөд Өмнөд ба Умард Солонгосын хил залгаа газар тул хоёр Солонгосын харилцаанд гүүр болгон ашиглаж иржээ.

개성시 *Кэсөн хот* (開城市, Kaesong) БНАСАУ-ын өмнө хэсэгт байрлах хот. Корйёгийн нийслэл

хот байсан бөгөөд таван зуу гаруй жилийн турш цэцэглэн хөгжсөн эртний хот юм. Кэсөн, Кэгён(開京), Сон-аг(松岳), Сондо(松都), Сонгён(松京) зэрэг олон нэртэй байжээ. Хойд өргөргийн 38 дугаар хэмд орших бөгөөд Солонгосын дайнаас өмнө БНСУ-ын Кйёнги мужид харьяалагддаг байснаа дайнаас хойш БНАСАУ-д харьяалагдах болжээ.

거란 *Хидан, Хятан* (契丹, 거란 Khitan) 4-р зууны дунд үеэс Өвөр Манжуур болон Өвөр

Монголын Шар мөрний сав газраар нутаглаж байсан дорнод ху нарын удам болох сяньби нар. 10-р зууны эхээр буюу 916 онд тайзу Елюй Абаожи (耶律阿保機) хиданчуудыг нэгтгэн Хидан улсыг байгуулжээ. 926 онд Бохайг мөхөөснийхөө дараа 936 онд Сүн улсын 16 мужийг өөртөө нэгтгэжээ. 1066 онд улсын нэрийг Ляо хэмээн өөрчилжээ. Улс байгуулагдсан эхэн үедээ Корйётой харьцангуй найрсаг

харилцаатай байсан боловч Бохайг мөхөөгөөд Ляодунг эзлэн авснаас хойш сөргөлдөх болсон байна. 993 оноос хойш Корйё руу гурван удаа дайрсан боловч амжилт олоогүй байна. Киданы нэгдүгээр довтолгооны үед Корйёгийн Сөхьи жанжин гадаад харилцааны хэрэгт ур чадвартайгаа харуулж, Кандоны 6 мужийг өөрийн болгож чадсан байна. Гэвч энэ нь цаашид хоёр улсын харилцааны гол зангилаа асуудал болж хувирсан бөгөөд 1014 онд хийсэн гуравдугаар довтолгооны шалтаг болсон ажээ. Хиданг зүрчидийн Алтан улс мөхөөсөн бөгөөд хааны угсааныхан төв Азид Баруун Ляо улсыг байгуулсан боловч 1211 онд Чингис хаанд дагаар орон бууж өгчээ.

거서간 *Көсөгань* (居西干, Hyeokgeose) Шиллагийн эхэн үеийн вангийн цол. *Шижо* Пак

Хйөггөсэ-г *көсөгань* гэдэг байсан бөгөөд “Гурван улсын түүхэн тэмдэглэл”-ийн “Шиллагийн Уг тэмдэглэл”-ийн “*Шижо* Хйөггөсэ *көсөгань*-ы тэмдэглэл”-д “*Көсөгань* гэдэг нь Жинь Хань-ы хэлээр ван гэсэн утгатай үг” гэжээ. Бас “эрхэм хүндэт хүнийг дуудах цол” гэсэн байна. Мөн “Гурван улсын нөхсөн судар”-ын “Шиллагийн *шижо* Хйөггөсэ вангийн зүйл”-д “Цолыг *Көсылхан* гэнэ(位號曰居瑟邯)” гэжээ. Ингэхдээ зүүлт хийж, “Мөн *Көсөгань* гэнэ” хэмээн тайлбарласан байна. *Көсөгань* цолыг хэрэглэх болсон нь Шиллагийн өмнө оршин тогтнож байсан Саро улс бүрэлдэн тогтсоны тусгал юм. КоЧосөн-ийг мөхсөн хойно хүрэл болоод төмөр зэвсгийн соёлтой иргэд нь Кйөнжүгийн нам дор тал нутагт очиж суурьшаад Саро хэмээх хот улсыг байгуулсан бөгөөд энэхүү түүхэн хэрэг явдал нь Пак Хйөггөсэ-гийн улс байгуулсан домогт тусгалаа олжээ. Пак гэдэг нь гэрэл гэгээг, Хйөггөсэ нь мөн л тунгалаг гэгээлэг гэсэн утгатай үг бөгөөд нар болон тэнгэр шүтдэг байсныг гэрчилнэ. *Көсөгань* хэмээх цолыг Хйөггөсэгийн үед л хэрэглэсэн ба хоёрдугаар ван болох Намхэ вангийн үеэс цаца-үн(次次雄) цолыг хэрэглэх болжээ.

거칠부 *Көчилбү* (居柒夫, Geo Chil-bu ?-579 он) Шиллагийн Жинхын вангийн үеийн жанжин,

сайд. Нэмүл марибганы тавдугаар үеийн удам бөгөөд аав нь Ицань Мүллийөг (勿力) юм. Бага насандаа сахил хүртэж, олон газраар явж үзсэн байна. Когүрйөгийн

дотоод байдлыг тандахаар очоод Херян(惠亮) ламын номлолыг сонсож ихэд биширчээ. 545 онд вангийн зарилгаар “Төрийн түүх(國史)”-ийг эмхэтгэн бичиж, алба тушаал ахижээ. 551 онд Пэгжэ-гийн цэрэгтэй хамтран Когүрйө руу довтолж, Чүгрйөн даваанаас хойшхи арван күнь-ийг эзлэхэд гавьяа байгуулжээ. Үүний дараа Херян ламын хамт нутагтаа ирээд, Херяныг их багш өргөмжлөн бүддийн шашны *палгванъхой* зэрэг хурал хурж эхлэсэн байна. 576 онд буюу Жинъжи вангийн үед *сандэдын* хэмээх сайдаар өргөмжлөгдөж, төр засалцан явж байгаад 78 насандаа өөд болжээ.

검모잠 Көмможам (劍牟岑, Geom Mojam) 7-р зуун. Когүрйөг мөхсний дараа Когүрйөг дахин сэргээх хөдөлгөөнийг удирдсан удирдагч. Когүрйөг мөхсний дараа Пожан вангийн татвар эмээс гарсан хүү Ансын-г вангаар өргөмжлөн Ханъсөн (漢城, Хванхэ мужийн Чэрийөн)-д төвлөн суугаад улсаа дахин сэргээх хөдөлгөөнийг явуулжээ. Ялангуяа Гурван улсыг нэгтгэх явцад Тан улстай дайсагнасан харилцаатай болсон Шиллад элч илгээн тусламж гуйж байв. Тан улсын цэргийн довтолгооны эсрэг хэрхэх талаар Анъсынтай зөрчилдөж байгаад хорлогдож үхжээ.

경당 Кйөндан (局堂, Gyeongdang) Когүрйөгийн үеийн орон нутгийн хувийн сургууль. Улсын сургууль буюу Тайхаг байгуулагдсан 372 оноос хойш буюу бүр тодруулбал, Пйөнян руу нийслэлийг нүүлгэснээс хойш байгуулагдсан гэж таамагладаг. Хүүхэд залууст бичиг үсэг, нум сум харвахыг заадаг байжээ.

경대승 Кйөн Тэ сын (慶大升, Gyeong Dae-seung 1154-1183 он) Корйөгийн дунд үе буюу Мйөнжон-гийн үеийн цэргийн эрхтэн. *Ымсө* журмаар алба тушаал дэвших замнал нь эхлэж, хожим жанжин болсон байна. 1179 онд төрийн эрхийг атгаад байсан ЧөнЖүнбү нарыг хороогоод төрийн эрхийг гартаа авсан байна. Цэргийн түшмэдийн эрх мэдлийг хязгаарлаж, бичигийн түшмэд нартай ойр дотно харилцах болсонд нь цэргийн түшмэлүүд дургуйцэх болжээ. Тиймээс өөрийн амь биеийг хамгаалах, мэдээлэл цуглуулах, эсрэг талынхыг дарах зэрэг зорилгоор *тобан* хэмээх байгууллага байгуулсан байна. Эрх барьснаасаа хойш дөрвөн жилийн дараа буюу 1183 онд нас баржээ.

경학 Кйөнхэг (經學, Confucianism) Хүнзийн сургаалыг бичсэн судрын гол агуулгыг судлах,

тайларлах ухаан юм. Күнз, Мэнзийн сургаалын уг утгыг судлах ухаан. Хятадын Хань улсын үед үүссэн бөгөөд Хүнзийн сурталтнууд хувь хувийн үзэл суртал болон улс төрийн чиг шугамын дагуу сургаал номыг тайлбарладаг байжээ.

계림도독부 Керимийг тохинуулах яам (鷄林都督府, Gyerim Territory Area Command) Гурван

улсыг нэгтгэх явцад Тан улсын зүгээс Шиллагийн нийслэл Кйөнжү хотод байгуулсан захиргааны байгууллага. 663 (Мүнъмү вангийн 3-р) онд Тан улс нь Шиллад Керимыг тохинуулах яамыг байгуулж, Мүнъмү ванг уг яамны тэргүүнээр тохоожээ. Гурван улсыг нэгтгэсний дараа татан буулгасан байна.

고구려 Когүрйө (高句麗, Goguryeo) 서기전 1 세기~ 668 년) МЭӨ 1-р зуунаас МЭӨ 668 онд

оршиж байсан эртний вант улс юм. Ялуу мөрний дунд орших эртний хот улс болон хөгжиж, ойролцоо орших Йэ, Мэк овгууд, Огжө, Дон-йэ, Пүйө, Чөсонъ зэрэг олон овог аймгуудыг нэгтгэн улам өргөжин, Когүрйөгийн ард түмнийг бий болгосноор хүчирхэг улс болон хөгжжээ. Хятадын Хань улсын түрэмгийллийн улмаас хэсэг доройтон буурч явжээ. Гэвч тэднийг хөөн зайлуулах явцад хүчирхэгжиж байв. Мөн Хятадын нэгтгэсэн Сүй болон Тан улстай хийсэн дайнд ялж, Зүүн Азид хүчирхэгжиж байв. Гэхдээ сүүл үе рүүгээ ноёлогч ангийн задралын улмаас доройтон буурч, Тан улс болон Шиллагийн хамтарсан довтолгоонд мөхжээ.

고국천왕 Ко гүг цөнъ ван (故國川王, King Gogukcheon 179-196) Гурван улсын үеийн,

Когүрйөгийн 9-р ван. 179-197 оны хооронд ван суурин суужээ. Шиньдэ вангийн хоёрдугаар хүү, 176 онд угсаа залгамжлах ван хөвүүнээр тодорчээ. 184 онд Хожуу Хань улсын Ляодуны тайшоу-гийн довтолгоог няцааж, 190-191 онуудад Жоа Карйө болон Ө Пирюгийн үймээнийг дарах зэргээр төр улсынхаа үндэс суурийг бэхжүүлжээ. Мөн ураг барилдах замаар вангийн засаглалын суурийг бэхжүүлсэн бөгөөд энэ үеэс дүү нь ахыгаа бус, харин хүү нь эцгээ залган ван суух ёс тогтсон байна. 191 онд *жиньдэбөб* хэмээх газар өмчлөлийн журмыг хэрэгжүүлж, тарчиг ядуу цагт тариачдад туслах арга хэмжээ авч байжээ.

고금록 Эрт эдүгээгийн тэмдэглэл (古今錄, Go geum log) (1) Корйөгийн эхэн үед буюу Мүнъжон-гийн үед Пак Инърян(朴寅亮)-ы бичсэн түүхэн зохиол. Нийт арван дэвтэр зохиол байсан гэх ч бидний үед уламжлан ирсэнгүй тул агуулгыг нь мэдэх аргагүй. (2) Корйөгийн сүүл үед буюу Чхүннйөл вангийн үед Вөнъбү(元傳), Ханъган(韓康) нарын бичсэн түүхэн зохиол. Бидний үед уламжлан ирээгүй.

고금석림 *Когым сөgrim* (古今釋林, Gogeum Stone Forest) Чосөнъ-ий сүүл үед И Ыи бон(李義鳳)-ны бичсэн толь бичиг. Нийт дөчин дэвтэр зохиол бөгөөд солонгос хэл, хятад хэл, түрэг, хидан, зөрчид, япон зэрэг олон хэлний үгийн сангийн тухай зохиол юм. Үгийн сангийн тоо нь хэдэн түмээр тоологдох тул хамгийн баялаг үгийн сантай толь бичиг хэмээн үнэлэгддэг. Солонгос хэлний үгийн сан судлалын чухал эх хэрэглэгдэхүүнд тооцож байна.

고려 대장경 Корйөгийн Гурван сав ном (高麗大藏經, Tripitaka Koreana) Хйөнъжон-ы(1009-1031) тэргүүн оноос эхлээд Сөнжон-ы 4-р(1087) онд Корйө-гийн гурван сав номын модон барыг хийж дуусгажээ. Уг судрыг Хятаны довтолгоог зогсоож, амар амгалан байлгахыг залбирч гуйх зорилгоор бүтээсэн гэх боловч бурхны шашны номлолыг нэгтгэн эмхлэх гэсэн зорилго ч бас байжээ. Тайгү(대구; 大邱)-гийн Пү-инъ(부인사; 夫人寺) сүмд хадгалагдаж байсан энэ модон бар Монголын довтолгооны үед нэлээд сүйджээ. Одоо Хай-инъ сүм(해인사; 海印寺)-д хадгалагдаж буй “Корйө-гийн Гурван сав ном (고려대장경; 高麗大藏經)” бол Канхва аралд Кожон-ы үед хийсэн модон бар болно. Дайн самуунтай хүнд хэцүү үед бүтээсэн боловч Дорно дахинд бүтээгдсэн хорь гаруй “Корйө-гийн Гурван сав ном”-уудаас яруу тодорхой найруулга, уран нарийн хэв, модон барын боловсруулалт зэргээрээ “Корйө-гийн Гурван сав ном ” тэргүүнд орно гэж судлаач, эрдэмтэд үнэлдэг.

고려 Корйө, Курё, Гүрё (高麗, Goryeo) Корйө улсыг монголчууд эртнээс Гуулин улс гэж нэрлэж иржээ. 918 оноос 1392 оныг хүртэл 474 жилийн туршид Солонгосын хойгт оршин байв. Хэмжээгүй эрхт вангийн засаглалтай, бүддийн шашинт улс юм. Корйө

улс нь сүүлийн зуугаад жилдээ Юань улсын ноёрхолд орсон бөгөөд энэ үедээ Юаньтай төрийн түвшинд ураг барилдан эх газрын соёлыг ихээр хүлээн авсан байна.

고려사 *Корйё са*, **Гуулин улсын судар** (高麗史, Gāolishi) “Гуулин улсын судар” нь Чосөнъ

улсын Мүнъжон (문종. 文宗) вангийн тэргүүн он буюу 1451 онд бэлэн болжээ. Нийт 139 боть бүхий тэмдэглэл, шастирын хэлбэр (기전체. 紀傳體)-ээр бичигдсэн уг сурвалж нь “Сурвалжит гэр (세가. 世家)” 46 боть, “Ойллоого (지. 志)” 39 боть, “Илтгэл (연표. 年表)” 2 боть, “Олон шастир (열전. 列傳)” 50 боть, “Жагсаалт (목록. 目錄)” 2 ботиос бүрдэнэ. “Сурвалжит гэр”-т Тхайжо-гоос Кон-ян ван хүртэл улсын вантай холбоо бүхий бичвэрийг оруулсан байна. 34 ван төр барьснаас Ү ван болон Чхан ванг олон шастир руу зэрэг бууруулан оруулсан тул 32 вангийн тэмдэглэл багтжээ. “Ойллоого”-д “Ёслолын ойллоого”, “Хөгжмийн ойллоого”, “Тайх тавиглах ойллоого” зэрэг Корйё улсын соёлыг багтаасан байдаг ба холбогдох үеийн эрдэм судлалд ихээхэн чухал эх бүтээл юм. “Илтгэл” нь Корйё улсын он дарааллын хүснэгт болно. Үүнд Тан (당. 唐) улсын сүүл буюу Таван улсын үе (오대. 五代), Сүн (송. 宋), Ляо (요. 遼), Алтан (금. 金), Юань (원. 元), Мин (명. 明) зэрэг улсыг дээд улс хэмээн мөр тэтгэж бичин, Корйё улсыг түүний доор байрлуулах хэлбэрээр бичжээ. Тэдгээрийн агуулга нь гол төлөв оны цол, ван өргөмжлөх, элч илгээх, төрсөн ба таалал төгссөн, дотоодын самуун, гаднын самуун гэх мэтчилэн зөвхөн эзэн ван хийгээд хааны угсааны амар амгалан ба аюул осолтой холбоотой үйл явдлыг тэмдэглэжээ. “Олон шастир” нь “Хатад (후비. 后妃)” -ын шастираас эхлээд “Хааны угсаа (종실. 宗室)”, “Урван тэрслэгч (폐행. 嬖幸)”, “Зальхай түшмэлийн шастир (간신전. 姦臣傳)”, “Сайн түшмэл (양리. 良吏)”, “Шударга журам (충의. 忠義)”, “Элбэрэл элэгсэг (효우. 孝友)”, “Хатуу зоригт охин (열녀. 烈女)”, “Арга чадал (방기. 方技)”, “Тайган (환자. 宦者)”, “Харгис түшмэл (혹리. 酷吏)” зэрэг шастируудаас бүрдэнэ.

고려사절요 Гуулин улсын судрын чухал анги (高麗史節要, Koryosa choryo) 1452 онд буюу

Чосөнъ улсын Мүнъжон вангийн 2-р онд Ким Жонсө нарын 18 хүн найруулан

бичжээ. Нийт 35 ботиос бүрдэнэ. Энэхүү сурвалжид “Гуулин улсын судар”-т тэмдэглээгүй, орхисон Корйё улсын түүхэн үйл явдлыг багтааснаараа онцлог тул “чухал анги” хэмээсэн байна. “Гуулин улсын судрын чухал анги” нь улсын сайд түшмэдийг төвлөн бичсэн байдаг бол “Гуулин улсын судар” нь улсын эзнийг гол болгон бичсэн сурвалж юм.

고인돌 *Ко-инъ тол* (古人-, Dolmens) Хүрлийн үеийн булшинд *Ко инъ тол*, Чулуун байгууламжит булш гэж хоёр зүйл давамгайлна. *Ко инъ тол*-ыг мегалитын соёлд хамааруулдаг бөгөөд ширээ хэлбэртэй, суурь хэлбэртэй хоёр зүйл буй. Хань мөрнөөс хойш дөрвөн том тулгуур чулуун дээр том өргөн хавтгай чулууг хөмөрч тавьсан ширээ хэлбэрийн булш элбэг байдаг бол Хань мөрнөөс урагш жижиг чулуу, хад ивсэн том чулуун булш их бий. Түүнээс гадна ямар нэг ивүүр чулуугүй, газарт шууд том чулуу тавьсан булш Солонгосын хойг даяар тархмал ажээ.Өвөр Челла мужийн Сынжү Ү сан ли-гийн *Ко инъ тол* булшнаас бийпаа хэлбэрт хүрэл хутга гарчээ. Чулуун байгууламжит булш нь газар дор тоосго хэлбэртэй чулуугаар дөрвөлжлөн хайрцаглаж барьсан булш бөгөөд заримдаа *Ко инъ тол* булштай хамт олддог ажээ.

고조선 **Ко Чосөнъ** (朝鮮, Ko-Chosŏn, ? ~ НТӨ 108 он) нь Таньгүнъ Вангөм-ийн байгуулсан улс хэмээгдэх Солонгосын хойг дээрх анхны төрт улс бөгөөд тайзу И Сөнге-гийн байгуулсан Чосөнъ улсаас ялгахын тулд Чосөнъ нэрийн урд нь эртний буюу *Ко* гэдэг утгатай үсгийг залгажээ. БНСУ-ын түүхийн салбарт *Ко Чосөнъ* улсыг хүрэл зэвсгийн үеийн соёл иргэншилтэй, одоогийн БНХАУ-ын Ляонин муж [Liaoning, 遼寧省(요녕성), 辽宁省] ба БНАСУ-ын Хванхай, Пхйөн-анъ, Хамгйөн, Канвөнъ мужийн газар нутгийг хамарсан эртний төрт улс хэмээн үздэг. “Гурван улсын нөхсөн судар” зэрэг сурвалжид тэмдэглэгдсэн Таньгүнъ-ий домгоос үзвэл НТӨ 2333 онд Таньгүнъ Вангөм *Ко Чосөнъ* улсыг байгуулсан гэдэг. *Ко Чосөнъ* нь төвхнөснийхөө дараа Еэ болон Мэг овгуудыг өөртөө дагуулж, хүчээ бэхжүүлсэн байна. Сурвалжид тэмдэглэснээс үзвэл бодитоор оршиж байсан төрт улс болох нь тодорхой авч холбогдох тэмдэглэл цөөн бөгөөд хэт ерөнхий, хийсвэр

ажээ. Ко Чосөн-ий эд өлгий хэмээн шууд нотлох баримт үгүй тул энэ улсын он дараалал, хил хязгаар, түүх, соёлын талаар ихээхэн маргаан өрнөдөг.

고흥 Кохын (高興, Goheung) 4-р зууны дунд үе буюу Пэгжэгийн 13-р ван болох Кынцого вангийн үеийн эрдэмтэн, түүхч. Пэгжэгийн анхны төрийн түүх болох “Бичиг тэмдэглэл(書記)”-ийг зохиожээ. “Бичиг тэмдэглэл”-д вангийн ургийн бичгээс гадна вангийн угсааны эрхэм дээд болохыг гэрчлэх домог түүхийг эмтхэтгэснээс гадна вангийн засаглалын зүй ёсны шинжтэй болохыг онцлон бичсэн гэж таамагладаг. Пэгжэ нь Кынцого вангийн үед гадагш газар нутгаа тэлэх бодлого явуулж, вангийн засаглалыг бэхжүүлсэн бөгөөд энэ үед “Бичиг тэмдэглэл”-ийг зохиожээ.

골품제도 Колпхүм тогтолцоо (骨品制度, Bone-rank system) Шиллагийн нийгмийн тогтолцоо.

Хүнийг ясны шинж, өөрөөр хэлбэл цусны цэвэр ариун байдлаар нь эрхэм язгуурлаг, эгэл бор хэмээн тогтоож, хэргэм цол, алба тушаалаас эхлээд өдөр тутмын ахуй амьдралд нь хүртэл онцгой эрх ямба олгодог эсвэл хязгаарладаг тогтолцоо юм. “Колпхүм”-ыг дотор нь ариун ястан, жинхэнэ ястан гэж хоёр хуваагаад түүнээс доош зургаан “түпхүм”-д хуваадаг. “Ариун ястан” нь Ким овогтноос зөвхөн вангийн угсаа залгамжлагчид л багтах хамгийн дээд зэргийн “колпхүм” байснаа хожим үгүй болжээ. Жинхэнэ ястан ч мөн Ким овогтнууд хэрнээ вангийн угсааны бус хүмүүс бөгөөд “Ариун ястан” устан үгүй болсон хойно ван угсааг залгах болжээ. Тэрчлэн эртний вангийн болон вангийн хатны угсааны Пак овогтнууд, Понъ Каяагийн вангийн угсаа болох шинэ Ким овогтнууд “жинхэнэ ястан”-д багтдаг байв. Адилхан вангийн угсааныхан хэрнээ “ариун ястан”, “жинхэнэ ястан” гэж хуваадгийн шалтгаан тодорхойгүй ч эхийн талын удмаас шалтгаалж байв. Зургаагаас дөрөвдүгээр “түпхүм” нь энгийн феодалууд ба эднээс хамгийн өндөр зиндаа нь зургадугаар “түпхүм” байлаа. Бусад нь энгийн ард, тариачны давхарга байсан бололтой.

공민왕 Конминъ ван (恭愍王, King Gongmin 1330-1374) Корёгийн 31-р ван. 1351-1374 онд ван сууринд суужээ. Монгол нэр нь Баянтөмөр. Цүнсүг вангийн хүү бөгөөд ээж нь

Мийөндөг тайхоу Хон овогт болно. 1341 онд Юаньд очиж суусан бөгөөд 1349 онд монгол хатантай гэрлэсэн нь Ногүг тэжан гүнж болно. Цүнжөн ванг сууринаас огцорсны дараа монгол гүнжийн хамтаар Корйөд ирж ван сууринд сууж, олон өөрчлөлт шинэчлэлтийг хэрэгжүүлсэн байна. 1352 онд монгол маягаар үс засах, хувцаслах зэргийг болиулж, 1356 онд монгол маягийн он тоолол, албан тушаал зэргийг хэрэглэхийг болиулжээ. Мөн Юань улсын хааны удамтай ураг холбож, эрх мэдэл атгасан Кицөл нарыг төрөөс зайлуулж, Юань улсад булаагдсан баруун хойт нутгийг дахин эрхэндээ оруулсан байна. 1368 онд Мин улсыг төрийг төвхнөсний дараа Минтэй хавсран Ляодунд бүгсэн Юань улсын үлдэгдэл хүчинг хөөн зайлуулж байв. Кон минь ван Юан улсын эсрэг гадаад бодлого явуулж, дотооддоо “Эрхэт гэр бүл”-үүдийн нөлөөг сулруулах оролдлого хийв. Кон минь ван “Зүүн хязгаарыг тохинуулах яам”-ыг устгаж, Ки цөл(기철; 奇轍) тэргүүт Юаны талыхныг зайлуулан, хуучин засагла-лын тогтолцоог сэргээв. Мөн “Сансөн-ы хэрэг эрхлэх газар” рүү зэвсэглэн дайрч, тэр хавийн нутгийг эргүүлэн авсан байна. Дараа жил нь Ялуу мөрнийг гэтэлж, “Тоннийёны хэрэг эрхлэх газар(동녕부; 東寧府)” рүү дайрчээ. Юан улс, Кон минь ванг огцруулсан гэж зарласан ба Кимюн нар Кон минь ванг хорлохыг завдсан(Хынван сүмийн хэрэг) боловч бүтэлтэй болоогүй байна. Мин улсад элч илгээж, дотно харилцах бодлого барихын хамт дотооддоо шинэчлэлт хийж, “эрхэт гэр бүл”-үүдийн хүч нөлөөг сулруулах оролдлого хийв. Үүний тулд юуны өмнө Түшмэдийн хэрэг эрхлэх газар Чөнбан(정방; 政房)-ыг татан буулгажээ. Цой овогтны дангаар ноёрхох засаглалын байгууллагын нэг болох Чөнбан нь цэргийн эрхтний ноёрхол нуран унасны дараа ч урьдын хэвээр боловсон хүчний бодлогыг атгаж, вангийн эрхийг хязгаарлан, шинэ “садайбү” нарыг дарж байв. Кон минь ван, лам Шиньдонь(신돈; 辛旽)-ыг итгэмжлэн “улсын багш” гэж өргөмжлөөд төрийн хэргийг даалгажээ. Кон минь вангийн шинэчлэлтийн бодлогыг “эрхэт гэр бүл”-үүдтэй холбоо сүлбээгүй хүн хэрэгжүүлэх боломжтой байсан тул угсаа язгуургүй энгийн нэг ламд найдахаас өөр аргагүй байжээ. Шиньдонь лам, И Гон сү(이공수; 李公遂) нарын “эрхэт гэр бүл”-ийнхнийг хөөн зайлуулж, язгуур угсаагүй хүмүүсийг төрийн албанд авчээ. Мөн ванд “Газрын хэргийг засан тохинуулах

тамгын газар” байгуулахыг зөвлөж, өөрөө шүүгч нь болоод(Кон минъ вангийн 15-р, 1366 он), эрхэт гэр бүлүүдийн булааж авсан газар болон боолчуудыг хуучин эздэд нь буцааж, тариачин гаралтай боолчуудыг боолоос чөлөөлсөн байна. Эдгээр арга хэмжээ харц барлаг, тариачдын талархлыг хүлээсэн боловч том феодалуудын эрх ашгийг хөндсөн тул Шинь донь лам удалгүй хорлогдож үхжээ. Тун удалгүй Кон минъ ван мөн хорлогдсон ба энэ нь “эрхэт гэр бүл”-үүдийн хүч нөлөөг дарж чадахуйц хэмжээнд нийгмийн шинэ дэвшилт хүчин хараахан бэхжиж чадаагүйн илрэл болно.

공부 **Үйлдвэрийн яам** (工部, Ministry of Works, Works Department) Корйөгийн 995 онд (Сөнжоны 14-р он) Төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Тан улсын тогтолцоог дуурайн, Корйөгийн үед байгуулсан зургаан яамны нэг нь үйлдвэрийн яам юм. Үйлдвэрийн яам ой мод, улсын үйлдвэрлэл, барилга байгууламж зэргийг хариуцаж байв.

공음전 **Кон-ымжонь** (功蔭田, Gongeumjeon) Төрд байгуулсан гавьяаных нь зэргээр түшмэлд олгох газрыг *кон-ымжонь* гэнэ. Энэхүү газар өмчлүүлэх журам нь Корйө улсыг мөхөхөд нэгэн шалтгаан болсон байна. Уг журмаар таваас дээш зэрэгтэй түшмэлд гавьяаны газар олгодог байжээ. Татвар татах эрхийг үе уламжлан эзэмшдэг байв. Үе дамжин татвар татах эрхтэй байв. Тийм учраас айхавтар хүнд ял гэм хийхгүй л бол гэр бүлийнх нь түүх уртсах тусам геометрийн прогрессоор газрын хэмжээ ихэсдэг байжээ. Дагаад тухайн гэр бүл нь маш их баяжиж, хөрөнгөждөг байжээ. Нэг үгээр хэлбэл *мунбөл* язгууртны эдийн засгийг баталгаажуулсан журам юм.

과거 **Орогсдын шалгалт** (科擧, Imperial Exam) Түшмэдийг төрийн албанд шалгаруулж авах зорилготой шалгалт. Утга зохиолын(제술업; 製述業), Сонгодог бичгийн(명경업; 明經業), Холимог(잡업; 雜業) гэсэн гурван төрөл байв. Утга зохиолын шалгалт нь дотроо Хятадын яруу найргийн нэг төрөл шүлэг *ши*(시; 詩), шүлгийн холбоц *лү*(부; 賦), өргөлийн магтаал *сон*(송; 頌), төрийн бодлогын талаарх санал *цайг*(책; 策) гэсэн хэдэн төрөл байжээ. Харин Сонгодог бичгийн шалгалтыг Хүнзийн суртлын ном судрын мэдлэгээр шалгадаг байсан ба энэ хоёр нь хоёулаа бичгийн түшмэдийн шалгалт юм. Корйө улсын үед Утга зохиолын шалгалтад зургаан мянган хүн

тэнцсэн байхад Сонгодог бичгийн шалгалтад тэнцэгч дөнгөж дөрвөн зуун тавин хүн байгааг үзэхэд Утга зохиолын шалгалт хамгийн гол шалгалт байжээ. Тухайн үед феодалууд Хүнзийн суртлаас илүү утга зохиолыг эрхэмлэн шимтэх болсон байна. Харин Холимог шалгалтаар нягтлан бодох, анагаах ухаан, мэргэ төлөгч, газарзүйч гэх мэт мэргэжлийн түшмэд шалгаруулж байжээ. Дээрх хоёр шалгалттай харьцуулахад доод зэргийн гэж хэлж болно. Корйё-гийн сүүлээр, бүр Кон ян ван(공양왕; 恭讓王)-гийн үед цэргийн түшмэдийн шалгалт анх бий болсон тул Корйё улсын үед ийм шалгалт байхгүй байсан гэж эрдэмтэд үздэг. Энэ үед бүх л чөлөөт хүн Орогсдын шалгалтад орох эрхтэй гэдэг журамтай байсан ч энгийн тариачдад түүнд бэлтгэх хөрөнгө мөнгө, цаг хугацаа ч байхгүй байсан нь ойлгомжтой юм. Мөн харц барлаг, лам нарын үр хүүхэд орж болохгүй байв. Шалгагч түшмэдийг *чигонгө*(지공거; 知貢舉) гэж нэрлэдэг байсан ба шалгагч түшмэлээр томилогдох нь туйлаас нэр хүндтэй хэрэг байжээ. Шалгагч түшмэд, шалгалтад тэнцэгч хоёр багш шавийн юм уу эцэг хүүгийн ч гэмээр барилдлага тогтоож, тэр нь насан турш үргэлжлэх тул ийм барилдлагатай бүлэг хүмүүс бий болжээ. Тэд өөрсдийн бүлгээр дамжуулан нийгэмд байр суурь эзэлж, алба тушаал ахих бололцоотой болсон байна.

광개토왕 Квангайто ван (廣開土王, King Gwanggaeto 391-413) Когүрйөгийн их ван. Нэрэндээ дүйхүйц өргөн уудам нутгийг эзэлсэн энэ вангийн байлдан дагуулалтыг Күгнайсөн(국내성; 國內城)-д байдаг Квангайто вангийн аварга том гэрэлт хөшөөний бичээсээс мэдэж болно. Бичээсэнд жаран дөрвөн хэрэм цайз, мянга дөрвөн зуун тосгоныг гартаа оруулсан тухай бий. Дөрвөн зүгт түүний морины туурай хүрээгүй газаргүй, тэр дундаа Хятадтай хийсэн тэмцлийн гол газар Ляодун, зүүн хойд зүгт Сүшень(숙신; 肅愼), хойт зүгт Манжуурыг дагуулж, Пайгжэг довтлон Имжинь(임진강; 臨津江) ба Хань мөрний эх хавийг эзэлж, Шиллад нэвтрэн орсон Японы цэргийг Нагдон голын сав газарт бут цохижээ. Квангайто ван “Мөнх жаргалант”(영락; 永樂) гэдэг оны чимэг хэрэглэж, Хятадтай эн тэнцүү байр сууринаас харилцаж байв. Түүнийг нас эцэслэсний хойно үйл хэргийг нь дурсан “Төрөө батжуулж, газар нутгаа өргөтгөн хил хязгаараа бэхжүүлсэн амгалан их ван” гэж хүндэтгэн дууддаг.

교정도감 Кёжсон догам Хянан сайжруулах газар (敎定都監, Gyojeongdogam) Корйөгийн

үеийн цэргийн түшмэлийн засаглалын, төрийн эрх барих дээд байгууллага. Цой Цүн хонь эсрэг хүчнийхнээ устгахын тулд байгуулсан түр газар байсан боловч яваандаа Цой овогтнуудын эрх мэдлээ хэрэгжүүлэх гол байгууллага болж хувирчээ. Цой овогтны засаглал нуран унасны дараа ч оршин тогтносон хэвээр байсан бөгөөд 1270 онд цэргийн эрхтэн Им Юү мү-г алагдсны дараа татан буугджээ.

구석기시대 Хуучин чулуун зэвсгийн үе (舊石器時代, Paleolithic) Хүн төрөлхтөн анх үүссэн үе.

Ойролцоогоор арван мянган жилийн өмнө чулуу засаж, зэвсэг хийж байсан үе.

국내성 Күгнайсөн (國內城, Guknaesong) Күгнайсөн гэдэг нь Хятадын Жилин мужийн Жиань

хотод байдаг Корйөгийн эртний хот бөгөөд тал газар тэгш дөрвөлжин хэрэм байжээ гэж таамагладаг. Хэрмийн урт ойролцоогоор 2.7 километр. Одоо байгаа чулуун хэрмийг IV зуунаас барьж эхлэн, III зуунд барьж дууссан гэж таамаглаж байна. 427 онд Пхёнъян руу нүүлгэхээс өмнө Когүрйөгийн нийслэлийн үүрэг гүйцэтгэж байжээ.

국자감 Төрийн хөвгүүдийн сургууль (國子監, Gukjagam) Корйө улсын Сөнжоны үед түшмэл

болгож, сонгон шалгаруулах боловсон хүчнийг сургахын тулд нийслэл Кайгйөнд байгуулсан дээд боловсролын байгууллага юм. Мүнъжоны үед олон төрлийн сургалт явуулдаг их сургууль болжээ. Йэ жон долоон тэнхимийг байгуулж, Хүнзийн суртлын боловсролыг хөхүүлэн дэмжиж байв. Шилдэг сурагчдыг орогсдын шалгалтаас чөлөөлөх зэргээр урамшуулж байжээ. Зөвхөн Хүнзийн суртлаар хязгаарлахгүй бусад олон зүйлийн эрдмийг заадаг байснаараа онцлогтой.

군반씨족 “Цэргийн анги” овог (軍班氏族, Military system) Корйөгийн үед вангийн нийслэлийг

хамгаалдаг байсан төвийн цэргийг хэлнэ. Үе улиран уг албыг хашдаг байсан учраас бие даасан нэгэн овог болжээ. Цэргийн газрыг ч бас өв дамжин эзэмшдэг байв.

군인전 Күнъинъжонь (軍人田, Guninjeon) Цэргийн овгийнхонд улсаас олгодог байсан газар.

군장 Хот улсын захирагч (君長, Commander) Эрт цагийн аймгаас аймгийн холбоо руу

шилжих шилжилтийн хөгжлийн шатанд буй улсын захирагчийг хэлнэ. Аймгийн ахлах вангийн дундын үе шат гэж үзвэл болно. 100 хүн захирдаг бол овгийн ахлагч, 1000 -10,000 иргэнтэй бол хот улсын захирагч, түүнээс олон тооны ард иргэд захирахыг ван гэнэ. Ко Чосөн-ий Ко инь тол чулуун булшийг харьяат иргэд нь арван мянгаас дээш язгууртанд босгодоггүй байсан нь тухайн цаг үед улсыг захирагч ван төрж гарчээ гэдгийг илтгэдэг.

궁예 Кун-е (弓裔, Gung Ye) 901 онд Хожуу Гурван улсын үед Хожуу Когүрйөг байгуулсан

ван. Хожуу Когүрйө улсыг Мажинь (마진, 摩震) гэж өөрчлөн нэрлэж, нийслэлийг

Цөрвөнх руу нүүлгэн шилжүүлж, улсын нэрийг Тхайбон 태봉(泰封) гэж сольжээ.

Куанпёнсон(廣評省) хэмээх хэд хэдэн тамгын газрыг байгуулж, төрийн тогтолцоог эмхлээд, нэг үе газар нутгийн 2/3-ыг эзэмших хэмжээнд хүчээ бэхжүүлжээ. Өөрийгөө амьд Майдар бурхан хэмээн өргөмжилж, шашин төрийг хослуулан хэмжээлшгүй эрхт засаглал тогтоохыг зорьжээ. Үүнийг нь эсэргүүцсэн төрийн эргэлт гарч, 918 оны 6-р сард Пүян гэдэг газар баригдаж алуулжээ.

권문세족 Эрхэт гэр бүл (權門勢族, Kwonmunseijok) Корйө-д Юан улсын нөлөө ихсэхийн хамт

Юаны хүчинд дулдуйдсан ноёлогч шинэ давхарга төрөн гарсныг эрхт гэр бүл гэдэг. Угсаа язгуургүй хэр нь өндөр албан тушаалд дэвшсэн монгол хэлний хэлмэрч Чо Инь гю(조인규; 趙仁規), “ынбан” буюу шонхор шувуу өсгөх албаны Юнь сү(윤수; 尹秀) ба Юаны хааны удамтай ураг холбож бүх л гэр бүлээрээ цол хэргэм олсон Ки цөл(기철; 奇轍) зэрэг хүмүүс энд багтана. Тэднээс гадна монгол гүнжийн гарын зарц болж Корйө-д ирээд алба тушаал олсон хүн, Юаны улсын “мянгатын дарга”-ын цол хэргэмээр шагнуулж цааш улам дэвшсэн хүн цөөнгүй. Мэдээжээр эртний угсаат гэр бүлүүд, цэргийн эрхтний ноёрхлын үед гарч ирсэн эрхтэн дархтнууд хэвээр байсан боловч дээрх олон янзын хүчинтэй зохицон нэгдэхээс өөр аргагүй байв.

귀주대첩 Күижү-гийн их ялалт (龜州大捷, Battle of Naengju) Хятан улс нь Корйөгийн

Хйөнъжон ванг өөрийн улсын хаанд бараалхах, Кандоны зургаан мужийг өгөхийг шаардан, хэд хэдэн удаа жижиг хэмжээний довтолгоон хийж байснаа Хйөнъжон-

гийн 9-р (1018) онд гурав дахь удаа довтолжээ. Со Бай аб(소배압; 蕭排押) жанжины удирдсан Хятаны их цэрэг олон газар Корйө-гийн цэрэгт ялагдаж, мөрдөгдөн хөөгдөж байснаа Квүйжү гэдэг газар Корйө-гийн Кан Гам цань(강감찬; 姜邯贊) жанжины цэрэгт бут цохиулжээ. Хятаны зуун мянган цэргээс хэдхэн мянга нь амь гарч, Корйө их ялалт байгуулав. Ийнхүү Хятаны эзлэн түрэмгийлах санаархал бүтэлгүй болж, Хйөнъжон-ы 10-р(1019) онд Хятан Корйө хоёр улс нь найрамдалт харилцаа тогтоожээ.

근초고왕 Кыньцого ван (近肖古王, Geunchogo of Baekje 346-375) Пэгжэгийн 13-р ван. Пэгжэд

Кыньцого вангийн үеэс феодалын тогтолцоо бүрэлдэн тогтож эхэлжээ. Тэрбээр улсаа нэгтгэн захирсан хүчирхэг ван, байлдан дагуулагч байлаа. 24-р(369) оны үед нийслэлээ өмнө зүг Игсань(익산; 益山) руу нүүлгэсэн бололтой байгаа Ма Хань-ыг харьяандаа оруулж, 26-р(371) онд Когүрйөгийн нийслэл Пхйөн ян-ыг дайлсан бөгөөд энэ дайнд Когүрйөгийн Когүгвөнъ ван(고국원왕; 故國原王) алагджээ. Ийнхүү Пайгжэ улс, одоогийн Кйөнги, Цүнцөн, Чолла гурван мужийг бүхэлд нь Канвөнъ, Хванхай хоёр мужийн зарим хэсгийг эзэлсэн өргөн уудам нутагтай болжээ. Түүгээр үл барам, Кыньцого ван, баруун талдаа Дун Жинь(동진; 東晉), (зүүн талдаа Ва(왜; 倭)-тэй холбоо тогтоож, гадаад байдлаа бэхжүүлж авсан байна. Кыньцого вангийн үеэс вангийн хүү эцгээ залгамжлах ёс тогтсон бололтой. Мөн Жинь овогт(진씨; 眞氏)-ноос хатан авдаг “Жинь овогт хатны үе” гэж түүхэнд нэрлэгдсэн үе ч энэ үеэс эхэлсэн ажээ. Кыньцого ван, эрдэмтэн мэргэдээр Пайгжэгийн түүх болох “Бичиг тэмдэглэл”(서기; 書記)-ийг бичүүлсэн нь хүчтэй вангийн засаглалт төр улсын бахархалтай холбоотой.

금나라 Алтан улс (金, Jin dynasty 1115-1234) Ар манжуурт нутагладаг Вань янь бү(왕안부; 完顔部)

аймгийн захирагч Няо я шү(조아숙; 烏訝束)-ын зүрчидийг нэгтгэн захирах гэж оролдсоор ирсэн ба түүний дүү Агуда(아골타; 阿骨打) ахынхаа зорилгыг биелүүлж

төрт улс төвхнүүлсэн нь Алтан улс юм.

금속활자 Хорголжин үсэг (金屬活字, Metal movable type) Корйөгийн Кожон вангийн үед анх хорголжин хэвлэлээр ном хэвлэж байжээ. И Гюү бо-гийн “*Тонгуг усан гүгжиб*” хэмээх номонд 1234 онд Цой Юнь-ий “*Когым санжөн емунь*” хэмээх 50 дэвтэр номыг 28 ширхэг хэвлэсэн гэснээс үзэхэд Германы Гутенберг 1450 онд хорголжин хэвлэлээр ном хэвлэснээс даруй 216 жилээр түрүүлж байна. Тэрчлэн 1377 онд Хындөг хийдэд хэвлэсэн “*Жигжи шимцэ ёжсөл*” хэмээх судар бол дэлхийн хамгийн эртний хорголжин хэвлэлийн дурсгал бөгөөд одоо Францын Парисын музэйд хадгалаатай буй. Солонгост 1392 онд Сөжөг вонь буюу Ном хэвлэх газрыг байгуулжээ. Үндсэндээ Чосөн-ий эхэн үеэс 1403 оноос хорголжин хэвлэлийн газрыг байгуулж, хэдэн түмэн хорголжин үсэг үйлдэж байв.

기자 Кижэ (奇字, Jizi) Ко Чосөн-ий хот улс аажмаар Тайдон болон Ляо мөрний сав газар тархай бутархай оршин байсан хэд хэдэн хот улсыг нэгэн том холбоонд нэгтгэсэн ба тэрхүү нэгтгэгчийг Кижэ гэдэг. Хятадын Янь(은; 殷) улс мөхөх үед, Хятадаас Жизи(기자; 箕子) гэгч ирсэн гэх домгийн ч гэмээр яриа бол дээрх хоёр нэр ижил тэмдэглээтэйн улмаас гарсан эндүүрэл бөгөөд энэ үеийн Ко Чосөн-ийг аймгийн холбооны шатанд байсан гэж эрдэмтэд үздэг.

김대문 Ким Дэ мунь (金大問, Kim Dae Mun) 7-р зууны сүүлийн хагас, 8-р зууны эхний хагаст буюу Шиллагийн Сөндөг вангийн үед амьдарч байсан түшмэл, зохиолч хүн. “*Керим жабжөнъ*”(鷄林雜傳), “Их хуврагуудын шастир”(高僧傳), “*Хваран сэги*”(花郎世紀), “*Ханьсанъги*”(漢山記) зэрэг зохиол бичсэн бөгөөд аль нь ч бидний үед уламжлан ирсэнгүй. “*Керим жабжөнъ*” нь түүх домгийн түүвэр бөгөөд “Турван улсын түүхэн тэмдэглэл”-ийг бичих үед ихээр ишлэж ашигласан гэдэг. “*Хваран сэги*” нь Шиллагийн алдартай хваран нарын намтар ажээ. Харин “*Хансанъги*” нь зохиолч бээр орон нутгийн түшмэлийн алба хашиж байхдаа харж үзсэн зүйлээ бичсэн зохиол юм.

김부식 Ким Бүшиг (金富軾, Kim Bu Sik 1075-1151 он) Шиллагийн Гурван улсыг нэгтгэх үйлсэд гавьяа

байгуулсан жанжин, Корйөгийн эхэн үеийн их сайд, бичгийн түшмэл. 1075 он (Мүнъжоны 29-р он)-д төрж, 1151 он (Ыйжоны 5-р он)-д нас баржээ. Шиллагийн Мү-йөл вангийн удам, Сүн улсын элч Муйжин хүртэл Ким Бүшиг-ийг тал бүрийн эрдэмтэй эрт эдүгэгийн түүхийг сайн мэддэг, бичгийн эрдэмдээ гаргуун хэмээн үнэлж байжээ. Шиллад дагаар орсон Каяа вангийн удам, жингол (ариун ястан) угсааны хүн байв. Арван таван настайдаа *хуаран* буюу багш болж, Когүрйө, Пэйгжэтэй хийсэн дайн болон язгууртны бослого үймээнийг дарахад гавьяа байгуулан, нэр хүнд нь өсжээ. Тэрбээр Юнь Өн-й, Хань Юүчүн нарыг тушаалаас хэдэнтээ бууруулсны эцэст улс төрийн өшөө авах вий гэдгээс эмээн гурван ч удаа албанаас чөлөөлөгдөх өргөх бичиг барьсны эцэст үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөж байжээ. Инъжон вангийн зарлигаар 『Гурван улсын түүхэн тэмдэглэл』 хэмээх 50 боть ном бичжээ. Түүний дүүтэй гэрлэсэн Ким Цүнъ Цү, Тхайзун Мү йөл вангаар өргөмжлөгдөхөд, Ким Юүшинъ-ий улс төрд эзлэх байр суурь улам нэмэгджээ. 660 оны тэргүүн сард *сансэдын* буюу язгууртны хурлын тэргүүн болжээ.

남반 *Намбань* (南班, Namban) Корйөгийн үед вангийн ордны харуул хамгаалалт болон ванд үйлчлэх, зарлиг тушаалыг дамжуулах, зэвсэг хэрэглэл зэргийг хариуцан ажилладаг түшмэл. Хятадын түшмэлийн тогтолцооноос үүдэлтэй. Ляо улсын үед бичиг цэргийн түшмэд баруун зүүн жигүүрт хуваагдан суудаг, урд жигүүрт намбань түшмэд суудаг байснаас өмнөд анги буюу намбань гэж нэрлэжээ. Өөрөөр бас дотоод түшмэл гэж нэрлэдэг.

남북국 시대 Ар өвөр улсын үе (南北國 時代, Northern and Southern States period) Нэгдсэн Шилла ба Бохай улсын үе. Гурван улсыг нэгтгэснээр Шиллагийн газар нутаг, хүн ам ихсэн томорч, эдийн засаг ч гэсэн үсрэнгүй хөгжив. Гурван улсыг нэгтгэх явцад нэг хэсэг хоорондоо байлдсан Шилла ба Тан улс нь найрамдаж, хоёр улсын хооронд худалдаачид, бүддийн лам, Хүнзийн сурталтнууд зорчих болжээ. Худалдаа идэвхтэй хийж, Шилла нь Тан улсад алт мөнгөн эдлэл, хүн орхоодой зэргийг худалдаж, ном судар, ваар сав, торго дурдан, гар урлалын бүтээгдэхүүн худалдаж авдаг байжээ. Бас торгоны зам болон далай тэнгисээр зорчих болсноор Шиллад Арабын худалдаачид ирж, худалдаа хийдэг байжээ. Шиллагийн гол боомт нь Улсаны боомт, Танхан балгас байлаа. (Кйөнги мужийн Хуасон хот) Эдгээр боомтоор Араб болон Зүүн өмнөд Азитай худалдаа хийх болов. IX зууны эхээр Шиллагийн Чан Бого жанжин Цөнхай хуаранг байгуулаад, далайн дээрэмчдийг хөөн зайлуулахын зэрэгцээ худалдааны гол боомт

болж байжээ. Хятад, Японтой худалдаа хийдэг байжээ. Когүрийөг мөхсөний дараа Тангийн эсрэг когүрийөчүүдийн тэмцэл үргэлжилжээ. 698 онд Тэй Жо-йөн тэргүүтэй когүрийөчүүд мохайчуудыг нэгтгэн, Манжуурын Жилин мужид Бохай улсыг төвхнүүлжээ. Бохай байгуулагдсанаар Ар Өвөр улсын үе эхэлнэ. Бохай газар нутгаа тэлж, Когүрийөгийн эртний газар нутгийг бараг бүгдийг эзэлжээ. Мүнъ вангийн үед хойд Манжуурыг эзэлсэн ба 755 онд нийслэлээ нүүлгэжээ. Бохай нь өөрсдийгөө Когүрийөгийн залгамж халаа улс гэж бахархдаг ба Япон руу илгээсэн албан бичигтээ өөрийн улсын ванг Корйө ван гэж тэмдэглэжээ. Бохай нэг хэсэг цэцэглэн хөгжсөн боловч Хятангийн довтлогоо болон Пэйгду галт уулын дэлбэрэлтээс болж 926 онд мөхсөн байна.

남북조시대 Ар, өвөр ханлиг улсын үе (南北朝時代, Northern and Southern dynasties) Хятадын төрт улсуудын түүхэн үечлэлийн нэг үе.

남송 Өмнөд Сүн улс (南宋, Southern song 1127-1279) Хятадын эртний төрт улс. Тан улс унасны дараа 10-р зууны сүүлчээр Сүн улс түүхийн тавцнаа гарч гурван зууны турш оршижээ. Сүн улс нийслэлээ өмнөдийн Ханжоу хот руу нүүлгэн суурьшинаас хойш Өмнөд Сүн гэгдэх болжээ. Монголчуудын байлдан дагуулалд өртөх хүртлээ Өмнөд Сүн улс амар жимэр хөгжиж байв. Сүн улс нь хүчирхэг улс байгаагүй ч гэлээ газар тариалан, технологи, аж үйлдвэр худалдаагаа гайхалтай хөгжүүлж чадсан юм. Эдийн засгийн хөгжил нь Тан улсын үеэс эхлэсэн бөгөөд Сүнгийн үед үр дүн нь тодорхой харагдаж байлаа.

내시 Ордны тайган (內侍, Eunuch) Корйө болон Чосонь-ий үед ордны дотоод хэргийг хариуцдаг чухал албан тушаал байжээ. Солонгосын түүхэнд ордны тайганы тухай анхны мэдээ “Гурван улсын түүхэн тэмдэглэл”-ийн Шиллагийн “Уг тэмдэглэл”-д гардаг ажээ.

내장전 Нэжанжёнъ (內莊田, Naejangjeon) Корйөгийн үеийн вангийн ордны эзэмшил газар. Вангийн угсааныхны хувийн эзэмшлийн газар бөгөөд яам, тамгын албан зардлыг нөхөх зориулалттай.

노비안검법 Боолоос чөлөөлөх хууль (奴婢按檢法, Novi blepharoptosis) Корйөгийн Кванжон-ы (956) үед нутгийн эрхэтнүүдийн хүч нөлөөг бууруулж, вангийн засаглалыг бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн хууль. Чөлөөт иргэн байснаа боол болсон

хүнийг боолоос чөлөөлжээ. Тухайн үед нутгийн эрхэтнүүд нь Хожуу Гурван улсын үймээн самуунт үеийг ашиглан дайны олзлогсад, өр ширээ төлж чадаагүй тариачид төдийгүй зарим үед чөлөөт тариачдыг хүртэл боолоо болгож, ихэд хүчирхэгжсэн нь эргээд вант засаглалыг ганхуулах хүчин зүйл болсон тул хэрэгжүүлсэн арга хэмжээ юм.

노자 Лаоз, Лао-цзы, Лао-зы (老子, Lao Tzu) Эртний Хятадын Хавар, Намар улсын үеийн их сэтгэгч, гүн ухаантан. Лаоз хорвоо ертөнцийн юмс үзэгдлийг “нам тайван ажиглахуй”, “нарийн чанд ажиглахуй” хэмээсэн аршийн ёсны диян бясалгал үйлдэж, Даогийн ёсонд суралцах номлолыг анх түрүү дэвшүүлсэн ажээ. Лаозын гүн ухааны сэтгэлгээ нь Хятадын төдийгүй нийт хүн төрөлхтний соёл сэтгэлгээний хөгжилд гүн гүнзгий үр нөлөө үзүүлсэн хэмээн үнэлэгддэг. (М. Чимэдцэеэ, Бидний мэдэх хийгээд эс мэдэх Хятад орон: сэтгэлгээ соёл, 95-96 –р тал)

녹읍 Идэх хот (祿)邑, Nok-eup) Идэх хот гэдэг нь Шиллагийн сүүл үе, Корйөгийн эхэн үед тодорхой хэмжээний газар нутгаас татвар татахыг түшмэдэд зөвшөөрсөн бүс нутгийг хэлнэ. Шилла ойр хавийн газар нутгийг нэгтгэх явцдаа тухайн нутгийн эрхтэн дархтнуудыг захиргаандаа оруулахын тулд гаргасан журам юм. Корйөгийн эхэн үед төр улсыг төвхнүүлэхэд гавьяа байгуулсан сайд болон дагаж орсон хэрмийн эзэд зэрэг цөөн хүнийг эдийн засгийн хувьд урамшуулах зорилгоор идэх хот олгодог байжээ.

논어 Шүүмжлэл өгүүлэл (論語, The analects) Хүнзийн суртал гүн ухааны сэтгэлгээний гол дурсгал, “Дөрвөн ном, таван бичиг”-ийн нэг нь “Шүүмжлэл өгүүлэл” юм. Хүнз болон түүний шавь нарын хэлсэн сургаалыг бичсэн ном юм. Күнзийг нас барсны дараа шавь нар нь Хүнзийн сургаалыг ном болгон гаргажээ. Олон хүн “Шүүмжлэл өгүүлэл”-ийг Хүнзийн зохиол гэж ойлгодог боловч Хүнз нэг ч ном бичээгүй. Шүүмжлэл өгүүлэл нь голдуу асууж хариулах, дүгнэх хэлбэрээр бичигдсэн 20 бүлэг, 482 хуудас, 600 орчим өгүүлбэртэй.

눌지마립간 Нүлжи марибганъ (訥祗麻立干, Nulji Maripgan 417-458) Гурван улсын үеийн Шиллагийн 19-р ван. Нэмүл марибганъ-ы хүү. Когүрйөд барьцааны хүн болж

очсон Шилсөн гэгч нутаг буцаж ирээд *марибгань* болсоныхоо дараа Когүрйөг ашиглан Нэмүл *марибгань*-ы хүү Нүлжиг хорлохоор завдсан боловч эсрэгээрээ Когүрйөгийн тусламжтайгаар Нүлжи нь төрийн эргэлт хийж Шилсөн-ыг хороогоод *марибгань* болжээ. Тэрбээр Когүрйөгийн урагш хил хязгаараа тэлэх оролдлогын эсрэг арга хэмжээ болгон Пэгжэтэй холбоотон болсон байна. Дотоодын зөрчил тэмцлээс сэргийлэхийн тулд ван сууринд хүү нь эцгээ залгамжлах ёсыг хэвшил болгож, усан сан байгуулах, иргэний орон сууцыг сайжруулах зэрэг арга хэмжээ авч байжээ.

다루가치 Даргач (達魯花赤, Darughachi) Монгол хэлний “дарах” гэдэг үгнээс үүссэн.

Монголын эзэнт гүрэн болон Юань улсын үед эзлэгдсэн газар нутгийг хянан захируулахаар суулгасан түшмэлийг хэлнэ. Даргач нь хот суурин, бүс нутгийг захирахаас гадна улс төрд чухал хэрэгт оролцох, нөлөөлөх эрх мэдэлтэй байжээ. Даргач тавьдаг журам Жүн Юань-ий уламжлалт төвлөрсөн түшмэл тогтолцоотой нийлээд удирдлагын өвөрмөц арга хэлбэр болон хөгжжээ.

다보탑 Олон эрдэнийн суварга (多寶塔, Dabotap, Dabo Pagoda) Кйөнжү-гийн Пүлгүг хийдийн

дотор байрлах Шилла улсын үед барьсан чулуун суварга. 1962 оны 12-р сарын 20-ны өдөр БНСУ-ын “Үндэсний соёлын өв”-ийн 20 дугаар үнэт зүйлээр бүртгэжээ. Өндөр нь 10,4 метр, барилгын суурийн өргөн 4,4 метр. Пүлгүг хийдийн гол дуганы урд, Бурхан багшийн суваргатай зэрэгцэн оршдог. 2008 оны 12-р сараас эхлэн бүтэн жил сэргээн засварласан байна. Өмнөд Солонгосын аравтын зоосон мөнгөн дээр “Олон эрдэнийн суварга”-ын зураг байдаг.

단군 Таньгүн, Таньгүн вангөм, Дангүн (檀君, Dangun, Tangun, 단군왕검 檀君王儉, Dangun

Wanggeom) Үлгэр домогт Солонгос үндэсний өвөг дээдэс, Ко Чосөн-ийг үндэслэгч хэмээжээ. “Турван улсын нөхсөн судар”, “Эзэд хаадын магтуу”, “Сэжоны магад үнэн тэмдэглэл”, “Зүүн гүрний нэвтэрхий толь” зэрэг Солонгосын түүхийн сурвалж бичигт Таньгүн-ийг Солонгос үндэстний өвөг дээдэс хэмээжээ. Өнөөдөр Бүгд Найрамдах Солонгос улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос улс аль аль нь Таньгүн-ийг өвөг дээдсээ хэмээн хүлээн зөвшөөрч байна. Таньгүн хэмээх хүн үнэхээр байсан үгүй талаар судлаачдын санал зөрөөтэй. Өмнөд Солонгост бол

ихэнх эрдэмтэд Таньгүн-ийг домгийн баатар, Ко Чосөн-ий улс төрийн удирдагчийг заасан нэр гэж үздэг.

단군신화 Таньгүн-ий домог, Дангүн домог (檀君神話, The Legend of Dangun) Солонгосын улс

үүслийн домог. Ко Чосөн-ий үүсэл гаралтай холбоотой домог. Хятадын “Вэй улсын бичиг(위서; 魏書)”, “Эртний тэмдэглэл(고기; 古記)” зэрэг хэдэн сурвалжид байна. “Эртний тэмдэглэл”-ээс “Гурван улсын нөхсөн түүх(삼국유사; 三國遺史)”-д эшлэн авсан домогт өгүүлэхдээ: Эрт цагт тэнгэрийн бурхан Хвань инь3(환인; 桓因) гурван хүүтэй байжээ. Тэдний нэг Хвань-үн тэнгэрийн доорхи газрыг эзэлж, хүний ертөнцийг аврах хүсэлтэй болохыг эцэг нь ухаж мэдээд, хорвоо ертөнцийг тольдон харж, тэртээ зүүн зүг дэх Тайбэг уулыг өлзийтэй сайхан газар гэж хүүдээ “цөнбү-инь”(천부인; 天符印) гурвыг өгч, газарт буулгав. Хвань үг гурван мянган албатаа дагуулан Тэбэг уулын орой дахь Шиньдань(신단수; 神檀樹) модны дор “бурхны хот”-оо байгуулжээ. Тийнхүү “салхины бурхан, борооны бурхан, үүлний бурхан”-ыг захирч, үр тариа, амь нас, өвчин зовлон, ял шийтгэл, буян нүгэл гэхчилэн хүний гурван зуун жаран төрлийн үйлийг удирдаж, хүн төрөлхтнийг захирсан гэнэ. Энэ үед бар, баавгай хоёр Хвань үн-д ирж мөргөн, хүн болгож өгөхийг гуйхад нь, сармис идэж, нарны гэрэл үзэхгүй газар зуун хоног хатуужиж чадвал хүн болно гэж айлдав. Барс тэсч чадсангүй, харин баавгай хорин нэг хоногийн дараа бүсгүй хүний биед хувилав. Бүсгүй болж хувилаад, үр хүүхэд хайрлахыг гуйн Шиньдань модонд мөргөж байхыг Хвань үн үзээд, хэсэг зуур эр хүний биед хувиан, түүнтэй хуримлажээ. Ийнхүү төрсөн хүүхэд нь Таньгүн Вангөм(단군왕검; 檀君王儉) юм. Тэрээр Пхён-ян балгасанд улсаа байгуулж, Чосөн гэж нэрлэжээ. Ко Чосөн-ийг үндэслэсэн Таньгүн Вангөм нь нарны бурхан Хуань инь-ий ач болох нь сүр хүч, эрх дархын бэлгэдэл мэт.

단군조선 Таньгүн Чосон (檀君朝鮮, Dangun Joseon) Ко Чосөн-ий анхдугаар угсаа

залгамжилсан вант улс юм. Ир йөн ламын бичсэн “Гурван улсын нөхсөн судар”-т энэ улсын тухай тэмдэглэжээ. Чосөн-ий үеийн “Зүүн гүрний нэвтэрхий толь”-ос үзвэл НТӨ 2333 онд байгуулагдсан гэдэг боловч энэ нь зөвхөн домгийн

шинжтэй бөгөөд Өмнөд Солонгосын эрдэмтэд улс байгуулагдсан он цагийн талаар өөр өөр санал дэвшүүлж байна. НТӨ 194 онд сүүлчийн ван болох Жүнъ ван Вэйманьд шахагдан, Махань руу зугтсанаар энэ улс мөхжээ.

당 Тан (唐, Tang) Сүй улсын дараа бий болсон Хятадын хүчирхэг улсуудын нэг. 618 онд Гао Зу

Тан улсыг үндэслэн байгуулжээ. Тан улс 289 жил оршин тогтнож, улс төвхнөснөөс хойш мөхөх хүртэл 20 хуанди төр барьжээ. Тан улс 907 онд Ай хуандигийн үед мөхжээ. Хил хязгаар тэлсэн өөрчлөлтийг үл тооцвол Сүй улсын уламжлалын дагуу төрийн тогтолцоо, соёл нь хөгжсөн байна. Нийслэл нь Шиань, хоёр дахь том хот нь эрт, дундад зууны үед Хятадын хоёр дахь том хот байсан Луоян хот байв. Шиань 1 сая хүн амтай, хүнсний дутагдалтай байжээ. Тан улсын үед Хятадын уламжлалт соёлыг дэвшилтэт технологиор хөгжүүлж, гадагшаа идэвхтэй харилцаж байсан. Олон үндэстнээс бүрдсэн олон улсын шинжтэй хүчирхэг гүрэн байв. Хойд талаараа Уйгар, Төвдтэй урагшаа Вьетнамтай харилцдаг байв. Харийн соёл, харийнхны оршихуйг хүлээн зөвшөөрсөн, олон улстай хамгийн өргөн харилцсан улс гэж судлаачид үнэлдэг. Солонгосын түүхэнд Пэйгжэ болон Когүрйөгийн довтолгооны улмаас хүнд байдалд ороод байсан Шиллад туслан, Гурван улсыг нэгтгэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Бас Пэйгжэг мөхсөн хойно Япон нь Тан улс руу илч илгээж, Тангийн дэвшилтэт соёлыг хүлээн авч, засаглалын тогтолцоогоо сайжруулсан байна. Энэ мэтээр Зүүн Азийн олон улсад маш их нөлөөтэй байжээ. Солонгосын хойг бол газарзүйн байрлалын хувьд Хятадын нөлөө их байх нь дамжиггүй, тэр дундаа Хятадын төрт улсууд дундаас Тан улс нь Солонгост хамгийн ихээр нөлөөлсөн байна. Түүнээс хойш Зүүн Азид мянга гаруй жилийн турш үргэлжилсэн Хятад төвт ертөнцийг үзэх үзлийг бүрэн бэхжүүлсэн орон юм. Хожим Ань Луй шань-ий бослогоос хойш ард түмний тэмцэл ширүүсэж, уруудах замдаа оржээ.

대가 Тайга (大加, Tribal chief) Корйөгийн үеийн таван аймгийн удирдагчийг хэлнэ. Пү ван

(副王), Пөнъ ван (藩王) –тай тэнцэх тушаал юм. Когүрйөгийн гол хүч төвлөрч байсан Йөнно, Чөлно, Сүнъно, Кваньно, Керү зэрэг таван аймгийн удирдагчийг тайга гэдэг байв. Когүрйөгийн эхэн үеийн ванг аймгийн холбооны удирдагч гэж үздэг бөгөөд ванг язгууртны хурлаас сонгож, угсаа залгамжилдаг байжээ. Эхлээд

Сүнъно аймаг, дараа Керү аймгаас аймгийн удирдагчаа угсаа залгамжлан суулгадаг байв.

대가야 Тэ Каяа (大伽倻, Dae Gaya) 1-р зуунаас 6-р зууныг хүртэл ар Кйөнсан мужийн Корйөн нутагт оршин тогтносон Зургаан Каяагийн нэг. Анхандаа Палло улс(半路國), Панпа улс(伴波國) гэдэг нэртэй байснаа 5-р зууны сүүлийн хагасаас хойш Тэ Каяа гэж нэрлэх болжээ.

대마도 Цүшима арал (對馬島, Tsushima Island) Японы Нагасаки мужад харьяалагдах арал. Өмнөд Солонгост Цүшима аралтай дүйх том арал гэвэл Чэжү арлаас өөр байхгүй. Цүшима арал нь далайн түвшнээс 400 метрт оршдог, тэгш тал багатай, уулархаг нутаг учраас газар тариалан эрхлэх, байшин барих ашигтай талбай багатай.

대장경 Их хөлгөн судар (大藏經, Tripitaka) Буддийн шашны их хөлгөн судар. Бурхан багш Зүүн хойд Энэтхэгийн эртний магада хэлээр сургаалаа айлдаж байсан бөгөөд тухайн хэл дээр бичсэн судар өнөө үед хадгалагдаж үлдээгүй. Харин Баруун хойд Энэтхэгийн пали хэлээр орчуулагдсан судар Шриланка улсаас Зүүн Өмнөд Азид уламжлагдан үлджээ. Эдгээр судрыг санскрит хэлээр хөрвүүлсэн эх нь Төв Ази, Баруун Хойд Азиар дамжин Хятадад хүрч, Хятад хэлнээс Төвд хэл дээр орчуулагджээ. Их хөлгөн судрын онцлог нь дотроо ёс суртахууны, судрын, гүн ухааны сав аймаг гэсэн гурван савд хуваагдах бөгөөд Энэтхэг, Хятадын эрдэмтдийн бичсэн буддийн шашны онол сургаалаас гадна түүх, гүн ухаан, хэл шинжлэл, утга зохиол, яруу найргийн чиглэлээр бичсэн бүтээлүүд ордог.

대조영 Тэй Жо-йөн, Тэ Чжо ён, Тэ Жу-ён (大祚榮, Dae Joyeong ?-719) Бохай улсыг үндэслэгч.

Когүрйөгийн жанжины гэр бүлээс гаралтай. Ляо мөрний баруун талд Йөнжүд нутаглаж ирсэн когүрйөчүүд, зүрчид, хятан үндэстэнтэй нэгдэн, Тан улсын ноёрхлоос мултран гарч, Манжуурын зүүн хойт хэсэг рүү нүүн суурьшжээ. Тийнхүү Сунгари мөрний сав газар өргөн уудам тал нутагт(эртний Пүйө аймгийн нутагт) нэгэн шинэ улс бий болсон нь Бохай юм. Когүрйөг мөхөх үеэр Йөнжү руу хөөгдсөн Тэй Жо-йөн хятан нарын бослогыг ашиглан, албат харьяатуудаа дагуулан зүүн зүгт Тонмо уулын ойролцоо ирж суурьшин, өөрийгөө Жинь улсын ванд

өргөмжлөв(698). Бохайн үндсэн иргэд нь когүрйөчүүд болон мохай үндэстнүүд юм. Манжуурт Когүрйөгийн харьяанд байсан зүрчидүүд Бохай улс бий болохын хамт түүнд даган оржээ. Үндсэндээ эгэл ардын ихэнх нь мохайчууд байж, ноёлогч давхаргыг когүрйөчүүд бүрдүүлж байсан гэж үзэж болно. Японд илгээсэн жуух бичигтээ өөрийн улсыг Корйө улс гэж нэрлэсэн нь Когүрйөгийн залгамж халаа гэж үзсэн, улсаа дахин сэргээх гэсэн хүсэл эрмэлзлийн илрэл гэлтэй.

도교 Даоизм, Бумбын шашин (道敎, Taoism) Эртний Хятадын ардын шашин. Эртний хятадын домогт удирдагч, гүн ухаантан Лао-зи нь Даоизмыг үндэслэгч юм.

도덕경 Жам ёсны судар (道德經, Tao Te Ching) Хятадын гүн ухаантан Лаозын бүтээл. Жоу улс доройтоход 80 гаруй настай байсан Лаоз нутгаа орхин үл мэдэгдэх газар луу явжээ. Ингэхдээ хотоос гарах хэрмийн хаалган дээр үүд сахигч түшмэдтэй тааран “Жам ёсны судар”-аа үлдээсэн гэх домог буй. Энэ хосгүй бүтээл нь Лаозын сэтгэлгээг судлан таних гол хэрэглэгдэхүүн болж, бидний үед хүрч иржээ. Дао жин, Дө жин гэх дээд, доод хоёр дэвтрээс бүрдэнэ. Түүний сургаалын гол тулгуур нь бүх юм хувирч өөрчлөгдөвч тэдгээрийг зохицуулагч хууль хувирч өөрчлөгдөшгүй мөнхийн юм гэсэн үзэл ажээ.

도방 Торгон цэргийн анги (都房, Dobang, Tobang) Корйөгийн дунд үеийн цэргийн түшмэдийн засаглалын эрх баригч Кйөн Тэй сын өөрийн амь биеийг хамгаалахаар зохион байгуулсан хувийн цэрэг. Кйөн Тэй сынг үхсэний хойно тарж бутарсан боловч Цой Цүн хөнъ-ны засаглалын үед дахин сэргэжээ. Цэргийн түшмэлийн засаглалыг бэхжүүлэх, эрх баригчийн амь биеийг хамгаалах үүрэгтэй байлаа. Вангийн засаглалыг дарангуйлсан эрх мэдэлтэй байсан цэргийн эрхтнүүдийн зөвшөөрсөн үндсэн дээр цэрэг хөдлөх боломжтой байсан тул хувийн цэрэг гэж үзэх нь зүйтэй юм.

도선 Досөнъ (道洗, Doseon) Досөнъ нь Ар Өвөр улсын үеийн Нэгдсэн Шиллагийн хувраг бөгөөд “Тосөнъ тиги”, “Сон-аг мйөнданги”, “Тосөнъ дабсанъги” зэрэг зохиолыг бичжээ. 827(Хындөг вангийн 2-р) онд төрсөн бөгөөд 898(Хёгон вангийн 2-р) онд нас баржээ. Йөн-ам нутгаас гаралтай хүн бөгөөд 15 настайдаад сахил хүртэн хувраг болжээ. Эрдэмтэй хувраг гэдгээрээ алдартай байсан ч Фэншуйн ухааныг Шиллад нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэснээрээ

илүү алдартай. Тан улсад очиж, Фэншуйн ухаанд суралцсан гэдэг. Сон-аг нутагт шинэ вант улс Корйөг үндэслэх Тайзу төрнө хэмээн урьдчилж хэлснээрээ алдаршиж, Тайзу тэргүүтэй Корйөгийн вангууд түүнийг ихэд хүндлэн шүтэж биширдэг байв. Ялангуяа Тайзу “Хойч үедээ үлдээх арван сургамж”-даа “Тосөн-ий фэншуйн сургаальд үндэслэн сүм хийдийг барих хэрэгтэй, зоргоор сүм хийд босгож болохгүй” хэмээн дурдсан байна.

도첩제 Ламын гэрчилгээний журам (度牒制, Docheorje, Doseungje) Лам гэдгээ гэрчлэх

бичгийг биедээ авч явах журам юм. Хятадын Ар, өвөр Ханлиг улсын үед анх энэ журмыг гаргажээ. Тан улсын үед улам боловсронгуй болгожээ. Хятадад лам хүнийг алба гувчуураас чөлөөлдөг тул олноороо лам болохоос сэргийлж, уг журмыг гаргажээ. Шиллагийн 27-р ван болох Сөнъдөг хатан вангийн 5-р онд хатны өвчнийг эдгээхийн тулд Хванрён хийдэд их хурал хурж, зуун хүнд ламын гэрчилгээ олгосон тухай тэмдэглэл бий. Солонгост Корйөгийн үеэс уг журмыг үндсэндээ хэрэгжүүлэх болсон бөгөөд Чосөн-ий Тайзугийн үед улам чангатгажээ. Чосөн нь Буддийн шашныг дарж, Хүнзийн суртлыг дэмжихийг төрийн бодлогоо болгосон тул уг журмыг хэрэгжүүлснээр ламын тоог цөөлж чадсан байна. Хожим Чосөн Сөнжоны үед уг журмыг бүрмөсөн цуцалжээ.

도평의사사 То пхён ыи са са (都評議使事, Dopyeonguisasa) Корйөгийн сүүл үед төрийн эрхийг

барих дээд байгууллага. Бичиг, цэргийн өндөр дээд цол хэргэмтэй түшмэдийн хамт төрийн хэргийг хэлэлцэх дээд байгууллага байв. Анх арван хоёр хүний бүрэлдэхүүнтэй байсан уг зөвлөлийн хуралд оролцогсдын тоо сүүл рүүгээ далаасная болж өссөн байна.

돌궐 Түрэг (突厥, Turk) Төв Азид байгуулсан түрэг үндэстний анхны хаант улс юм. Төв Азийн

Амударьяа мөрөн, Каспин тэнгисийн баруун хойд тал нутагт хүчирхэгжин мандсан Түрэг нь Төв Азиас зүүн тийш хүрээгээ тэлж, Зүүн Хойд Азийн гол нутаг дахь Жужаныг мөхөөгөөд, Зүүн Хойд Азийн умард нутагт ноёрхлоо тогтоожээ. Түүнээс гадна Енисей мөрний сав газрын дээд хэсгийг нөлөөндөө оруулжээ.

동관진유적 Тонгванъжинь-ий дурсгалт газар (潼關鎮遺蹟, Dongguanjin Ruins) 1960-аад оныг

хүртэл Солонгосын хойгоос хуучин чулуун зэвсгийн үеийн олдвор бараг олдоогүй

байв. 1933 онд Хойт Солонгосын Ар Хамгйөн муж(*Хамбүг*; 함북; 咸北)-ийн Чонсөн(*중성*; 鍾城)-ий Тонгванъжинъ-ий олдворыг эс тооцвол өөр дурсгал байсангүй. Тэндээс арслан заан, хирс зэрэг сүүн тэжээлт амьтны чулуужсан яс, хэд хэдэн чулуун зэвсэг, ясаар хийсэн зэвсэг олджээ. Зарим эрдэмтэн үүнийг хуучин чулууны үеийнх биш, ойр хавиас нь олдсон бусад шинэ чулуун зэвсгийн үеийн дурсгалаас онц ялгарах юмгүй гэж үздэг. Гэвч Тонгванъжинъ-ээс холгүй, Түмэн мөрний хойхно орших Жилинь муж(*길림성*; 吉林省), Анъдо(*안도*; 安圖)-гийн Сөгмүнъсанъ цонъ(*석문산촌*; 石文産村)-ы агуйн дурсгалууд нь Тонгванъ жинъ-ийх ч мөн хуучин чулуун зэвсгийн дурсгал болохыг батлана.

동녕부 Тоннийөн-ий хэрэг эрхлэх газар (東寧府, Dongning) Корйөгийн сүүл үед Юань улсын зүгээс Сөгийөнд байгуулсан албан газар. 1269 онд Баруун хойт нутгийн цэргийн хуарангийн Цой Танъ, Ханъ шинъ нар Вөнжон ванг сууринаас нь огцруулсан Им Йөнъ нарыг зайлуулах нэрийдлээр умардын 54 хот, Жаби нуруунаас хойшхи 6 хот Юаньд дагаж оржээ. Тэгмэгц Юаний зүгээс Жаби нуруунаас хойшхи газар нутгийг мэдэлдээ авч, тэнд Тоннийөний хэрэг эрхлэх газрыг байгуулаад Цой танъ-ыг ерөнхий захирагчаар томилжээ. Вөнъжон уг газар нутгийг эргүүлж өгөхийг шаардсан боловч хүлээж аваагүй бөгөөд 1290 оноос хойш Корйөгийн зүгээс удаа дараалан шаардсаны эцэст Сөгийөн тэргүүтэй баруун хойт нутгийн зарим газрыг Корйөгийн эзэмшилд шилжүүлжээ.

동맹 Тонмайн (東盟, Dong'maeng) Когүрйөгийн ургацын талархлын баяр болохын зэрэгцээ тэнгэр тахих ёслол. “Вэй улсын ойллого”-ын “Дорнын бүдүүлгүүдийн шастир”-ын “Ханъ улсын шастир”-т “5-р сард үрслүүлэг хийсний дараа болон 10-р сард тариалангийн ажлыг дуусгасны дараа сүнс сүлдэнд тахил өргөдөг” хэмээн тэмдэглэжээ. *Тонмайн* нь хожим Корйөгийн *палгуанъ хой* хэмээн бүддийн шашны ёслолын үндэс болжээ. “Сүн улсын түүх(宋史)” (1345) -нд “Улсын зүүн зүгт агуй байх бөгөөд 10-р сарын 15-нд тахил өргөнө. Үүнийг *палгуанъ хой* хэмээмүй. Өргөнөөр ёслон тэмдэглэж, ван болон хатад өндөрт гарч, дуу хөгжим үүсгэн найрлана(國東有穴 號歲神 常以十月望日迎祭 謂之八關齋 禮儀甚盛 王與妃嬪登樓大張樂宴飲).” гэжээ.

동명왕 Тонмйөн ван (東明王, King Dongmyeong) НТӨ58-НТӨ19 он. Нэр нь Чүмон(朱蒙).

Когүрйөгийн төрийг төвхнүүлэгч. “Гурван улсын түүхэн тэмдэглэл”-ээс үзэхэд НТӨ 37 онд Чүмон(주몽; 朱蒙)-ыг дагасан пүйөчүүд Ялуу мөрний дунд хавь, Дунга голын сав газар дах Хванъ инь(환인; 桓仁) нутагт суурьшиснаар Когүрйө улс төвхнөсөн ажээ. Умраас нүүж ирсэн ноёлогчид, уугуул нутгийнхныг захиргаандаа оруулан төр улсын үндсийг тавьжээ. Домгоос үзвэл, хойт Пүйөд тэнгэрийн хааны хүү гэж биеэ нэрийдсэн Хэмусү, лусын охин Юхва хоёрын дундаас Жүмон төрсөн байна. ЮхВаг бүсгүй хүний журмыг үл сахисан хэмээн лусад хөөгдөж, эзгүй газар явахад нь Пүйөгийн Кымва ван ордондоо дагуулан аваачжээ. Удалгүй Юхва бүсгүй нэгэн том өндөг төрүүлж, өндөгнөөс Жүмон хүү гарчээ. Жүмон морь сургахдаа гарамгай, нум сумаар мэргэн харвадаг аж. Гэвч эх хүү хоёр Пүйөгийн вангийн ордонд гадуурхагдах болсон тул эхийн хүслээр өмнө зүг явж, загас, өчүүхэн яст мэлхийнүүдээр туслуулан, мөрөн гаталж, Чолбөнд улсаа байгуулжээ. НТӨ 36 онд Пирю улсын Сонян ван дагаж орсон ба НТӨ 34 онд хот хэрэм барьж байгуулжээ. НТӨ 33 онд Хэнинъ улсыг байлдан дагуулж, НТӨ 28 онд умард Огжо-г мөхөөжээ. НТӨ 24 онд Зүүн Пүйө-д талархлын элч илгээж байв. НТӨ 19 оны 9-р сард, дөчин настайдаа өөд болоход нь тахил тахиж, Тонмйөн ван хэмээн өргөмжилсөн ажээ.

동예 Тон-еэ (東濊, Dongye) МӨЭ 82 оны ҮІ зууны үед оршин тогтнож байсан Тон-еэ бол

Солонгосын Зүүн тэнгисийн эрэг хавиар Зүүн Огжөтэй зэрэгцэн оршиж байсан эртний аймаг улсын нэг юм. Еэ(濊) гэж бас нэрлэдэг байв. Канвөнъ мужийн хойд хэсэг Зүүн тэнгисийн эрэг хавиар төвлөн хойшоогоо Өвөр Хамгйөн мужийн Вөнъсанъ-аас урагшаа Канвөнъ мужийн Канрын болон Ар Кйөнсан муж хүртэлх нутгийг эзэлж байжээ. Баруун зүгийн Маханъ, Пэйгжэтэй тулалдаж байсан мэдээ бий. Газар тариалан эрхэлж, нэхмэл урлал хөгжиж байжээ. ҮІ зуунд Шиллагийн Жинъхын ванд дагаж орсон. Жинъхын ван Тон-еэгийн хуучин хязгаар нутагт гэрэлт хөшөө босгон, Шиллагийн газар нутаг болсныг зарлан тунхаглажээ. Одоогийн Канвөнъ мужийн зүүн хойт нутагт нутаглаж байсан эртний аймаг. Газар тариалан болон далайн загас ан агнуур эрхлэдэг байжээ. Торго болон даавуу нэхэх урлаг өндөр хөгжижээ. 10-р сард Мүцөнъ хэмээх тэнгэр тахих зан үйл хийдэг байв. Дон-еэгийн овгууд нь хил хязгаараа машид чандлан сахиж, бусдын газар нутагт

нэвтэрвэл боол, үхэр, морь зэргээр торгодог “цэгхвэ” хэмээх заншилтай байжээ. Мөн нэг овгийнхон хоорондоо гэрлэдэггүй, заавал өөр овгоос эхнэр явдаг байжээ.

동이 **Дорнын зэрлэгүүд** (東夷, Dongyi) Хятадууд эрт цагаас өөрийн улсын дорно зүгт орших

харь улс үндэстнийг нэрлэж ирсэн доромж үг. Дун-и буюу дорнын зэрлэгүүд хэмээх үгийн утга цаг хугацаа өнгөрөхийн хирээр өөрчлөгдөж иржээ. Хань улсаас өмнөх үед (Шаньдун, Чансү, Хубей) Хятадын гурван мужид амьдардаг үндэстнүүдийг нийтэд нь нэрлэдэг байв. Цаашдаа Манжуур, Солонгосын хойг, Япон зэрэг улс үндэстнийг нэрлэх үг болон хувирчээ. Одоогоор бол Хань үндэстнийг бүрдүүлж буй Пүйө, Когүрийө, Пэйгжэ, Йэмэг, Самхань болон Мохай, Сяньби, Ухуань, Вэ зэргийг дорнын зэрлэгүүд гэж нэрлэж байжээ.

마립간 **Марибгань** (麻立干, Maripgan) Шиллагийн эхэн үеийн төрийн тэргүүнийг нэрлэх цол.

Хот улсын захирагчийг залгамжлагч, ахлагч гэсэн утга бүхий “*усагым*(이사금; 泥師今)” гэдэг нэрийн оронд Марү буюу өндөрт буй тэргүүн гэсэн утгатай “марибгань” нэрээр улсын тэргүүнээ нэрлэх болжээ.

마한 **Ма Хань** (馬韓, Mahan) НТӨ 3-р зуунаас 4-р зууны үед одоогийн Кйөнги, Цүнцөн, Чёлла

мужийн нутагт оршиж байсан Гурван Хан улсын нэг нь Ма Хань юм. “Гурван улсын ойллого”-оос үзвэл тавин дөрвөн аймгийг нэгтгэсэн аймаг улс байсан бөгөөд том нь түмэн өрхөөс, бага нь хэдэн мянган өрх айлаас тогтож байжээ. Томхон аймгийн удирдагчийг шинжи(臣智), бага аймгийн удирдагчийг ыбца(邑借) гэдэг байв. Махань нь Гурван Хань-ы үед хамгийн өргөн, уудам нутгийг эзэлж байжээ. Хань мөрний сав газраас эхлэн Цүнцөн болон Чёлла мужийн нутаг дэвсгэрийг эзэлж, Могжи, Пэгжэ зэрэг тавин дөрвөн аймгийг өөртөө нэгтгэж байв. Хожим нь Пүйө зэрэг Умардаас нүүдэллэн ирсэн иргэд болох Пэгжэ нь Махань-ы бүх хүчийг нэгтгэжээ.

말갈 **Мохай** (靺鞨, Malgal) Бохайг мөхсөний дараа хятанчууд мохай нарыг нийтэд нь зүрчид

гэж нэрлэдэг байв. Мохай нь Манжуур, Солонгосын хойгт нутаглан амьдарч байсан тунгусчууд бөгөөд когүрийө нар тэднийг эзэлж, улмаар уусгажээ. Жоу улсын үед Мохайг Сушень гэж нэрлэж байв. Мохай улсын өлгий нутаг болох Сунгари

голын сав газрыг Вүжи аймаг нэг хэсэг эзлэж байжээ. Гэвч Вүжи аймгийн хүч доройтох үед мохай нар хүчирхэгжин, мохайн олон аймгууд тус тусдаа нутаглан суужээ. Түүнээс хойш Мохай Когүрйөд бүрэн эзлэгдэж, когүрйөчүүдтэй хамт Бохайг төвхнүүлэхэд том гавьяа байгуулжээ. “Турван улсын нөхсөн судар”-т I зууны үед мохай нар Шилла, Пэйгжэтэй тулалдсан тухай тэмдэглэл бий. Энэ тэмдэглэлийг үндэслэн эрдэмтэн Жөн Яг ён Мохай Еэ (Тон-Еэ)-гийн харьяанд байжээ гэж үздэг. Мохай нар одоогийн Канвөнъ мужид нутаглаж байжээ. Сунгари мөрөн, Хэй Лун Жян мөрний ойролцоо нутаглаж байсан мохай, зүрчидүүдийн ихэнх нь Ар Пхйёнанъ, Хамгйөнд суурьшсанаар хань үндэстэнд уусч, үлдсэн хэсэг нь Ялу мөрөн, Түмэн голын хойд хэсэг рүү нүүдэллэн суурьшаад Алтан улс, Чин улсыг төвхнүүлжээ.

명 Мин (明, Ming Dynasty) Мин улс 1368 оноос 1644 оны хооронд оршин тогтнож байв.

Монголчуудын байгуулсан Юань улсын эсрэг 1351 онд эхэлсэн “Улаан алчууртны бослого”-ын толгойлогчдын нэг Жу Юань Жан Мин улсыг байгуулжээ. Хүнбү болон Юнлө хуандигийн үед томоохон хэмжээний суваг, шуудуу барьж байгуулан, газар тариаланг хөгжүүлсэн бол Ванли болон Хуйзун нарын мунхаг хуандигийн үед доройтож эхэлжээ. Эцэст Ли Зиченээр удирдуулсан тариачны бослого, Хожуу Алтан улсын удаагийн довтолгооны улмаас хүч нь суларчээ. Мин улсын хуанди албат түшмэдийн хамтаар өмнө зүгт ухарч, Өвөр Мин улсыг байгуулсан боловч эрх мэдлийн төлөөх ужиг тэмцлийн улмаас 1662 онд Чин улсад дарагдан мөхжээ.

명경업 Сонгодог бичгийн шалгалт (明經業, Myungkyungup) Корйөгийн Кйөнхаг-т боловсон

хүчин шалгаруулж авах зорилготой орогсдын шалгалтын нэг төрөл. Түшмэдийг төрийн албанд шалгаж авах зорилготой Орогсдын шалгалт нь Утга зохиолын(제술업; 製述業), Сонгодог бичгийн(명경업; 明經業), Холимог(잡업; 雜業) гэсэн гурван төрөл байв. Утга зохиолын шалгалт нь дотроо Хятадын яруу найргийн нэг төрөл шүлэг ши(시; 詩), шүлгийн холбоц пү(부; 賦), өргөлийн магтаал сон(송; 頌), төрийн бодлогын талаарх санал цайг(책; 策) гэсэн хэдэн төрөл байжээ. Харин Сонгодог бичгийн шалгалтыг Хүнзийн суртлын ном судрын мэдлэг шалгадаг байсан ба энэ хоёр нь хоёулаа бичгийн түшмэдийн шалгалт юм. Корйө улсын үед

Утга зохиолын шалгалтад зургаан мянган хүн тэнцсэн байхад Сонгодог бичгийн шалгалтад тэнцэгч дөнгөж дөрвөн зуун тавин хүн байгааг үзэхэд Утга зохиолын шалгалт, гол шалгалт байжээ. Тухайн үед феодалууд Хүнзийн суртлаас илүү утга зохиолыг эрхэмлэн шимтэн болсон байна.

명당 Мйөндан (明堂, Myeongdang) Хятдад Тэнгэрийн хөвгүүн албат түшмэл нарынхаа мэндийг мэдэлдэг газрыг Мйөндан гэдэг байжээ. Фэнг Шуйгийн ухаанд орон сууц барих, өвөг дээдсээ оршуулахад сайн газрыг хэлдэг.

명도전 Гэрэлт хутган зоос (明刀錢, Knife money) Солонгост хэрэглэж байсан Хятадын Байлдаант улсын үеийн мөнгөн тэмдэгт. Урт 12,4-13,5 сантиметр, өргөн 1,5-1,9 сантиметр, хүндийн жин 12-19 грамм. Бариулынхаа үзүүрт нүхтэй, бариулан дээрээ гурван шулуун зураастай. Материал нь хүрэл бөгөөд хэвэнд цутгаж хийдэг байжээ. Гэрэлт хутган зоосны олдвор нийт хутганы олдворын 90%-ийг эзэлдэг. Нэг дороос хэдэн зуу, хэдэн мянгаараа хэлхээтэй элбэг олддог байна.

목곽묘 Модон тасалгаат булш (木槨墓, Wooden Chamber Tomb) модоор тасалгаа гаргаж хийсэн булшны нэг төрөл.

목지국 Могжи улс (目支國, Mokjiguk) Гурван Хань улсын үед Махань (馬韓)-ы тавин дөрвөн жижиг улсын нэг нь Могжи улс байв. “Гурван улсын ойллого” (三國志), “Вэй улсын ойллого”-ын (魏志 東夷傳) “Дорнын бүдүүлгүүдийн шастир”-т Вөлжи улс гэж тэмдэглэжээ. Могжи улс нь төмөр зэвсгийн үеийн эхэнд одоогийн Өвөр Цүнцөн муж болон Ар, Өвөр Чолланам мужад үүсч, хөгжжээ. Пэйгжэ улс Махань-ы голлох улс болон гарч ирэхээс өмнө, Могжи нь Махань-ы хамгийн хүчирхэг (小國聯盟體) улс байв.

묘청의 난 Мё цөний самуун (妙淸의 亂, Myocheong Rebellion) Инъжон-ы 5-р(1127) онд арван таван зүйл бүхий “Шинэчлэх зарлиг” гаргаж вангийн засаглалыг бэхжүүлэх оролдлого хийв. Энэ үед зүрчидийн Алтан улс байгуулагдаж, Корйё улсын гадаад байдал нэлээд түгшүүртэй болж ирсэн үе юм. Дотоод, гадаад байдал тогтвортой бус болсныг ашиглан төр булаах оролдлого дахин гарчээ. Энэ үймээнийг Мё цөн(묘청; 妙淸), Пайг Сү хань(백수한; 白壽翰), Жөн Жи сан(정지상; 鄭知常) тэргүүтэй Сөгийөныхон удирдав. И Жа гйөм-ын самууны хөлд, галд шатсан нийслэл Кайгйөн-

ыг орхин Сөгийөн руу нүүх хэрэгтэй хэмээн Мё цөн номлож, түүндээ Фэн-шуйн сургаалыг ашиглажээ. Тэрээр Кайгийөн-ы газар тамиргүй болсон тул газрын хүч тамир ид цэцэглэж байгаа Сөгийөн руу нийслэлийг нүүлгэвэл газрын буянаар улс орон дахин цэцэглэн хөгжих болно гэж үзэж байлаа. Тийнхүү Сөгийөнд Тайхва ордон(대화궁; 大花宮) баригдсан юм. Мөн Сүн болоод Алтан улсыг их улс, эзэн улс гэж шүтдэг үзлийг шүүмжлэн адил тэгш байр сууринаас хандсан төдийгүй Алтан улсыг дайлахыг санал болгож байжээ. Фэн-шуй шүтдэг Сөгийөн-ы буддын лам Мё цөн-ыг хүнзийн сурталт, Кайгийөн-ы Ким Бү шиг тэргүүтэй бичгийн сайд нар эсэргүүцэж байлаа. Мё цөн эхэн үедээ И Жа гйөм-ын самуунд цочирдсон Инъжон-г өөрийн санаагаар хөдөлгөж чадаж байв. Гэвч эсрэг талынхны шүүмжлэл газар авч, санаан зоргоор хэрэг бүтэхээ болиход цэрэг зэвсгийн хүчээр шийдвэрлэх гэж оролдсон байна(Инъжон 13, 1135). Гэвч жилийн дараа Ким Бү шиг-ийн цэрэгт Сөгийөн эзлэгдэн самуун дарагджээ.

무구정광대다라니경 Хумхын тоосгүй ариун тарнийн судар (無垢淨光大陀羅尼經, Great Dharani

Sutra) 1966 оны 10-р сард Кйөнжү-гийн Пүлгүг хийдийн Шагжамуни суврагаас олдсон дэлхийн хамгийн эртний, модон бараар хэвлэсэн тарнийн ном. Нийт урт нь 620 см, өргөн нь 6,5-6,7 см ба цаг хугацааны хувьд Шагжамуни суврагыг барьсан 751 (Кйөндөг вангийн 10-р) онд барласан болов уу гэж таамагладаг. Солонгосын эртний хэвлэх арга техникийн өндөр түвшинг нотлох харуулах үнэтэй дурсгал юм. Үндэсний соёлын 126-р үнэт зүйлээр бүртгэн авсан бөгөөд Үндэсний Музейд хадгалж байгаа ажээ.

무문토기 Хээгүй шавар ваар (無文土器, Wuwen Pottery) Хээгүй шавар ваар нь шинэ чулуун

зэвсгийн үеийн савхан хээт ваартай харьцуулбал хээгүй эсвэл хээ багатай. Хээрийн жонш, кварц, гялтгануур хольж, 800-аас доош температурт шатаасан хүрэл зэвсгийн үеийн ваар юм. Хээгүй шавар ваарын хэлбэр, хээ нь бүс нутаг бүрд харилцан адилгүй. Хээгүй шавар ваар нь Солонгосын хойгийн хүрэл зэвсгийн үеийн хүмүүсийн цаг хугацаа, орон зайн тархалт болон хөгжлийн явцыг ойлгоход чухал ач холбогдолтой. Хаанаас олдов гэдгээсээ шалтгаалан ерөнхийдөө гурван төрлийн хийцтэй бөгөөд бор өнгөтэй.

무반 Мүбань Цэрэг анги (武班, Wuwen Pottery) гэдэг нь Корйё болон Чосён-ий үеийн

ноёлогч анги болох *янбань*-ы нэг хэсэг юм. *Янбань* нь хоёр анги гэсэн утгатай үг бөгөөд бичгийн түшмэд, цэргийн түшмэдийг хэлнэ. Цэргийн мэргэшсэн алба Гурван улсын үед байсан хэдий ч түшмэл засаглал хэлбэршин тогтож эхлэсэн Корйөгийн эхэн үеэс цэргийн түшмэл гэдэг албан тушаал бий болоод Чосөн-ий сүүл үе хүртэл үргэлжилжээ. Корйө болон Чосөн-ий үед цэргийн түшмэдүүд улс төр, эдийн засгийн хувьд бичгийн түшмэдээс доод байр сууринд байжээ. Корйө улсын үед цэргийн түшмэдүүд зүй ёсоор эзлэх ёстой цэргийн захирагчийн хэргэм тушаалыг бичгийн түшмэдэд алдсан нь цэргийн түшмэд бослого гаргах гол шалтгаан болов. Корйөгийн үед цэргийн түшмэдийг цэргийн эрдэмд онцгой энгийн цэрэг, тосгоны жижиг түшмэдийн дундаас шалгаруулдаг байсан бол Чосөн-ий үед цэргийн түшмэдийн орогсдын шалгалтын журмаар цэргийн түшмэдийг шалгаруулдаг болжээ.

무신란 Цэргийн түшмэлийн бослого (武臣亂, Musinran, Musin Rebellion) 1170 онд (Ыйжон-ы 24-р оны намар) цэргийн түшмэлийн бослого гарав. Бослогын үр дүнд цэргийн эрх мэдэлтнүүд 100 гаруй жил засгийн эрхийг атгажээ. Цэргийн түшмэлийн бослого нь Корйө улсын түүхийг эхэн үе, хожуу үе гэж хоёр ангилах түүхэн эргэлтийн үеийг эхлүүлжээ.

무신정권 Цэргийн түшмэдийн засаглал (武臣政權, Military government) Цэргийн түшмэдийн засаглал нь 1170 оноос 1270 оны хооронд цэргийн түшмэдүүд төр барьсан үе юм. Цэргийн түшмэдийн засаглал нь самбйөлцо буюу гурван тусгай цэрэг зэрэг цэргийн зохион байгуулалт дор цэргийн эрх мэдлээ хадгалж, “Жөнбан” буюу Түшмэлийн цэрэг эрхлэх газар, Хянан сайжруулах газар зэрэг гол байгууллагаар дарангуйллаа тогтоож байв. Цэргийн түшмэдийн засаглалын үед газрыг хууль бусаар дээрэмдэх явдал газар авч, газар эзэмшлийн тогтолцоо нуран унаснаар тариачид, барлагууд гэх мэт нийгмийн доод давхаргуудын эсэргүүцэл тэмцэл ширүүсжээ. Тариачны эсэргүүцэл тэмцэлтэй зэрэгцэн нийгмийн гарлаар ангилах дэг журам ганхав. Цэргийн түшмэлийн засаглалын сүүлийн 40 жилд Монголын довтолгоонд өртөж, нийслэлээ Канхва арал руу нүүлгэж шилжүүлэв. “Найман түмт их хөлгөн судар”-ыг бүтээсэн нь үндэсний ухамсар хэрхэн сэргэснийг харуулдаг.

무용총 Мүйөн булш (舞踊塚, Muyongchong) Хятадын Жилин мужийн Түнгоу(通溝)-гийн талд

Когүрйөгийн 7 мянга гаруй булш орших бөгөөд тэдгээрийн нэг нь уг булш болно. Мүйөн булшны хананд Гурван улсын үеийн когүрйөчүүдийн аж байдлыг дүрсэлсэн зураг буй.

무천 *Му цөнь* (舞天, Mucheon) Эртний Зүүн Еэ аймагт жил бүр, билгийн тооллын 10-р сард хийдэг байсан ургацын талархлын баяр болохын зэрэгцээ тэнгэр тахих ёслол. Овог аймгаараа хамтран тэнгэрт тахил өргөж, дуу дуулан бүжиг бүжиглэдэг байжээ. “Гурван улсын ойллого”-ын “Дорнын бүдүүлгүүдийн шастир”-г бичиж тэмдэглэжээ.

문무왕 *Мүнъмү ван* (文武王, King Munmu) ?-681 он. 661-681 онд ван сууринд сууж байжээ.

Ким овогтой. Уг нэр нь Пөбминь. Өргөмжит цол нь Мүнъмү. Шиллагийн 30-р ван бөгөөд Гурван улсыг нэгтгэх үйлийг гүйцээжээ. 29-р ван болох Тайзун Мүйөл вангийн ууган хүү бөгөөд ээж нь Ким Сө хйөнъ(金舒玄)-ий бага охин болохын зэрэгцээ Ким Юү шинъ(金庾信)-ий эгч болох Мүнъмйөн хатан(文明王后) болно. 661 онд ван сууринд суусан бөгөөд Пү Йө пхүн, Погшинъ нарын толгойлсон Пэгжэг дахин мандуулах хөдөлгөөнийг дарахын зэрэгцээ Тан улстай холбоотон болох замаар Гурван улсыг нэгтгэжээ. Мөн Анъсын, Көм Мо жам нарын толгойлсон Когүрйөг дахин сэргээх хөдөлгөөнийг дараад Солонгосын хойгоос Тангийн үлдэгдэл хүчинг хөөн гаргасан байна. Гурван улсыг нэгтгэх их үйлийг амжилттай бүтээсэн Мүнъмү ван улс орныхоо дотоод байдлыг түвшитгэх, вангийн засаглалыг бэхжүүлэхэд ихэд анхаарчээ. Нас барсны хойно, гэрээслэлийнх нь дагуу Зүүн тэнгисийн эргийн том хадан дээр чандарлан оршуулсан байна.

문벌귀족 *Сурвалжит язгууртан* (門閥貴族, Kwon Munsejok) *Янбанъ* нар орогсдын шалгалт

өгч байж, хэргэм зэргээ үе уламжлан авдаг байв. Харин сурвалжит язгууртан орогсдын шалгалтаас чөлөөлөгдөж, хэргэм зэрэг өвлөж авахын зэрэгцээ өвөг дээдсийн гавьяаны газар өвлөж авах онцгой эрхтэй байжээ. Шиллагийн үеийн язгууртан болон гадны язгууртнаас ялгахын тулд өгсөн нэр ажээ. Үүнд, гурван үед нь таваас дээш зэргийн түшмэл байсан гэр бүлийг хэлнэ. Гэвч Өмнөд Солонгост 2015 онд шинэчилсэн сурах бичигт сурвалжит язгууртан гэлгүй язгууртан хэмээх нэрийг хэрэглэх болжээ.

문하성 *Мүнъ ха сөн* (門下省, Munhaseong) Корйө-гийн засаглалын тогтолцоог ван болон сурвалжит

гэр бүлийн эрх ашгийг хамгаалах, бэхжүүлэх байр сууринаас тогтоожээ. Сөнжон-ы үед сурвалжит гэр бүлүүд төрийн эрхийг атгасан юм. Тиймээс үндсэндээ Сөнжон-ы 2-р(983) оноос Мүнъжон-ы 30-р(1076) он хүртэлх хугацаанд төр захиргааны байгууллагын бүтэц бүрэлдэн тогтжээ. Улс төрийн дээд эрхийг барих *Жүн сө сөн*(중서성; 中書省), *Мүнъ ха сөн*(문하성; 門下省), *Сан сө сөн*(상서성; 尙書省) хэмээх гурван байгууллага байв. Энэ гурваас Жүн сө сөн, Мүнъ ха сөн хоёр голлох үүрэгтэй тул нийлүүлж *Жүн сө мүнъ ха сөн*(중서문하성; 中書門下省) эсвэл *Жайбү*(재부; 宰府) гэж нэрлэж байжээ. Уг хоёр байгууллагын сайдын нэг нь төрийн бодлогыг тогтоож, шийдвэр гаргах, нөгөө нь зөвлөх, хянах үүрэгтэй байв.

미륵신앙 *Майдар бурханд шүтэх шүтлэг* (彌勒信仰, Maitreya Faith) Майдар гэдэг нь санскрит

хэлний “мадри” буюу асрах, хайрлан энэрэх гэсэн утгатай үгнээс үүсчээ. Шагжамуни-гийн шавь Майдарыг ирээдүйд бурхны хутгийг олон, нэгдүгээр хүн болно хэмээн зөгнөсний дараа Тушита тэнгэрт залран сургаал номлолоо айлдаж байхад нь хожмын өдөр зовлонт ертөнцөд дахин мэндэлж, бодь модны дор сургаалаа айлдаж, хүн зоныг гэгээрүүлнэ гэж үздэг шүтлэг юм. Тушита тэнгэрт төрүүлж өгөх, эсвэл Майдар бурхныг энэ ертөнцөд түргэн ирүүлэхийг хүсэн залбирч мөргөдөг шүтлэг болно. Гурван улсын үеэс уламжлагдан ирсэн шүтлэг бөгөөд эрт үед урласан олон Майдар бурхан өнөөг хүртэл уламжлагдан иржээ. Майдар бурхны шүтлэгтэй холбоотой домог ард түмний дунд өргөн дэлгэрчээ.

밀개 *Чулуун хянгар* (Endscraper) Хуучин чулуун зэвсгийн үеийн зэвсэг. Ямар нэгэн юмыг

хусахад хэрэглэдэг байжээ. Чулуун багаж хийх зориулалтаар эмтэлсэн чулууны хэлтэрхий эсвэл чулууны нэг үзүүрийг засч янзлан, зузаан ир гаргахыг чулуун хянгар гэнэ. Зузаан ир нь чулуун хянганы онцлого юм. Ир зузаан байх тусам сайн хусдаг. Хатгах, зурах, хусах үед ир нимгэн байвал амархан хугарна. Чулуун хянгар маш олон төрөл, ир нь бас олон төрөл. Чулуун хянгараар ихэвчлэн амьтны арьс шулдаг байжээ.

박혁거세 *Паг Хйөггөсэ* (朴赫居世, Park Hyeokgeose) НТӨ 69-НТ 4 он. Шилла улсыг үндэслэгч.

НТӨ 57 оноос НТ 4-р оныг хүртэл ван сууринд суужээ. Хатан нь Ким овогт Арийөн хадагтай болно. “Гурван улсын түүхэн тэмдэглэл”, “Гурван улсын нөхсөн судар”-

аас үзвэл НТӨ 69 онд Сарогийн зургаан тосгоны ахлагч нар Алцөнъ толгой дээр цугларч вангаа залж, улсаа байгуулан нийслэллэх газраа сонгохоор ярилцан байв. Энэ үед Ян уулын бэл дэх Нажен гэдэг газарт сонин туяа цацарч, нэгэн цагаан морь урд хөлөөрөө бохирон ёслох мэтээр үйлдэхийг хараад очиж үзтэл нэгэн том өндөг байх бөгөөд морь нь тэнгэрт гараад явчихав. Өндгийг хагалж үзтэл дотроос нь нэгэн цэвэрхэн царайлаг эрэгтэй хүүхэд гарч иржээ. Зүүн булгийн усанд биеийг нь угаатал биенээс нь гэрэл гарч, шувуу болоод амьтад бүжиг бүжив. Өндөг нь хулууны хэрийн хэмжээтэй хэмээгээд овгийг нь Паг хэмээв. Биеэс нь гэрэл гарав хэмээн нэрийг нь Хйөггөсэ, бас Пүлгүнэ(弗矩内) хэмээжээ. Түүнийг зургаан тосгоны ахлагч нар Саро улсын вангаар өргөмжилж, НТӨ 52 (Хйөггөсэ кесөганы 5-р) онд Сарян ли-гийн Арян худгийн дэргэд мэндэлсэн луугийн охин Арийёныг хатнаа болгон авчээ. Ван сууринд суух хугацаандаа Кымсөн хотыг барьж, зургаан мужаар тойрон явах зэргээр төрийг төвхнүүлсэн бөгөөд Ма Хань, Зүүн Огжө зэрэг улстай гадагш харилцаж байв.

발해 Бохай, Пальхэ, Пархэ (渤海, Balhae, Bohai) 7-р зууны дундуур Ляо мөрний баруун талд

Йөнжүд нутаглаж ирсэн когүрйөчүүд, зүрчид, хятан үндэстэнтэй нэгдэн, Тан улсын ноёрхлоос мултран гарч, Манжуурын зүүн хойт хэсэг рүү нүүн суурьшжээ. Тийнхүү Сунгари мөрний сав газар өргөн уудам тал нутагт(эртний Пүйө аймгийн нутагт) нэгэн шинэ улс бий болсон нь Бохай юм. Бохай улсыг Когүрйөгийн жанжин Тэй Жо йөн байгуулжээ. Когүрйөг мөхөх үеэр Йөнжү руу хөөгдсөн Тэй Жо йөн хятан нарын бослогыг ашиглан, албат харьяатуудаа дагуулан зүүн зүгт Тонмо уулын ойролцоо ирж суурьшин, өөрийгөө Жинь улсын ванд өргөмжлөв(698). Боохай-н үндсэн иргэд нь когүрйөчүүд болон моохай үндэстнүүд юм. Манжуурт Когүрйөгийн харьяанд байсан зүрчидүүд Бохай улс бий болохын хамт түүнд даган оржээ. Үндсэндээ эгэл ардын ихэнх нь мохайчууд байж, ноёлогч давхаргыг когүрйөчүүд бүрдүүлж байсан гэж үзэж болно. Японд илгээсэн жуух бичигтээ өөрийн улсыг Корйө улс гэж нэрлэсэн нь Когүрйөгийн залгамж халаа гэж үзсэн, улсаа дахин сэргээх гэсэн хүсэл эрмэлзлийн илрэл гэлтэй. Бохай-гийн гадаад харилцаа сонирхолтой бөгөөд ээдрээтэй. Тан улсын нөлөөнөөс зайлсхийн улсаа төвхнүүлсэн Бохай нь эхэндээ Тан улстай нэлээд дайсагнасан байдалтай байв. Мү ван (719-737)-гийн үед тэнгисээр цэрэг илгээж, Тангийн Тэн жоү Шаньдуны

хойгийг довтолж байсан удаатай(721). Шилла улс ч Бохай-гаас сэргийлж, Каннын мужийн хойт талаар урт хэрэм барьж(721) байсан ба нэгэн үе ширүүн дайтаж байжээ. Тийм ч учир Тан Шилла хоёр нэгдэж, Бохай-г довтолсон нь зүйн хэрэг юм(733). Бохай үүний хариуд хойт зүг Түрэгтэй, өмнө зүг далайн цаадах Японтой холбоо тогтоож байжээ. Гэхдээ харилцаа сайжрахын хамт Шиллад элч илгээж харилцаж байв. Мү ван газар нутгаа өргөтгөж, хойт Манжуурыг эзэлсэн хүчирхэг вант улсынхаа тусгаар тогтнолыг баттай болгожээ. Мү ван(737-794)-ийн үед Танд Ань лю шаний бослого гарснаар шалтаглан Ляодуны хойгийг эзэлж авчээ. Сөнъ ван(818-830)-ийн үед Бохай улсын газар нутаг хамгийн их өргөжин тэлж, нийгэм соёлын хөгжлийн оргил үедээ хүрсэн юм. Энэ үед зүүн хил нь Алс дорнод, баруун талдаа Ляо мөрөн, өмнө зүг Хамнам, хойт талдаа Хэй лун жян гол хүрч байлаа.

발해고 Пархэгийн шинжлэл (渤海考, Bal fired) Чосөнъ-ий сүүл үеийн эрдэмтэн Юү Дыггон 1784 онд бичсэн Бохай буюу Пархэ улсын түүх, соёлын тухай зохиол. Зохиогч нь Бохайг Когүрйөгийн залгамж халаа улс гэж үзэн Нэгдсэн Шиллатай хамтаар Умард Өмнөд улсын үеийг бүрдүүлсэн гэж үзжээ. 2014 онд Ц. Цэрэндорж монгол хэлээр орчуулжээ.

배중손 Пэ Жүн сонъ (裴仲孫, Bae Jung-son) ?-1271 (Вөнъжоны 12-р) он. Корйөгийн сүүл үед Гурван тусгай цэргийн тэмцлийг тэргүүлж байсан цэргийн түшмэл. 1270 (Вөнъжоны 11-р) онд нийслэлийг Канхва арлаас Кэгийн руу буцааж нүүлгэх шийдвэр гарахад Гурван тусгай цэргийхэн уг шийдвэрийг эсэргүүцжээ. Үүнд Вөнъжон Гурван тусгай цэргийг тараахаар зарлиг буулгасан бөгөөд Пэ Жүн сонъ үүнийг эсэргүүцэн Шөнийн эргүүлийн жанжин Но Йөн хьи нарын хамтаар бослого гаргажээ. Тэд Канхва аралд бэхлэн суугаад сынхваху Он-ыг вангаар өргөмжлөв. Засаг газрыг Кэгийн рүү нүүмэгц Жиньдо арал руу шилжиж, уулын хэрмийг бэхлэн суужээ. Чөлла болон Кйөнсан мужийн усан замыг эзлэсэн байна. Дараа жил нь Ким Бан гйөн болон монгол юаньшу Хинду нарын удирдсан цэрэг Жиньдо арлыг довтлох үеэр дайнд амь үрэгдсэн гэж таамагладаг. Үүний дараа Гурван тусгай цэргийн үлдэгдэл хүчин нь Чэжү арал руу шилжиж, хоёр жил гаруй тэсчээ.

백제 Пэгжэ, Пайгжэ (百濟, Baekje, 18 BC - 660 AD) Пэгжэ бол Гурван улсын нэг нь бөгөөд

Солонгосын хойгийн төв хэсэгт оршиж байгаад 660 онд мөхсөн эртний төрт улс юм. НТӨ 18 онд Пүёгоос гаралтай Онжо гэгч одоогийн Сөүл хот байгаа нутагт Пэгжэ улсыг үндэслэжээ. Хань болон еэ гэх мэт уугуул нутгийнхныг пүёо нар захиргаандаа оруулсан гэсэн үг юм. Когүрийё болон Шиллатай дайтах үедээ дайтаж, эвлэрэх үедээ эвлэсээр газар нутгаа Йёнсань мөрөн, Сөмжинь мөрөн хүртэл тэлж, хүчирхэг төр улс болон хөгжижээ. Газар зүйн таатай байрлалаа дээд зэргээр ашиглаж, Хятадын дэвшингүй соёлыг өөрийн хөрсөндөө сайтар буулгаж авч байсны зэрэгцээ тэрхүү соёлыг Япон болон Каяад уламжлан дамжуулж, эртний Зүүн Азийн соёлын хүрээг бүрэлдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Гэвч Шилла болон Тангийн цэргийн холбоотны хүчинд автан 660 онд мөхсөн байна.

법흥왕 Пөбхын ван (法興王, Beopheung 514-540) Гурван улсын үеийн Шиллагийн 23-р ван. Овог нь

Ким, нэр нь Вөнъжон. Жижын вангийн хүү бөгөөд эртний төрт улсын төвлөрсөн засаглалыг тогтоосон ван юм. 516-517 онд цэргийн яам байгуулж, цэргийн эрх мэдлийг зангидан вангийн засаглалыг бэхжүүлснийхээ дараа 520 онд хууль тунхаглажээ. Хуулийн агуулгыг мэдэж болох сурвалж бичгийн дурсгал уламжлан ирээгүй ч түүнд түшмэлийн арван долоон зэрэг дэв, ямбаны хувцасны өнгийг тогтоож, мөн *Колхум* ёсны талаар хуульчлан заасан гэж үздэг. *Сандэдын* буюу тэргүүн сайдын тушаалыг бий болгоод язгууртны хурлыг ахлуулсан байна. Каяаг байлдан дагуулж, газар нутгаа томруулсан гавьяатай. Дараа жил нь буюу 23-р(536он) онд “*Көнъвөнъ*” гэдэг оны чимэг хэрэглэж эхэлсэн нь дотоодод вангийн эрх бэхжиж, гадаадад Хятадтай эн зэрэгцэх улс хэмээн бахархах болсныг харуулна. 14-р(527 он) оноос 22-р(535 он) онд буддын шашныг төрийн шашин болгон улсыг оюун санааны хувьд нэгтгэх үзэл суртлын суурийг тавьжээ. Амьдралынхаа сүүлийн жилүүдэд сахил санваар хүртсэн бөгөөд сахилын нэр нь Пөбгон болно.

백란도 Пйөгранъдо (碧瀾渡, Byeokrando) Корйөгийн үеийн худалдаачид наймаачид болон

Хятадын элч нарын нийслэл Кэгийөнд хүрэхийн тулд дамждаг байсан боомт. Еэсөн мөрний эрэгт орших тул өөрөөр Еэсөн боомт гэж бас нэрлэдэг байжээ. Кэгийөнөөс баруун тийш дөчин ли газарт оршдог байв. Хятадын элч нар энд усан онгоцоо зогсоогоод Пйөгран жөн гэдэг газарт хоногლოსны дараа Кэгийөн руу явдаг байжээ.

Хятад болон араб худалдаачид зорчидог олон улсын боомт байв.

변한 Пйөнъ Ханъ (弁韓, Byeonhan) Одоогийн өвөр Кйёнсан мужийн төв хэсэгт оршиж байсан

Гурван Ханъ-ы нэг. Пйөнъ Ханъ (卞韓) гэж бас нэрлэдэг. “Гурван улсын ойллого”-оос үзвэл Пйөнъ Ханъ нь Ма ханъ-ы зүүн талд, Жинъ Ханъ-ы баруун талд оршиж байсан бөгөөд Мирими донгүг(彌離彌凍國), Чөбдогүг (接塗國), Кожами донгүг (古資彌凍國), Косүнъ шигүг (古淳是國), Панърогүг(半路國), Нагногүг (樂奴國), Күнъмигүг (軍彌國), Миояамагүг (彌烏邪馬國), Камрогүг (甘路國), Күяагүг(狗倂國), Жүжомагүг (走漕馬國), Анъяагүг (安挪國), Тогрогүг(瀆盧國) зэрэг аймгаас тогтож байв. Эдгээр аймагаас том нь 4-5 мянган өрх, бага нь 6-7 зуун өрхөөс тогтож байсан бөгөөд томхон аймгийн ахлагчийг *шинъжи* (臣智), арай багавтар аймгийн ахлагчийг *хөмцыг* (險側), *сархэ*(殺奚), *ыбца* (邑借) гэх мэтээр нэрлэдэг байжээ. Газар нутаг нь үржил шимтай тул таван төрлийн тариа будаа болон тутрагын тариалан эрхлэхэд тохиромжтой байв. Хүр хорхой үржүүлж, торго болон даавуу нэхэж мэддэг байжээ. Төмрийн хүдэр элбэгтэй бөгөөд эндээс Ма Ханъ, Награн гүнъ, Тэбан гүнъ, Зүүн Еэ, Вэга зэрэг газар руу төмрийн хүдэр гаргадаг байв. Хэл, орон сууц, зан заншил, хувцас хунар нь Жинъ Ханъ-ыхтай адил төстэй байсан бөгөөд өвөрмөц тахилын ёслолтой байв.

별무반 Тусгай цэргийн анги (別武班, Byeolmuban) Корйөгийн эхэн үед зүрчидийг байлдан

дагуулахын тулд зохион байгуулсан цэргийн анги. Юнь гванъ-ы санал болгосноор байгуулсан бөгөөд Тусгай цэргийн анги дотроо Бурхны морьт цэрэг(신기군; 神騎軍), Бурхны явган цэрэг(신보군; 神步軍) бас Ад чөтгөрийг дарах цэрэг(항마군; 降魔軍) гэсэн гурван хэсгээс бүрджээ. Морьт, явган цэрэг нь голцуу феодал, чөлөөт тариачдаас, Ад чөтгөрийг дарах цэрэг нь лам нараас бүрдсэн байна. 1107 онд Юнь гванъ, О Йөнъ цон нар тусгай цэргийн ангийг удирдан зүрчидийг төвшитгэж байжээ. Йэжон(예종; 睿宗)-ы 2-р(1107) онд Юнь гванъ(윤관; 尹瓘)-ы удирдсан Корйө-гийн цэрэг Хамхын(함흥; 咸興)-ы тал газарыг эзлээд, цааш Ма үнъ рйөн(마운령; 摩雲嶺)-ыг давж, Килжү(길주; 吉州) хүртэл давшиж эзэлсэн гэдэг. Чухам хаа хүртэл эзэлсэн тухай хэд хэдэн санал байдаг. Юутай ч эзэлсэн нутагт есөн хэрэм байгуулан цэргээ хуарагнуулж, хилийг хамгаалуулжээ. Гэвч удалгүй

зүрчидүүдэд буцааж алдсан байна(Йэжон 4-р, 1109 он)

병부 Цэргийн яам (兵部, Byeongbu) Гурван улсын үеийн Шиллагийн албан газар. 516 (Пёбхын вангийн 3-р) онд байгуулагдсан бөгөөд цэргийн хэргийг хамаардаг байв.

병자호란 Чин улстай дайтсан, улаан хулгана жилийн дайн (丙子胡亂, Byeongjahoran) 1632 онд Хожуу

Алтан улс Чосонь-ийг албат улс болох, жил бүр өргөх алба бэлгийн хэмжээг ихэсгэхийг шаардав. Чосонь улс шаардлагыг хүлээж авсангүй. 1636 онд Хожуу Алтан улс нэрээ Чин(淸; 清) улс хэмээн өөрчилсөн ба хоёр дахь удаа довтолжээ. Үүнийг улаан хулгана жилийн дайн гэж нэрлэдэг. Чин улсын цэрэг нийслэл Ханьсөн-г шууд чиглэн ирэхэд Инъжо ван Канхва арал руу зугттал зам хаагдаж, Намхань уулын хэрэмд толгой хоргодов. Тэнд Чин улсын цэрэгт бүслэгдэж байгаад, өлсгөлөн хүйтнийг тэсвэрлэлгүй гарч бууж өгчээ. Ингэж ялагдаад Чосонь нь, Мин улстай харилцаагаа таслах, вангийн угсаа залгагч хүүг барьцааны хүн болгон илгээх, Чин улсын албат улс болсноо хүлээн зөвшөөрөх, Чин улс Мин улсыг дайлах үед цэрэг хөдөлгөн туслахыг амлав. Чин улсын түрэмгийлэл богино хугацаанд болсон ч, харийн цэргүүдийн дээрэм тонуул хэтэрхий байсны дээр дайны дараа Чин улсад барих алба бэлгийн хэмжээ ихсэж, энгийн ард их хохирол амсчээ. Тэр тусмаа Японы довтолгооны дараа эдийн засаг бүрэн сэргэж амжаагүй байхад дахин харийн түрэмгийлэлд өртсөн тул тариачдын амьдрал тэсэхүйеэ бэрх болсон байна. Ялангуяа, Чин улсын цэрэг шууд дайрч өнгөрсөн баруун хойт нутаг дээрэм тонуул, аллага хядлагын улмаас эзгүйрч хоосорчээ.

봉수 Дохиот гал (烽燧, Beacon) Бамбар юм уу эсвэл галын утаагаар яаралтай мэдээг дамжуулах эртний

аргыг хэлнэ. Эрт үед Ази даяар хэрэглэж байсан уламжлалт цэрэг улс төрийн арга. Өдрийн цагаар өндөр ууланд гал гаргаж утаагаар дохио өгөх ба шөнийн цагаар бол галаар дохио өгдөг байжээ. Солонгосын түүхийн сурвалжид Караг улсын Сүро ван дохиот гал хэрэглэж байсан тухай мэдээ бий. Корйөгийн дунд үе гэхэд дохиот галыг улс орны харилцаа холбооны сүлжээ болгон хэрэглэж байсан бөгөөд энэ нь Чосонь-ий үе хүртэл үргэлжилжээ.

부곡 Пүгог (部曲, Bugak) Нэгдсэн Шилла болон Корйөгийн үеийн, харц барлагууд амьдардаг

орон нутгийн доод шатны тусгай нэгж. Пүгог-ын иргэд нь улсад алба татвар төлдөг тул боол бус чөлөөт иргэд байжээ. 4-6 дугаар зууны үед Солонгосын хойгт төмөр

зэвсэг тархснааар газар тариалан хөгжиж, шинээр олон тосгон бий болжээ. Нэгдсэн Шиллагийн үед эдгээр тосгодыг төвийн засаг захиргаанд харьяалуулах ажил хийгдэж, газар нутаг хүн амын хувьд харьцангуй жижиг хэмжээтэйг нь *хян* юм уу эсвэл *нүгог* гэж нэрлэх болсон байна.

부여 Пүйө, Пүё (扶餘, 夫餘, Buueo, 기원전 4 세기 ~ 494 년) Сунгари мөрний сав газар өргөн уудам

тал нутагт оршиж байсан эртний аймаг. Сурвалжид ХТӨ IV зууны хавьцаа Пүйөгийн тухай анхны баттай мэдээ гардаг ба ХТ-ийн I зуунаас үе үе нэр гардаг.

Пүйө нь Ванман(왕망; 王莽)-ы төвхнүүлсэн Синь(신; 新, ХТ 8-23) улсад Хүннү,

Когүрйөгөөс дутахгүй хүчирхэг улсын нэгэнд тооцогдож байжээ. Энэ үед аймгийн холбоонд нэгдсэн байв. ХТ 49 онд “ван” цол хэрэглэж байсан тухай хятад сурвалжийн мэдээ бий. Вэй(위; 魏) улсын жанжин Гуань юэ сянь(관구검; 田丘儉)

Когүрйөг довтлох үед(ХТ 244 он), Пүйө холбоотон улсын хувиар Вэй-гийн цэргийг

хоол хүнсээр хангаж байв. Сяньбигийн Мү рун чүйн довтолгоонд Ыйрйө ван(의려왕; 依慮王) алагдан түүний үр хүүхдүүд Огжө руу зугатжээ(ХТ 285). Ийм

хүнд үед Пүйөгийн вангийн удмын Ыйра(의라; 依羅)-д Жинь(Jin; 晋) улс туслан

дэмжиж, улс гэрийг мөхөхөөс аварчээ. Гэвч түүний дараа өмнө талаас нь Когүрйө

довтлов. Пүйө нь төв Азийн нүүдэлчин аймаг, Когүрйө хоёрын дунд хавчигдаж,

тэдний эсрэг тэмцэлд Хятадыг түшин, улс гэрээ төвхнүүлж иржээ. Харин Жинь

улс, төв Азийн нүүдэлчдэд шахагдаж, урагш нүүдэллэхийн хамт(ХТ 316), Пүйө

ганцаардаж эхэлсэн байна. Тийн ХТ 346 онд Му рун хуан довтолж, тавин мянган

пүйөчүүдийг хаантай нь олзлон аваачжээ. Мү рун овогтон доройтоход(ХТ 370),

Пүйө Когүрйөд дагаар оров (ХТ 494).

부족 Аймаг (部族, Tribe) Нэг өвөг дээдэстэй, адил хэл, шашин шүтлэгтэй хамтын

нийгэмлэг. Нэгэн овогтой бөгөөд хүн төрөлхтний түүхэн дэх анхны том

хэмжээний улс төрийн хамтын нийгэмлэг болно. Хэд хэдэн овгоос аймаг

бүрэлдэж бий болжээ.

부족국가 Аймаг улс (部族國家, Tribal country) Балар эртний нийгмээс төвлөрсөн засаглалт төр улс үүсэх шатны улс төрийн бүтэц. Аймгийн холбоо.

북위 Юань Вэй буюу Тоба Вэй, Хожуу Вэй, Умард Вэй (北魏, Northern Wei 386~534)

Хятадын Таван ху-гийн Арван зургаан улсын үед тоба овгийн Тоба Гүй Хуабэй-д төр төвхнүүлжээ. Хятадын таван ху, арван зургаан улсын үед Сяньби нарын байгуулсан Өмнөд Умард Ханлиг улсын үе хүртэл оршин тогтносон төрт улс юм. Улсын албан нэр нь Тоба боловч ханз нэр нь Вэй (魏) бөгөөд Гурван улсын үеийн Вэй улсаас ялгахын тулд Хожуу эсвэл Умард Вэй гэж нэрлэдэг. Тоба овогтнууд хаанчилсан учраас Тоба Вэй ч гэж нэрлэнэ. Тоба овогтнууд овгоо Юань гэж өөрчилснөөс хойш Юань Вэй (元魏) гэж нэрлэдэг.

불국사 Пүлгүг хийд (佛國寺, Bulguksa) Шиллачуудын үлдээсэн урлагийн гайхамшигт дурсгалын оргил нь *Пүлгүгса* хийд, Бурхан багшийн суврага, Олон эрдэнийн суврага болно. Пүлгүг хийдийг Кйөндог вангийн 10-р(751) онд чинсан Ким Дай сөн энэ болоод өмнөх насны эцэг эхийн дурсгалыг мөнхжүүлэх гэж барьсан гэдэг ч ер нь улсын хөрөнгөөр барьжээ. Пүлгүг хийд уг нь хоёр мянга гаруй тасалгаатай, том хийд байсан авч, модон хэсэг нь хар луу жилийн Японы довтолгооны үед шатаж үгүй болсныг сэргээн засварлажээ. Гол хаалга болох Чаха хаалга руу өгсөх Цагаан үүлэн (доод) шат, Хөх үүлэн (дээд) шат, *Тай-үн* ордны өмнө хослон байх Бурхан багшийн суврага, Олон эрдэнийн суврага, эд бүгд *Тай-үн* ордныг тойрон чимж байдаг.

비로자나불 Машид амирлуулагч (毘盧遮那佛, Vairocana) Энгийн хүний нүдэнд үл үзэгдэх гэрлэн биет бурхан багш. Санскрит хэлний (vairocana) гэдэг үгнээс үүсэлтэй.

비파형동검 Бийпаа хэлбэрт хүрэл хутга (琵琶形銅劍, Lute-shaped Bronze Dagger) Хятадын зүүн хойт нутаг, Ляо мөрний сав газраар төвлөн их олддог хүрэл зэвсгийн үеийн олдвор юм. Солонгосыг чөлөөлөгдөхөөс өмнө “Манжуур маягийн хүрэл хутга” гэж нэрлэдэг байжээ. Зарим эрдэмтэд “Пүйө маягийн хүрэл хутга” гэж нэрлэх нь ч бий. Солонгост 1960-аад оноос хойш Пхйөнян-ы Хйөнжэсан дүүргийн Сөподон,

Хванхэ мужийн Пэцөнъ, Кйёнсан мужийн Санжү, Цүнцөн мужийн Сонгүтри-гээс олдсон бөгөөд сүүлийн үед өвөр Чөлла мужаас бас олджээ.

빗살무늬토기 시대 Савхан хээт шавар ваарны үе (— 土器時代, Com-pattern pottery period

또는 즐문토기 시대(櫛文土器時代, Jeulmun pottery period) Солонгосын хойгийн архиологийн үечлэлийн нэг үе. НТӨ 8200-НТӨ 1500 оныг хамаарна. Савхан хээт шавар ваар бол шинэ чулуун зэвсгийн үеийн голлох олдворын нэг бөгөөд ваарны ур хийцээс шалтгаалан эрт, дунд, хожуу үе гэж ангилдаг. Уг вааранд үр тариа болон хоолны үлдэгдэл зэргийг хадгалдаг байсан бололтой.

사고 Түүхийн сан хөмрөг (史庫, Accident) Корйё болон Чосөнъ-ий үеийн вангуудын “Үнэн магад тэмдэглэл”-ийг хадгалахын тулд улсаас байгуулсан судар бичгийн сан.

사관 Сударч түшмэл (史官, History official) Корйё, Чосөнъ-ий үеийн түүх, судар, шастирын ажил эрхэлсэн түшмэл. Корйёгийн Кванжон-ы үед Хятадын жишээгээр, ордонд сударч түшмэлийн албыг байгуулжээ. Түүнээс хойш *еэмүнъ цүнцүгван*, *цүнцүгван* зэргээр нэрийг нь өөрчилж байсан байна. Сударч түшмэд нь цаг үеийн алдаа эндэл, ололт амжилт, хүмүний мэргэн ухаан болон харалган явдал зэргийг хойд үед сургамж бологон бичдэг байжээ. Зарим үед сударч түшмэдэд дарамт шахалт үзүүлсний улмаас түүхэн үнэнийг гажуудуулан бичүүлэх явдал гардаг байжээ.

사기 Түүхэн тэмдэглэл (史記, Shiji) Хятадын Хань улсын түүхэн хүүрнэл зохиолын хамгийн сор бүтээл бөгөөд Сыма Цянь гэгч зохиожээ. Эцэг Сыма Тан нь ордны сударч түшмэл байсан бөгөөд эцгийнхээ эхлүүлсэн ажлыг гүйцээж, НТӨ 91 онд бичиж дуусгажээ. Хятадын аман түүх домогт өгүүлэх Шар хуандигаас Хань улсын Үди хуанди төр барьсан анхдугаар он хүртэлх 3000 жилийн түүхэн үйл явдлыг уран зохиолын яруу үг хэллэгээр, уран дүрслэн бичсэн түүх, уран зохиол юм. Мөн Хятадын түүхэн дэх 24 төрт улсын албан түүхийн эхлэл болсон бөгөөд уран нарийн дүрслэл ба бүтцийн хувьд сонгодог хэв загвар болсон бүтээл хэмээн үнэлдэг.

사대부 Садэбү (士大夫, Sadaebu) Корйё болон Чосөнъ-ий үеийн, бичгийн түшмэдийг нэрлэх ерөнхий нэр.

Эртний Хятадад тэнгэрийн хөвүүн болон ноёдыг *тэбү* болон *са* гэж цоллодог байснаас үүдэлтэй нэр ажээ. Яваандаа бичгийн төдийгүй бичиг, цэргийн түшмэдийг нийтэд нь нэрлэх

нэр болж хувирчээ. Сүн улсын үед күнзийн суртлын шинэ урсгал болох *сөнри хаг*-аар зэвсэглэсэн *садэбү* нар өөрсдийн ноёрхлыг бэжүүлэхийн тулд хууль журам, ёс дэглэм зэргийг садэбү төвтэй болгон өөрчилж, улс төрийн эрх мэдлийг атгах болжээ. 13-р зуунд *сөнри хаг* нь Корйөд нэвтэрснээр Корйөгийн шинэ *садэбү* давхарга бий болсон байна. Шинэ *садэбү* нар Чосөн-ий төрийг төвхнүүлж, шинэ вант улсын ноёлогч анги болсон бөгөөд бичгийн түшмэд төвтэй төр засгийг цогцлоожээ.

사략 Түүхийн товчоон (史略, History book) 1357 онд эрдэмтэн И Жэхёнъ Корйөгийн 15

дугаар ван болох Сүгжоны үеийг хүртэлх түүхийг бичсэн он дарааллын түүхэн зохиол. Бидний үед уламжлан ирээгүй учраас тодорхой мэдэх аргагүй боловч он дарааллын бичиг маягаар бичсэн Корйөгийн вант улсын түүх гэж таамагладаг.

사로국 Саро улс (斯盧國, Soraguk) Кйөнжү-гийн талд нутаглаж байсан Саро хот улс нь

Кыбryan(급량; 及梁), Сарян(사량; 沙梁), Понъпхи(본피; 本彼), Морян(모량; 牟梁), Ханъжи(한지; 漢祗), Сыбби(습비; 習比) хэмээх зургаан овгоос бүрдэж байв. Саро хот улсын анхны захирагчийг Хйөггөсэ гэдэг байсан тухай домог бий. Хйөггөсэ нь Кыбryan овгийн хүн байсан тул анх энэ овгоос ахлагчийг сонгодог байсан бололтой. Түүний хатан Арийөн(알영; 闕英) нь Сарян овгийнх тул, Сарян нь Кыбryan дараа орох хүчирхэг овог байжээ. Түүний дараа Зүүн тэнгисийн эргийн бөө мөргөлт Тхархай(탈해; 脫解) ноёлох болжээ. Энэ үед Кйөнжү нутгаас халин, зэргэлдээ хот улсуудыг нэгтгэх хандлагатай болсон байна. Энэ үеийн захирагчдыг *Көсөганъ*(거서간; 居西干), *Ца ца үн*(차차웅; 次次雄), хожим *Исагым*(이사금; 泥師今) гэж дуудах болсон ба бөө, тахилч, залгамжлагч гэсэн утгатай бололтой. Энэхүү Саро хот улсын байдал бусад хот улсын байдалтай ерөнхийдөө нэлээд төстэй байсан хэмээн үздэг.

사림 Сарим (士林, Sarim) Корйөгийн дунд үеэс Чосөн-ий үеийн күнзийн сурталт бичгийн хүмүүсийг

нэрлэх нэр. 1970-аад оноос түүхийн сурах бичигт Чосөн-ий эхэн үеийн ноёлогч давхаргыг нэрлэх нэр болон тогтжээ.

사문학 Дөрвөн зүйл сургууль (四門學, Private Literature) Корйөгийн үеийн сургууль. Сөнжон-гийн

11-р(992) онд Төрийн хөвгүүдийн сургууль(국자감; 國子監) хэмээх сургууль

байгуулснаар Корйё улсын боловсролын тогтолцооны суурь тавигджээ. Нэгэн ёсны их сургууль болох Төрийн хөвгүүдийн сургууль нь дотроо хэд хэдэн дээд сургуулиас бүрдэж байсан ба Инъжон-ы үед(1122-1146) Нийслэлийн зургаан сургууль гэж нэрлэсэн *Күгжахаг*(국자학; 國子學), Их суртахуй(태학; 太學), Дөрвөн зүйл сургууль(사문학; 四門學), Хуулийн(율학; 律學), Уран бичлэгийн(서학; 書學), Тооны(산학; 算學) гэсэн зургаан сургууль бүрэлдэн тогтжээ. *Күгжагам*, Их суртахуй, Дөрвөн сургуульд “Таван бичиг”, “Ачлалт ном”, “Шүүмжлэлт өгүүлэл” зэрэг Хүнзийн суртлын ном голчлон үздэг байсан тул адил төрлийн хичээл заадаг гэсэн үг юм. Төрийн хөвгүүдийн сургуульд бичиг цэргийн гуравдугаар зэргээс дээд, Их суртахуйд тавдугаар зэргээс дээд, Дөрвөн сургуульд долдугаар зэргээс дээд зэргийн түшмэдийн үр хүүхэд сурдаг байснаараа ялгаатай юм. Нөгөө гурван сургуульд наймдугаар зэргээс доод зэргийн түшмэдийн, мөн татвар эмийн үр хүүхэд сурч байв.

사비성 Саби хэрэм (泗沘城, Sabi Fortress) Пэгжэгийн нийслэл хот байсан хэрэм. Өвөр Цүнцөн мужийн Пүйё хотод оршидог. 538 онд Пэгжэ нь Саби хэрэм рүү нийслэлээ нүүлгэсэн бөгөөд Пүсо уулыг тойруулан хавирган сар мэт хэлбэрээр барьсан тул Панвөл хэрэм гэж бас нэрлэдэг байжээ. Пэгжэг мөхсний дараа пэгжэчүүд Саби хэрмийг эзлэн аваад Шиллагийн цэргийн довтолгооныг няцааж, улсаа дахин мандуулах хөдөлгөөн өрнүүлж байв.

사서오경 Дөрвөн бичиг, таван ном (四書五經, Four Books and Five Classics) Күнзийн суртлын гол номууд. НТӨ 300 оны орчим бичигджээ. “Шүүмжлэлт өгүүлэл”, “Мэнз”, “Их суртахуй”, “Хэв дундын бичиг”-ийг “Дөрвөн бичиг” гэх ба “Шүлэглэлт ном”, “Түүхийн ном”, “Зурхайт ном”, “Хавар намар”, “Ёслолт ном”-ыг “Таван ном” гэдэг.

사심관 Сашимгванъ (事審官, Sasimgwan) Корйёгийн үед орон нутгийн засаг захиргааны нэгжүүдэд бүгдэд нь төвөөс тодорхой хугацаатайгаар захирагч томилогч явуулж байсан ба эдгээр захирагчийг төрсөн нутагт нь явуулдаггүй байсан нь орон нутгийн эрхтнүүдийн хүчин өсөж бэхжихээс сэргийлсэн хэрэг байжээ. Тэдний захиргаан дах доод тушаалын түшмэлүүд(*хожан*; 호장; 戶長; *чанри*; 장리; 長吏)

энгийн ард, тариачидтай шууд харилцаж засаг захиргааны гүйцэтгэх үүрэгийг хариуцаж байв. Эд нар нутгийн уугуул иргэд тул богино хугацаагаар солигдож байдаг төвөөс томилсон захирагч нараас илүү тухайн нутгийн нөхцөл байдал, ажил хэргийг сайн мэддэг, илүү нөлөөтэй ч байжээ. Тиймээс тэднийг хэт толгой даахаас сэргийлж, төвөөс уг нутгийн гаралтай *сашимгвань* түшмэл томилж хянуулах юм уу, үр хүүхдийг нь барьцааны хүн маягаар нийслэлд суулгах арга хэмжээ авч байв.

사역원 Хэлмэрчийн газар (司譯院, Saeakwon) Корйё болон Чоён-ий үеийн гадаад хэл болон орчуулах, хэлмэрчлэх ажлыг хариуцуулсан албан газар. Монгол, хятад, манж, япон хэлний хэлмэрчийн газар байжээ.

사전원 Сүмийн тариалангийн газар (寺院田, Temple hall) Сүм хийдийн эзэмшлийн тариалангийн газар. 976 оноос эхлэн газар өмчлүүлэх журмын дагуу сүм хийдэд тариалангийн газар хуваариалан олгосон бөгөөд хожим ван болон язгууртнууд сүм хийдэд газар олгох, эсвэл сүм хийд өөрөө газар эзэмших явдал элбэг болжээ. Солонгосын уламжлалт нийгэмд бүддийн сүм хийдүүд нь төрийн үзэл суртлын төлөөлөгч болж байсан бөгөөд ард иргэдийн дийлэнхи нь шүтэж биширдэг байв. Энэ үеийн бүддийн шашны эдийн засгийн хүчин чадлын гол суурь нь сүмийн тариалангийн газар байжээ.

사헌부 Сахёнбү (司憲府, Saheonbu) Корйё, Чосён-ий үед, төрийн хэргийн зөв бурууг шүүж, түшмэдийн зүй бус явдал үйлийг хянаж, засах үүрэгтэй байгууллага. Түүний сайд нь түшмэд сайд нарыг томилох, хууль тогтоох цуцлах зэрэг чухал хэрэг шийдэхэд гарын үсэг зурж баталгаажуулах эрх үүрэгтэй байсан тул вангийн хэмжээгүй эрхт засаглал тогтохоос сэргийлэх, өөрөөр хэлбэл эрх мэдлийг тэнцвэржүүлэх чухал үүрэгтэй байжээ.

살리타이 Саридай (撒里台, монгол: *ᠰᠠᠷᠢᠳᠠᠢ* Saridaᠢ,? ~ 1232 он) Монголын эзэнт гүрний үеийн жанжин. Жалайр овгийн хүн бөгөөд Чингис хааны итгэлийг олсон мэргэн харваач байжээ. Түүнийг бас мэргэн харваач буюу хорчи (Qorchi, 豁儿赤) гэж нэрлэдэг байжээ. 1231 онд Монголын элч Жугуй алагдсны улмаас Саридай цэргээ удирдан Корйё руу довтолсон боловч Күижү гэдэг газар ялагдал хүлээсэн байна. Гэхдээ

дахин хүчээ сэлбээд Кэсөн хүртэл довтолжээ. Тэгээд Корйөгийн засаг газартай хэлэлцээр хийгээд цэргээ татан буцсан байна. Гэвч Корйөгийн засаг газар нь Канхва арал руу зугатан гарсан тул дараа жил нь Саридай цэргээ удирдан дахин дайлаар иржээ. Цө-инь хэрмийн тулаанд Ким Юнь хү гэдэг хуврагт алуулжээ.

살수대첩 Салсүгийн их ялалт (薩水大捷, Battle of Salsu) Когүрйө-гийн цэрэг Суй улсын Ян

хуандигийн удирдсан их цэргийг Салсү (Цөнцөнъ мөрний хөвөөнд) гэдэг газарт бут цохисон их ялалт. Когүрйө нь Хятадын Ар, өвөр ханлиг улстай найрамдалт харилцаатай байсан боловч 589 онд Суй улс Хятадыг нэгтгэмэгц дайсагнасан харилцаатай болж хувирчээ. 598 онд Суй улсын стратегийн чухал газар болох Ляоши руу довтолж байв. Үүнд хилэгнэсэн Суй улсын Мүн хуанди гурван зуун мянган их цэргээр усан болох хуурай замаар Когүрйө руу довтолсон боловч үер болох хар салхины улмаас амжилт олоогүй байна. Дараа нь Ян хуанди урьд үзэгдээгүй их хүч буюу сая гаруй их цэргээр Когүрйөгийн хилийн хамгаалалтын гол цэг Ляодун цайзыг дайрав. Гэвч амжилт олоогүй тул гурван зуун мянган тусгай цэргээр Когүрйөгийн нийслэл Пхйөнян руу шууд довтолжээ. Ылжимүньдөг жанжин дайсныг хуурч хөөгдөж буй дүр үзүүлэн нутгийн гүнд дагуулж аваачаад Салсүгийн орчим бут цохисон байна. Ялуу мөрнийг гатлан ирсэн дайсны гурван зуун мянган цэргээс ердөө хоёр мянга долоон зуун хүн амь гарсан гэдэг. Байлдах урам зориг нь бүрмөсөн унтарсан Ян ди ухрахаас өөр замгүй болжээ.(Йөн ян вангийн 23-р, 612 он) Когүрйөг байлдан дагуулах явдал амжилтгүй болсон нь Суй улсын мөхлийн замыг нээсэн гэдэг.

삼국사기 Гурван улсын түүхэн тэмдэглэл (三國史記, Samguk Sagi) 1145 онд Ким Бүшиг

тэргүүтэн вангийн зарлигаар бичсэн Солонгосын албан түүх. Шастирын хэлбэр (기전체. 紀傳體)-ээр бичигдсэн уг сурвалж нь “Уг тэмдэглэл (본기. 本紀)”, “Ойллоо (지. 志)”, “Илтгэл (연표. 年表)”, “Олон шастир (열전. 列傳)” зэргээс бүрдэнэ. Уг тэмдэглэлийг ван тус бүрээр ангилж бичээгүй. Когүрйө, Пэгжэ, Шиллагийн уг тэмдэглэлийг тус бүрээр нь нэг нэг “Уг тэмдэглэл” болгоод дотор нь ван тус бүрээр бичжээ. Гурван улс дундаас Шиллагийн түүхийг хамгийн эхэнд бичсэн бөгөөд хэмжээний хувьд ч хамгийн их. 2018 онд Ц. Цэрэндорж монгол хэлээр орчуулж хэвлүүлжээ.

삼국유사 Гурван улсын нөхсөн судар (三國遺事, Samguk Yusa) Корйё улсын Цүн рйөл

вангийн 7-р онд (1281 он) Ир-йёнъ лам Инъгаг хийдэд шавилан суухдаа “Гурван улсын нөхсөн судар”-ыг бичиж үлдээсэн бөгөөд Солонгосын түүхийн чухал сурвалж бичиг юм. Эх хувь нь уламжилж ирээгүй боловч 2003 онд Чосён-ий эхэн үед хэвлэгдсэн хоёр янзын хуулбар БНСУ-ын Үндэсний Соёлын өвийн 306 дугаар, 306-2 дугаар үнэт зүйл болжээ. Уг судрын агуулгад Гурван улс болон Караг улсын вангийн үе залгамжлал, он дараалал, Эртний Чосён-өөс авахуулаад эртний олон улс гүрний мандал буурал, домог, хууч яриа, сүсэг бишрэл, түүх, буддын шашны талаарх тэмдэглэл, их хуврагуудын тухай үлгэр домгууд, дандрын ёсны хуврагуудын үүх түүх, ачлал тахимдуугаар нэрээ гаргасан хүмүүсийн талаарх өгүүлэл зэрэг багтжээ. Гурван улсын бүх үлгэр домог нь гурван улсын цаг үеийнх бөгөөд амнаас ам дамжин уламжлагдан иржээ. Харин тэдгээр үлгэр домгийг Корйёгийн үед л бичгээр бичиж үлдээсэн байна. Өөрөөр хэлбэл амнаас ам дамжих үлгэр домгийг Ир-йёнъ лам зохиол болгосон гэсэн үг юм. Үлгэр домгийн гол сэдэв нь Шилла улс хийгээд Буддын шашинтай холбоотой. “Гурван улсын нөхсөн судар” нь “Гурван улсын түүхэн түүхэн тэмдэглэл”-тэй хамт Солонгосын эртний түүхийн хос багана болсон бүтээл билээ. Ялангуяа Тангүний домгоос авахуулаад идү үсгээр бичигдсэн 14 *хянга* шүлэг багтсан байдаг нь солонгос хэл, утга зохиолын судалгааны гол хэрэглэгдэхүүн болдог. “Кюнъ Йөжөнъ”-ий арван нэгэн хянга шүлэг нь урьд өмнө олны хүртээл болж байгаагүй учраас хянга шүлгийн судалгаанд гол хэрэглэгдэхүүн болдог. Мөн “Их вангуудын магтуу”(제왕운기) - тай хамт Тангүний домгийг уламжилж буй сурвалж бөгөөд Корйё улсын сүүл үе буюу Монголын эсрэг тэмцэх тэмцлийн явцад Тангүнд шүтэх шүтлэг хүчтэй болсны дээр солонгосчуудын нэгэн үндэстэн болохоо ухамсарласан ухамсрын тусгал гэж үзэж болно. 2017 онд Ц.Цэрэндорж монгол хэлээр орчуулж хэвлүүлжээ.

삼국지 Гурван улсын ойллого (三國志, Three Kingdoms) Баруун Жин улс (西晉, 265~ 301 он)-ын Чен

Шоугийн зохиол бөгөөд Сүн улсын Пэй Сөн ши (372-451) агуулгыг нь улам баяжуулж бичсэн Хятадын Гурван улсын үеийн түүхэн зохиол юм. ‘Гурван улсын ойллого’ нь нийт жаран таван бүлэг болно. Үүнд: ‘Вэй улсын бичиг’ гучин бүлэг, ‘Ши улсын

бичиг’ арван таван бүлэг, ‘У улсын бичиг’ хорин бүлэг бий. Гурван улсын ойллого нь агуулгын хувьд Вэй улсын Хуан Чу-гийн анхдагч оноос Жин улсын Тай вангийн анхдагч он хүртэлх жаран жилийн түүхийг бичсэн байна.

삼대목 Самдэмог (三代目, Samdaemok) Нэгдсэн Шилла улсын үед вангийн зарлигаар эмхтгэн бичсэн хянга шүлгийн түүвэр зохиол. “Гурван улсын түүхэн тэмдэглэл”-ээс үзвэл 888 (Чиньсөн хатан вангийн 2-р) онд кагань Вүихон (角干 魏弘), Тэгүхвасан (大矩和尚) нар вангийн зарлигаар эмхтгэсэн гэх боловч уг зохиол нь бидний үед уламжлан ирээгүй. Шиллагийн үеийн хянга шүлгийг түүвэрлэн ангилж эмхэтгэн бичсэн зохиол. Сурвалж бичигт тэмдэглэн үлдээсэн Солонгосын хамгийн анхны шүлгийн түүвэр зохиол болно.

삼별초 Самбйөлцо-Гурван төрөл тусгай цэрэг (三別抄, Sambyeolcho) Корйөгийн үед анх “Ябйөлцо(야별초; 夜別抄)” нэртэй шөнийн эргүүлийн цэрэг байснаа цэргийн тоо нь олшироход зүүн, баруун хоёр хэсэг болгон хуваажээ. Хожим Монголын довтолгооны үед олзлогдож байгаад зугатаж ирсэн цэргүүдээр Бурхны итгэлт цэрэг “Шинь-ыйгүнъ(신의군; 神義軍)” цэргийг зохион байгуулснаар гурван тусгай цэрэг буюу “Самбйөлцо” гэж нэрлэх болжээ. Ерөнхийдөө “Тобан” нь Цой овогтнуудын амь биеийг хамгаалах үүрэгтэй бол “Самбйөлцо” нь цэрэг, цагдаагийн үүрэг гүйцэтгэж байв. Ийнхүү тусгай цэрэг зохион байгуулах хэрэгтэй болсон нь улсын цэрэг нэр төдий болж, үүргээ гүйцэтгэж чадахгүй болтлоо доройтсоны гэрч юм. Хэдийгээр “Самбйөлцо”-гын зардлыг улсын сангаас хангаж, мөн улсын алба үүрэг гүйцэтгэж байсан ч бодот байдалд Цой овогтнуудын хувийн цэрэг байв. Цэргийн эрхтнүүдийн ноёрхол нуран унахад “Самбйөлцо” ч татан буугджээ.

삼한 Гурван Хань, Сам Хань (三韓, Samhan) Эрт үед Солонгосын хойгийн урд хэсэгт оршин байсан гурван аймгийн холбоо. Ко Чосөн-ий урд талд, Солонгосын хойгийн төв болон өмнөд хэсэгт Жин аймаг оршин байв. Жин аймагт олноор нүүдэллэн ирэгсэд нутгийн иргэдтэй нэгдэж, улам хүчирхэгжисний дүнд Ма Хань(마한; 馬韓), Жинь Хань(진한; 辰韓), Пйөнх Хань(변한; 弁韓) нэртэй Гурван Хань(삼한; 三韓) болж

задрав. Энэ үед нэгэнт төр улс бүрэлдэн тогтож байсан болохыг өвөр Кйөнсан мужийн Тахо ли-д хийсэн малтлагаар олдсон эх хэрэглэгдэхүүн, олдвор баталдаг. “Гурван улсын ойллого”-оос үзвэл Жинь Хань нь дорно этгээдэд, Ма Хань нь баруун этгээдэд оршиж байсан хэмээн байршлыг нь тэмдэглэжээ. Эндээс Ма Хань нь одоогийн өвөр Цүнцөн, өвөр Чөлла мужийн нутагт, Жинь Хань нь ар өвөр Кйөнсан мужийн нутагт, Пйөн Хань нь Нагдан мөрний сав газар буюу өвөр Чөлла мужийн зүүн хэсэгт оршин байсныг мэдэж болохоор байна. “Хожуу Хань улсын бичиг(後漢書)”-т Ма Хань нь 54, Жинь Хань нь 12, Пйөн Хань нь 12 жижиг улсаас тогтож байсан хэмээн тэмдэглэжээ. Эдгээр жижиг улсуудын захирагчийг *шиньжи*(臣智), *хөмцыг*(險側), *нүре*(不例), *сархэ*(殺奚), *ыбца*(邑借) гэх зэргээр нэрлэдэг байв. Мөн тэнгэр эзэн гэж нэрлэдэг тахилын ёслолын удирдагч улс бүрт нэг байдаг байсан бөгөөд “*sodo*” гэдэг нэртэй дархалсан газрыг эзэмшдэг байжээ. “*Sodo*”-гийн голд том мод босгож, түүндээ хонх, бөмбөр уяж шашны зан үйлд хэрэглэдэг байсан гэнэ. “*Sodo*”-д хэрэгтэн, ялтан хүн нэвтрэн орвоос түүнийг барьж болдоггүй байв. Түүний тухай судлаачдын хэд хэдэн санал буй ч ариун онгон гэж дархалсан газар байсан гэдэг санал үнэнд илүү ойр мэт. Эртний бөө мөргөл хөгжин өөрчлөгдөж өөрийн хүчээр бурхныг захирах болно гэж үздэг байснаа бурхныг аргадан гуйж тахил тахидаг мөргөл илүү нөлөөтэй болжээ. Тал газар ихтэй тул Гурван Хань-д эрт үеэс тутрагын тариалан хөгжиж, тутрага тариалахад зайлшгүй хэрэгтэй усан санг олноор байгуулж байсан бололтой. Мал аж ахуй ч мөн хөгжиж, тэнгис далайн эрэг хавийн газруудаад загас агнуур хөгжиж байжээ. Ялангуяа Пйөн Хань, Жинь Хань нь төмрийн хүдрээр баялаг тул төмөр үйлдвэрлэж, төмрийг мөнгөн тэмдэгт шиг ашигладаг байв. Газар тариалан нь эдийн засгийн үндэс болж байсан тул хавар үр суулгах, намар ургац хураах үед улирал улирлаар тахил өргөх ёслол гүйцэтгэдэг байлаа. Хавар үр суулгаж дууссаны дараа 5-р сард овог аймгаараа цуглан тэнгэрт тахил өргөж, дуу дуулж бүжиг бүжин ууж иднэ. 10-р сард ургац хураасны дараа талархлын баяр хийдэг байжээ. Ийнхүү дээд доодыг ялгалгүй, нийтээр нэгэн ёслолд оролцох нь овгийн байгууллын үлдэгдэл байсаар байсны шинж юм. Гурван Хань-д морь, үхрийг оршуулах ёслолд хэрэглэж байжээ. Том шувууны далавч хамт хийсэн нь сүнсний

мөнх чанарт итгэх сүсэг бишрэлийг харуулах сонин баримт гэж үздэг. Оршуулах ёслол нь өвөг дээдсийн сүнс ямагт үр ачтайгаа холбоотой байдаг гэсэн итгэлийг мөн өвөг дээдсээ хүндэтгэн шүтэх, бишрэлийг харуулдаг ажээ. Тийнхүү өрхийн тэргүүлэгч юм уу ванг нас эцэслэхэд хүү нь залгамжилдаг ёс тогтохын хамт өвөг дээдэстээ тахил өргөх ёс үүрэг нь болов.

삼화자향 Самхважа нутгийн анагаах ухаан (三和子鄉藥方, Samhwajahyangyakbang) Корйөгийн

сүүл үеэр ихэд дэлгэрсэн анагаах ухааны холбогдолтой ном. Чосөн-ий үед “Ардын анагаах аргын түүвэр (향약집성방; 鄉藥集成方)” хэмээх том эмхтгэл гарах үндэс суурь болжээ.

상대등 Сандэдын (上大等, Sangdaedeung) Шиллагийн үеийн язгууртны төлөөлөл болох

хамгийн дээд албан тушаал. Хамгийн анх 531 (Пөбхын вангийн 18-р) онд ицань(伊飡) Цөлбү(哲夫)-г *сандэдын* болгожээ. Язгууртны хурлыг удирдах үүрэг гол үүрэг нь байв. *Сандэдын* тушаалтнууд нь заримдаа улсын вангаар дэвшин өргөмжлөгдөж, заримдаа улсын вангийн эсрэг тэмцэж байжээ. “Гурван улсын түүхэн тэмдэглэл”-д нийт 43 *сандэдын* тушаалтан гардаг бөгөөд энэхүү тушаал нь Шилла улсыг мөхөх хүртэл хэвээр байв.

상서 Шаншу (尙書, Shangshu) нь Күнзийн суртлын арван гурван номын нэг. Хятадын анхны

төр улсаас Жоу улс хүртэлх хаадын зарлиг бичиг, түшмэдийн өргөх бичиг тэргүүтэй улс төрийн бичгүүдийг эмхтгэсэн ном юм. Күнзийн эмхтгэсэн гэх уг номыг тухайн үеийн төр улсын албан бичгийг цэгцэлсэн гэж үзээд түүхэн зохиолын төрөлд оруулах нь бий. Улс төрийн холбогдолтой бичгийг “шан (尙)” гэх бөгөөд түүн дээр хүндэтгэлийн утгатай “шу” үсгийг залгаснаар “шаншу” хэмээн нэрийджээ.

상서성 Сансөсөн, Дээд бичгийн яам (尙書省, Sangseoseong) Корйөгийн үеийн төв захиргааны

байгууллага. *Сансөсөн* нь төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй зургаан яамыг нэгтгэн захирч байжээ. Үүнд, бичгийн түшмэдийн хэрэг эрхлэх Түшмэлийн явдлын яам(이부; 吏部), цэргийн түшмэдийн хэрэг болон батлан хамгаалах, өртөө

шуудангийн алба эрхлэх Цэргийн яам(병부; 兵部), өрх, хүн ам, алба гувчуурын хэрэг эрхлэх Өрх явдлын яам(호부; 戶部), хууль цааз, зарга шүүх Шүүх яам (형부; 刑部), ёслол, гадаад харилцаа, боловсрол, “орогсдын шалгалт”-ыг хариуцах Ёслолын яам(예부; 禮部), ой мод, загасны нөөц, улсын үйлдвэрлэл, барилга байгууламж зэргийг хариуцах Үйлдвэрийн(공부; 工部) зургаан яам байв.

상정고금예문 Эрт эдүгэгийн ёслолт бичиг (詳定古今禮文, Sangjeong Gogyeum Yemun)”

Корйөгийн Инъжон-ы үед буюу 1234 онд Цой Юнь-ын нарын 17 хүн вангийн зарлигаар , эрт эдүгэгийн ёс журмыг нэгтгэн эмхтгэж бичсэн 50 дэвтэр ном. Хорголжин хэвлэлээр хэвлэсэн анхны ном гэж үздэг. Бидний үед уламжлан ирээгүй. Дайн самууны хөлд үрэгдээд, Чосөнь-ий эхэн үе гэхэд нийт номын аравны нэг, хоёр хувь нь л үлджээ.

서적포 Ном хэвлэлийн газар (書籍鋪, Publishing) Корйөгийн үеийн Төрийн хөвгүүдийн сургуульд харьяалагдах ном хэвлэх газар. 1101 (Сүгжоны 6-р) онд байгуулагдсан бөгөөд Нууц Бичгийн яам (秘書성)-нд хадгалж байсан олон ном болон модон барыг энд төвлөрүүлж, ном болон хэвлэлийн хэргийг эрхлүүлжээ. Цэцэглэн хөгжсөн хувийн сургуулиудтай харьцуулахад харьцангуй сул байсан улсын сургуулийг дэмжих чухал арга хэмжээ байжээ.

서희 *Сөхьи* (徐熙, Seo Hui 942-998) Ицань нутгаас гаралтай, Корйөгийн эхэн үед Хятаны довтолгоог няцаахад гавьяа байгуулсан сайд. *Нэыирийөн* Сөпилийн хүү бөгөөд 960 онд Орогсдын шалгалтанд тэнцсэнээр төрийн алба хаших болж, алба тушаал дэвших замдаа оржээ. Зүүн жигүүрийн сайд байх үед нь буюу 993 онд Хятаны довтолгоон эхлэхэд долоо хоногийн турш хятан нартай хэлэлцээр хийж, ятган сэнхрүүлсээр Хятанг цэргээ татахад хүргэжээ. Дараа жил нь цэрэг удирдан Ялу мөрний хавиархи зүрчидийг хөөн зайлуулж, Чанхын хэрмийг босгосон бөгөөд 994 онд Сөнъжүд хэрэм цайз босгосон байна. Ийнхүү умард хил хязгаарыг бэхлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ.

석가탑 Шагжамуны суврага (釋迦塔, Gyeongju Bulguksa Three-story Stone Pagoda) Ар Кйонсан мужийн Кйонжү хотод байх Пүлгүг хийдийн гурван давхар чулуун суврага. Ар өвөр улсын үе буюу Нэгдсэн Шиллагийн чулуун суврагын хамгийн өргөн тархсан хэлбэр. 1962 онд үндэсний

өвөөр бүртгэжээ. Өөрөөр Мүйөн суврага 무영탑(無影塔) буюу сүүдэргүй суврага гэж бас нэрлэдэг. Асадал, Асанёогийн домогт гардаг Мүйөнъ суврага ч гэж нэрлэдэг Бурхан багшийн суварга нь БНСУ-ын Үндэсний Соёлын өвийн 21 дүгээр үнэт зүйлээр бүртгэгджээ.

석관묘 Чулуун тасалгаат булш (石棺墓, Stone tombs) Солонгосын хойгт ихээр олддог хүрэл зэвсгийн үеийн булш. Олон чулууг өрж тасалгаа болгон хийсэн тул чулуун тасалгаат булш гэж нэрлэдэг.

석굴암석굴 Сөггүр-ам чулуун агуй (石窟庵石窟, Seokguram Grotto) Ар Кйёнсан мужийн Кйёнжү хотын Чиньхйёнъ дон-д байрлах, Нэгдсэн Шилла улсын үед хүний гараар хийсэн чулуун агуй. Уг агуйн дотор Шагжамуни тэргүүтэй 38 ширхэг бурханы дүрийг чулуугаар урлан байрлуулсан байна. 751 (Кйөндөг вангийн 10-р) онд Ким Дэ сөн гэгч анхлан барьж эхлэсэн гэх бөгөөд 774 онд Ким Дэ сөнийг үхсэний дараа Шиллагийн вангийн ордоноос бүрэн барьж дуусгажээ. Японы колоничлолын үед хийсэн хэдэн удаагийн сэргээн засварлах ажлын дүнд анхны байдлаасаа нэлээд өөрчлөгджээ. 1962-1964 онд БНСУ-ын засгийн газрын санхүүжилтээр өргөн хүрээтэй сэргээн засах ажил хийж, анхны дүр төрхөндөө тодорхой хэмжээгээр оржээ. 1995 онд ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын өвд Корйөгийн их хөлгөн судар, Чонмё-гийн хамтаар бүртгүүлсэн байна

석총 Чулуун булш (石塚, Stone grave) Когүрйөгийн эртний булш. Чулууг пирамид хэлбэрээр өрж барьсан бөгөөд Жанжин булш (將軍塚) бол ийм чулуун булшны хамгийн том жишээ нь юм.

선돌 Босоо чулуу (Menhir) Балар эртний үед газрын дээр шүтлэг бишрэлийн зориулалтаар босгосон байгалийн чулуу.

선비 Сяньби (鮮卑, Xianbei) Манжуур, өвөр Монгол, Монгол, Дашин алины нуруугаар нутаглаж байсан Зүүн Ху болон түрэг угсааны аймаг. Мал аж ахуй, ан агнуур эрхлэн амьдардаг байсан нүүдэлчин аймаг. Нэг хэсэг нь хань үндэстэнд уусчээ. Сяньби нар ямар хэлээр ярьдаг байсан талаар маргаантай. Судлаачид түрэг хэлээр ярьдаг байсан гэж үзэж байна. Нанхиад

сурвалжаас үзэхэд эхэн үедээ Хүннүгийн зүүн талд нутаглан сууж байснаа Хүннүг мөхсний дараа хэдэн тийш салаалан нүүдэллэжээ.

선종 Зен буддизм (禪宗, Zen Buddhism) Хятадын эх газарт 5-р зууны үед хөгжиж эхлэсэн Их хөлгөний нэг урсгал. Хятадаас Япон, Солонгос руу дамжиж түгсэн бөгөөд бумбын шашны нөлөө их тусчээ.

설총 Сөлцон (薛聰, Seol Chong 655-?) Нэгдсэн Шиллагийн үеийн гурван их бичгийн хүний нэг бөгөөд идү үсгийг зохиожээ. Вөнхё их багшийн хүү бөгөөд ээж нь Ёсөг гүнж болно. Солонгосын хойгт нэлээд эртнээс нэвтэрсэн ханз үсэг бичиг Когүрё, Пайгжэ, Шилла гурван улсын үед улам өргөн хэрэглэгдэх болжээ. Гэвч гадаад улсын бичиг үсэг болох ханзыг тэр хэвээр нь хэрэглэхэд олон талаар тохирохгүй байсан тул солонгос хэлийг тэмдэглэх өвөрмөц тэмдэглэгээний арга зохиожээ. Тухайлбал ханз үсгийн дуудлагыг юм уу эсвэл утгыг зээлдэн тодорхой дүрэм журмын дагуу солонгос үг тэмдэглэж байжээ. Анхандаа зөвхөн оноосон нэрийг тэмдэглэж байснаа аажмаар улам боловсруулан сайжруулж бүхэл өгүүлбэрийг бичиж тэмдэглэх болжээ. Эхэндээ солонгос хэлний өгүүлбэрийн гишүүдийн байрлалын дэс дараалаар ханз үсгийг жагсаан бичдэг байсан гэнэ. Үүнийг Шиллагийн Сөлцон улам сайжруулан ханз үсгээр хэлзүйн холбоосуудыг нөхөж, өгүүлбэрийн утгыг яруу тодорхой болгосон ба ингэж “Идү” үсэг мэндэлжээ. Шиллачууд энэхүү “Идү” үсгээр ардын дуу *Хянга*-г тэмдэглэн үлдээжээ. “Идү” үсгийг улам сайжруулах зорилгоор “*хянцал*” үсгийг зохиосон боловч туйлын ээдрээтэйн дээр солонгос хэлийг төгс сайн тэмдэглэж чадахгүй байсан тул удаан хэрэглээгүй байна. Есөн судар (九經)-ыг тайлбарлан уншуулж, шавь нартаа сургааль номоо өвлүүлжээ. Шинь мүнъ ванд “*Хваванге*” хэмээх шүлгийг зохиож өргөн барьсан бөгөөд төрийн албанд таарах тохирох зөв хүнийг сонгон ажиллуулахын чухлыг онцлосон утгатай.

성골 Ариун ястан (聖骨, Seonggol) Шиллагийн “*колхүм*” тогтолцооны дээд зэрэг. Энэ тогтолцоо нь хүнийг ясны шинж, өөрөөр хэлбэл цусны цэвэр ариун байдлаар нь эрхэм язгуурлаг, эгэл бор хэмээн тогтоож, хэргэм цол, алба тушаалаас эхлээд өдөр

тутмын ахуй амьдралд нь хүртэл онцгой эрх ямба олгодог эсвэл хязгаарладаг тогтолцоо юм. “*Колхүм*”-ыг дотор нь ариун ястан, жинхэнэ ястан гэж хоёр хуваагаад түүнээс доош зургаан “*түлхүм*”-д хуваадаг. “Ариун ястан” нь Ким овогтноос зөвхөн вангийн угсаа залгамжлагчид л багтах хамгийн дээд зэргийн “*колхүм*” байснаа хожим үгүй болжээ. Жинхэнэ ястан ч мөн Ким овогтнууд хэрнээ вангийн угсааны бус хүмүүс бөгөөд “Ариун ястан” устан үгүй болсон хойно ван угсааг залгах болжээ. Тэрчлэн эртний вангийн болон вангийн хатны угсааны Пак овогтнууд, Понь Каяагийн вангийн угсаа болох шинэ Ким овогтнууд “жинхэнэ ястан”-д багтдаг байв. Адилхан вангийн угсааныхан хэрнээ “ариун ястан”, “жинхэнэ ястан” гэж хуваадгийн шалтгаан тодорхойгүй ч эхийн талын удмаас шалтгаалж байсан мэт байна.

성균관 *Сөнгюүнъгванъ* (成均館, Sungkyunkwan) Корйөгийн сүүл үе, Чосөнъ-ий үеийн боловсролын дээд байгууллага. Корйөгийн Чхүнсөнъ вангийн үеэс Сөнгюүнъгванъ хэмээн нэрлэх болжээ. Кон Минъ вангийн үед нэг хэсэг Төрийн хөвгүүдийн сургууль гэж нэрлэж байснаа буцаад Сөнгюүнъгванъ болгожээ. Чосөнъ-ий сүүл үеийг хүртэл төрийн албанд ажиллах албан хаагч, түшмэдийг бэлдэх дээд боловсролын байгууллагын үүрэг гүйцэтгэж байжээ.

성덕대왕신종 *Сөндөг вангийн бурхны хонх* (聖德大王神鐘, The Bell of King Seongdeok)

Нэгдсэн Шиллагийн үед хүрлээр бурхан, хонх цутгах урлаг ихэд хөгжжээ. Хэдэн зуун кг зэс, цайр хольж цутгасан Хванрён хийдийн хонх, Сөндөг ванд зориулсан “Бурхны хонх” нь бараг цэврүүгүй, цэвэр сайхан хийцтэй бөгөөд тунгалаг дуутай. Орчин үеийн техник технологийн хөгжлийн төвшинд ч ийм хонх хийж чадахгүй байгаа ажээ. Өндөр нь 3.75m, өргөн нь 2.27m, 11~25 см зузаантай, 1997 онд Кйөнжүгийн Үндэсний Музейгээс 18.9 тонн жинтэй хэмээн хэмжижээ. Шиллагийн Кйөндөг ван өөрийн аав Сөндөг вангийн үйл хэрэгт зориулан уг хонхыг хийх гэж зорьсон боловч чадаагүй байна. Хэгон ван 771 онд уг хонхыг бүтээлгэж чадаад Сөндөг вангийн бурхны хонх гэж нэрийджээ. Эхэн үедээ Пондөг хийдэд өлгөж байсан тул Пондөг хийдийн хонх гэж нэрлэж байв. Мөн уг хонхыг үйлдэхэд хүүхдийн амийг өргөсөн гэдэг домогтой бөгөөд хүүхдийн уйлах чимээг дуурайн Эмэллэ хонх гэж нэрлэх нь ч бий.

성리학 Күнзийн суртлын шинэ урсгал, *Сонри хаг* (性理學, New-Confucianism) 12-р зуунд Өмнөд

Сүн улсын күнзийн сурталт эрдэмтэн Жү ши-гийн гаргасан шинэ урсгал. Үндэслэгчийх нь нэрээр Жүши суртал (朱子學) гэж бас нэрлэдэг. Юань улсын сүүл үеэс Корйө руу нэвтэрсэн бөгөөд Чосөнъ улсын төрийн үзэл суртал болгон улам хөгжүүлжээ. Өмнөд Сүн улсаас үүсч гарсан уг сурталаас хүний өдөр тутмын амьдралд ёс зүйг чухалчлах талыг илүү тусган хүлээж авчээ. Харин аажмаар хүн, сансар ертөнцийн үүсэл гарлыг метафизик байдлаар тайлбарлах гэсэн гүн ухааны тал нь илүү хөгжсөн байна. Албат түшмэд нь эзэн вандаа үнэнч байхыг чандлан сургаж, бусад шашинд эрс хатуу байр суурьтай хандаж байв. Шинэ хүнзийн суртлыг анх Корйө-д нэвтрүүлсэн хүн бол Анъ хян юм. Хожим нь Пайг И жөнъ бас Юан улсад хүнзийн суртлын шинэ урсгал сурч ирсэний дараа шавь И Жай хйөнъ багшийгаа залгамжилжээ. Корйө-гийн сүүл үеийн алдартай, хүнзийн шинэ сурталтнууд бол И Сүн инъ, Жөн Мон жү, Жөн До жөнъ, Кил жай, Квөнъ гынъ нар болно.

세속오계 Хорвоогийн таван журам (世俗五戒, Secular five precepts) Шиллагийн Чиньпйөнъ

вангийн үед Вөнъгванъ(圓光) хуврагийн *хваран* нарт зориулан сургасан таван сургааль. Эзэн вандаа үнэнч байх, эх эцэгтээ ачлалтай байх, найз нөхөртөө журамтай байх, дайны талбарт шантарч ухрахгүй байх, амьтны амийг хамаагүй хороохгүй байх гэсэн таван зүйл болно. *Хваран* нар эдгээр таван журмыг эндэхгүй дагахыг чухалчилдаг байв.

세형동검 Нарийн хүрэл сэлэм (細形銅劍, Thin Bronze Sword) Нарийн хүрэл сэлмийг хүрэл

зэвсгийн үе болон төмөр зэвсгийн эхэн үед хамаатуулж үздэг. Солонгосын хүрэл зэвсгийн олдворууд дундаас хамгийн өвөрмөц онцлогтой олдвор бол нарийн хүрэл сэлэм юм.

소도 *Codo* (蘇塗, Sodo) Гурван улсын үеийн тахил өргөх газар, өөрөөр хэлбэл дархалсан нутаг.

Овгийн нэгдлийн үед шашин, улс төр хоёр нийлэг байдалтай байснаа засаглал хүчирхэгжихийн хамт аажмаар салсан байна. Эрх баригчид эдэлж буй эрх дархдаа сэтгэл ханаж, шашны шинжтэй ямарваа ёслолыг тахилч нарт ногдуулсны учир юм. Гурван Ханъ-д энэ тахилчийг Тэнгэрийн хаан гэж нэрлэдэг ба “*codo*” нэртэй тусгай гацааг ахалдаг байжээ. “*Codo*”-гийн голд том мод босгож, түүндээ хонх, бөмбөр

уяж шашны зан үйлд хэрэглэдэг байсан гэнэ. “Codo”-д хэрэгтэн хүн нэвтрэн орвоос түүнийг барьж болдоггүй байв. Түүний тухай судлаачдын хэд хэдэн санал буй ч ариун онгон гэж дархалсан газар байсан гэдэг санал үнэнд илүү ойр мэт. Эртний бөө мөргөл хөгжин өөрчлөгдөж өөрийн хүчээр бурхныг захирах болно гэж үздэг байснаа бурхныг аргадан гуйж тахил тахидаг мөргөл илүү нөлөөтэй болжээ. Вангийн засаглал хүчтэй болохын хэрээр ван өөрөө тахилчийн үүрэг гүйцэтгэх хэрэггүй болсноор улс төр, шашин хоёр салжээ.

소수림왕 Сосүрим ван (小獸林王, King Sosurim 371-381) Гурван улсын үеийн Когүрйө-гийн

17-р ван. Когүгвөнъ ван(331-371)-гийн үед Мү рун овгийн Чянь Янь(전연; 前燕) хийгээд Пайгжэгийн довтолгоонд Когүрйө ихэд сульдаж, үүнийг даван туулахын тулд, засаглалын тогтолцоог боловсронгуй болгох шаардлага гарав. Энэ үүргийг Сосүрим ван гүйцэтгэжээ. Сосүрим вангийн 2-р(372) онд бурхны шашныг нэвтрүүлж Тхайхаг(태학; 太學) хэмээх сургууль байгуулж, дараа жил нь хууль тунхаглажээ. Бурхны шашин улс орныг оюун санааны хувьд нэгтгэхэд тус болсон бол, эрдмийн хүрээлэн нь засаг захиргааны тогтолцоог, хууль тунхагласан нь төрийн тогтолцоог боловсронгуй болгоход алхам болжээ. Харамсалтай нь тэрхүү хуулийн агуулга уламжлагдаж ирсэнгүй.

소학 Бага суртахуй (小學, Xiaohak) Сүн улсын күнзийн сурталт эрдэмтэн Люү Зи чен(劉子澄)бээр найм

есөн настай хүүхдүүдэд күнзийн сурталыг заахын тулд 1187 онд зохиосон сурах бичиг. Зарим судлаач Сүн улсын Жүзы зохиосон гэдэг боловч Жүзы-гийн удирдлаган дор түүний шавь Люү Зи чен эмхэтгэжээ. Дотоод 4 дэвтэр, гадаад 2 дэвтэр, нийт 6 дэвтэр юм.

송 Сүн улс (宋, Sòng Dynasty 960-1279) Тан улс мөхсний дараа 10-р зууны сүүлээр Сүн улс түүхийн

тавцнаа гарч 300 жилийн турш оршин тогтножээ. Сүн улс нийслэлээ өмнөдийн Ханжоу хот руу нүүлгэн суурьснаас хойш Өмнөд Сүн гэгдэх болжээ. Монголчуудын байлдан дагуулалд өртөх хүртлээ энх тайван байдалтай байв. Хэдийгээр хүчирхэг улс байгуулаагүй ч гэлээ газар тариалан, технологи, аж үйлдвэр, худалдаагаа гайхалтай хөгжүүлж чаджээ. Тан улсын үеэс эхлэсэн эдийн засгийн хөгжилд суурилан улс орноо хөгжүүлсэн бөгөөд газар

тариалангийн бүтээгдэхүүн огцом нэмэгдсэн байна. Анх удаа хүн амын тоо зуун саяас давжээ. Корйөтой найрсаг харилцаатай байж, худалдаа хийдэг байв.

송악 Сон-аг (松岳, Songak-myeon) Корйөгийн нийслэл хот бөгөөд таван зуу гаруй жилийн турш цэцэглэн хөгжсөн эртний хот юм. Кэсөн, Кэгийн(開京), Сон-аг(松岳), Сондо(松都), Сонгийн(松京) зэрэг олон нэртэй байжээ.

수 Суй (隋, Sui Dynasty, 581~ 619 он) бол Умард Өмнөд Ханлиг улсуудын самуунт үеийг даван туулаад Хятадыг нэгтгэсэн хаант улс юм. Соёл, барилга байгууламж ихэд хөгжиж, бат бөх удаан эдэлгээтэй чулуун гүүр хийх арга гаргаснаас гадна Их татмал гол хэмээх усан сувгийг байгуулсан нь тухайн үедээ дэлхий дахин дахь хамгийн том бүтээн байгуулалт болжээ. Ян хуандигийн зарлигаар татварыг нэмж, хүмүүсийг сая саяар нь барилгын ажилд албадан дайчилсан нь улс мөхөх нэгэн шалтгаан болжээ.

시랑 Жигүүрийн сайд (侍郎, Sirang) Жигүүрийн сайд хэмээх тушаал нь эртний Хятадын Хань улсын тогтолцооноос уламжлалтай. Солонгост Шилла улсын үед уг албан тушаалыг ордонд бий болгожээ. Корйөгийн Чүнсө мүнхха сөн болон Сансө югбү-гийн дэд сайдын тушаалтай дүйнэ.

시어사 Дэслэн байцаагч сайд (侍御史, Lee Se-hwa) Корйөгийн үеийн түшмэдийг хянан шалгах газар болох *Өсадэ*-гийн дэд сайд.

시조 Шижо (時調, Sijo) Корйөгийн сүүл үе, Чосөн-ий эхэн үед түгж дэлгэрсэн яруу найргийн нэгэн төрөл.

신기군 Бурхны морьт цэрэг (神騎軍, Singigun) Корйөгийн үеийн Тусгай цэрэг(別武班)-ийн нэг. Тусгай цэрэг нь Бурхны морьт цэрэг, Бурхны явган цэрэг, Ад чөтгөрийг дарах цэрэг гэсэн гурван цэргээс бүрддэг байв.

신돈 *Шиньдонь* (辛屯, Shin Don ?-1371) Корйөгийн сүүл үе буюу Конминь вангийн үед улс

төрийн шинэчлэлтийг удирдан хийсэн хувраг. Ээж нь Кесон хйөнъ-ий Огчөнъ хийдэд шивэгчин байсан ба бага насандаа сахил хүртжээ. 1358 онд Ким Вөнъ мйөн-ий тусламжтайгаар ванд бараалхаж, 1364 оноос төрийн хэрэгт зөвлөх үүрэг гүйцэтгэж эхлэсэн байна. 1365 онд И Гү сү, Ян Бэг иг, Пак цүнъ зэрэг эсрэг хүчний этгээдүүдийг улс төрөөс зайлуулж чаджээ. 1365 оны 7-р сард *чиньпйөнхү*(眞平侯) цолоор өргөмжлөгдөж, 12-р сард төрийн эрхийг атгаад нэрээ Тон хэмээн өөрчилжээ. Мөн ванд “Газрын хэргийг засан тохинуулах тамгын газар” байгуулахыг зөвлөж, өөрөө шүүгч нь болоод(Кон минь вангийн 15-р, 1366 он), эрхэт гэр бүлүүдийн булааж авсан газар болон боолчуудыг хуучин эздэд нь буцааж, тариачин гаралтай боолчуудыг боолоос чөлөөлсөн байна. 1370 онд Конминь ван төрийн хэргээ өөрөө биечлэн удирдах болсноор Шиньдонь ламын хүч нөлөө буурчээ. 1371 онд вангийн эсрэг хуйвалдаан зохиосон боловч амжилтгүй болж баригдаад Сүвөнъ руу цөлөгдсөн байна. Тун удалгүй цаазлагджээ.

신라 *Шилла, Силла* (新羅, Silla, НТӨ 57он – 935он) Шилла нь Когүрйө, Пэгжэ-тэй хамтаар

Гурван улсыг бүрдүүлж явсан улс. Мөн хожим Бохай-н хамтаар Өмнөд Умард улсыг бүрдүүлж явсан улс бөгөөд дэлхийн хамгийн урт түүхтэй вант улсын нэгд зүй ёсоор тооцогддог. НТӨ 57 (Хйөггөсэ кесөганы 1-р) оноос 935 (Кйөнсүнъ вангийн 9-р) он хүртэл 992 жилийн турш оршин тогтносон эртний улс. Кйөнжүгийн тал нутагт зургаан овог нэгдснээр Шилла улс үүсчээ. Каяа аймгийг өөртөө нэгтгэж, Хятадтай харилцах гол гарц болох Хан мөрний сав нутгийг эзлэснээр хүчээ бэхжүүлжээ. 7-р зууны дундуур Тан улстай цэргийн холбоотон болсоны үндсэн дээр Когүрйө болон Пэгжэг өөртөө нэгтгэжээ. Энэ үеэс Умард Өмнөд улсын үе эхлэнэ. Шиллагийн сүүл үеэр вангийн суурьны төлөөх тэмцэл ширүүсч, нутгийн эрхтнүүд толгой өндийлгөснөөр вант засаглал доройтжээ. Эцэстээ Хожуу Гурван улс болон хуваагдсан бөгөөд Кйөнсүнъ ван Корйөгийн Вангөнъ-д бууж өгөн дагаар орсноор Шилла улс мөхжээ.

신라방 *Шилла бан* (新羅坊, Sillabang) Шилла нь их улсад алба өргөх үед л тэнгис гатлан Тан

улсад очиж, бага сага бараа солилцоо хийдэг байснаа Нэгдсэн Шиллагийн үед Тан

төдийгүй, Япон хүртэл тэнгис гатлан очиж арилжаа наймаа хийдэг худалдаачид бий болж, иргэд хоорондын гадаад худалдаа хөгжжээ. Энэ бол хувийн худалдаачдын хүчтэй хэсэг бүлгүүд бий болсныг илтгэн харуулна. Японы Цүшима арал дээр шиллачуудтай хэл нэвтрэлцүүлэх, хэлмэрчлэх үүрэг бүхий тамгын газар байгуулж байжээ. Улмаар Шиллачууд байнга зорчдог Шаньдуны хойг (산동반도; 山東半島) гэх мэт газар тэдний оршин суудаг газар бий болсон бөгөөд түүнийг “*Шилла бан*” гэж нэрлэх болжээ.

신라소 *Шилла со* (新羅所, Sillaso) Нэгдсэн Шиллагийн үед Тан улсад, Шаньдуны хойг хавьцаа суух болсон Шиллачуудыг харж хянах үүрэгтэй албан газар бөгөөд түүнд шилла хүн ажилладаг байжээ. *Шилла бан*-д суудаг шиллачууд нь тэнгисийн эрэг хавийн Тэнжоу, Сүжоу, Ханжоу, Янжоуд *шилла со* байдаг байв.

신라원 *Шилла вонь* (新羅院, Sillabang) Нэгдсэн Шиллагийн үед Шаньдуны хойг хавьцаа суурин суух болсон шиллачууд тэндээ сүм хийд босгож, тэнгисийн аянд амар мэнд байлгахыг гуйн залбирч мөргөдөг байсан сүм.

신석기시대 *Шинэ чулуун зэвсгийн үе* (新石器時代, Neolithic age) НТӨ 10000-3000 жилийн хооронд үргэлжилсэн түүхэн үеийн нэг. Шавар эдлэлийн хийц хэлбэрт гарсан өөрчлөлтөөр баримжаалан шинэ чулууны үеийг эрт, дунд, хожуу гэж гурван үед хуваадаг. Шинэ чулууны дунд үеийн хүнийг эртний зүүн ази үндэстний өвөг гэж ихэнх эрдэмтэд үздэг боловч үүнийг батлах баримт хараахан үгүй байна. Юутай ч хятад үндэстнээс өөр, төв азиас гаралтай үндэстэн гэдэг нь тодорхой бөгөөд эдгээр шинэ чулууны үеийн хүний удам угсаа тасралгүй явсаар өнөөгийн солонгос үндэстэн бүрэлдэн тогтоход хувь нэмэр болсон гэж эрдэмтэд үздэг.

신집 *Шинъжиб* (新集, Shinjip) Когүрйөд 600 (Йёняан вангийн 11-р) онд Тхэхаг пагса И мүнъ жинъ гэгч вангийн зарлигаар зохиосон Солонгосын түүх. Юүги (留記) хэмээх зуун дэвтэр зохиолыг товчлон эмхэтгэж бичсэн гэх бөгөөд Когүрйө улсын хөгжлийг дагаад төр улс байгуулагдсан цагаас хойшхи түүхийг эмхэтгэн бичих хэрэгцээ шаардлага гарснаар Шинъжиб-ыг туурвисан хэмээн таамагладаг. Нийт таван дэвтэр зохиол байсан бөгөөд бидний үед уламжлан ирсэнгүй.

실록 Үнэн магад тэмдэглэл (實錄, Annals of the Joseon Dynasty) Зүүн Азийн түүх бичлэгийн

хэлбэр. Он дараалсан бичлэгийн хэлбэртэй бүх түүхийг ерөнхийд нь нэрлэсэн нэр. Хятад, Солонгос, Япон, Вьетнам зэрэг улсын түүхэн дэх төрт улсууд нь “Үнэн магад тэмдэглэл”-ий бичиж эмхтгэж ирсэн бөгөөд орчин цагт ч бичиж эмхтгэсээр байгаа ганц улс гэвэл хаант засаглалтай Япон юм. “Үнэн магад тэмдэглэл” гэдэг нь “үнэхээр болсон хэргийг бодитой тэр чигээр нь бичиж тэмдэглэнэ” гэсэн утгатай ажээ. Эртний Хятадад хуандигийн өдөр тутмын амьдралд тохиолдсон үйл явдлыг сударч түшмэл бичиж тэмдэглэдэг явдлаас үүссэн бөгөөд сударч түшмэдийн тэмдэглэлийг *сачо*(史草) гэж нэрлэнэ.

십이도 Шиб и до, Арван хоёр сургууль (十二徒, Twelve degrees) Корйө-гийн феодал

язгууртнуудын угсаа язгуурыг эрхэмлэн дээдэлдэг зан суртал нь хүнзийн сурталд мөн нөлөөлж, хүнзийн сурталд боловсруулдаг олон Хувийн сургууль шинээр бий болов. Мүнъжон-гийн үед(1046-1083) суурь нь тавигдсан, ”Дорнын Хүнз” гэж алдаршсан эрдэмтэн Цой цүн(최충; 崔冲) есөн зүйлийн эрдэмд боловсордог “Есөн дамжаат сургууль(구재학당; 九齋學堂)” байгуулсныг *Цойгондо*(최공도; 崔公徒) гэж нэрлэдэг. Энэ бол анхны хувийн сургууль юм. Тухайн үед *Цойгондо* тэргүүтэй арван хоёр хувийн сургууль байсан тул *Шиб и до*(십이도; 十二徒) гэж нэрлэжээ. Цой цүн, *мунъха шижүн*(문하시중; 門下侍中) гэдэг нэг ёсны Ерөнхий сайдын албан тушаал хашиж байсанчлан Арван хоёр сургуулийг үндэслэн байгуулагчид нь их төлөв өндөр цол хэргэмтэй түшмэл асан, эсвэл тухайн үеийнхээ их эрдэмтэн, Орогсдын шалгалтын шалгагч түшмэл(*чигонгө*; 지공거) нар байжээ. Эдгээр хүчин зүйлийн улмаас эрхтэн дархтнуудын үр хүүхдүүд албаны сургууль болох Төрийн хөвгүүдийн сургуулиас илүү Арван хоёр Хувийн сургуульд сурахыг нэр төртөйд үзэх болж түүний үр дүнд сурсан сургуулиараа бүлгэрхэх, зиндаархах болжээ.

쌍성총관부 Сансөн-ы хэрэг эрхлэх газар (雙城總管府, Ssangseong Prefecture) Корйөгийн сүүл

үед монголчууд Корйөгийн Хуажү(和州 : одоогийн өвөр Хамгён мужийн Йөнхын) - гаас хойшхи нутгийг захиргаандаа оруулахын тулд байгуулсан албан газар. Угтаа энэ газарт Корйөгийн засаг захиргаа төдийлөн хүрч чаддаггүй байжээ. Нүүдэллэн ирсэн корйөчүүд

болоод зүрчидүүд холилдон амьдардаг байв. Монгол Корйөгийн дайны үед буюу 1258 онд Ёнжинь хёнь(龍津縣) -ы Чохүи(趙暉) , Чөнжүгийн Тхагцөн(卓青) гэдэг хоёр хүн Корйөгийн нутгийн захирагчийг хороогоод Монголд дагаар оржээ. Энэ үед монголчууд энэ нутагт уг хэрэг эрхлэх газрыг байгуулж, Чохүи-г ерөнхийлөн захирагчаар, Тхагцөн-ийг түмтийн ноёноор тавьжээ. Хожим тэдний үр хүүхдүүд энэ нутгийг үе улиран захирчээ.

아비지 *Абижи* (阿非知, Abiji ?~?) “Гурван улсын нөхсөн судар”-т гардаг Хванрйөн хийдийн 9

давхар суврагыг барьсан Пэгжэгийн урчин. Шиллагийн Сөнъдөг хатан вангийн 2-р он буюу 643 онд Тан улсад суралцаад нутагтаа буцаж ирсэн Чажан юүлса бээр “Хванрйөн хийдэд 9 давхар суврага барьвал эргэн тойрны 9 улс алба барин дагаж орох болно” гэжээ. Ингээд Шиллагийн засаг газраас уг суврагыг бариулахын тулд Пэгжэгээс урчин явуулж өгөхийг хүсчээ. Шилла улс торго дурдан, алт эрдэнэсийг Пэгжэ рүү илгээн урчин явуулахыг хүсэв. Хүсэлтийн дагуу Пэгжэ улс Абижи-г илгээжээ. Шиллагийн талаас уг суврагыг бариулах ажлыг иганъ(伊干) Ким Ён цүнъ-д даалгасан байна. Гэтэл Чажан юүлса-гийн хэлсэн дагаж орох ёстой 9 улсын нэг нь Абижи-гийн эх орон болох Пэгжэ улс байв. Суврагын гол баганыг босгох өдөр Абижи өөрийн эх орон Пэгжэгийн нийслэл галд шатаж байна гэж зүүдлээд сэжиглэн гайхаж, суврагыг босгох ажилд оролцохоо болихоор шийднэ. Гэтэл тэр даруй газар хөдлөж, харанхуй болов. Харанхуйн дундаас нэгэн өндөр настай хуврага, хүчир эр хоёр гарч ирээд суврагын голыг босгоод хаашаа ч юм алга болов. Үүнийг үзсэн Абижи Пэгжэ улсын мөхөл ирснийг ойлгоод 9 давхар суврагыг барьж дуусгажээ. Уг суврагыг босгосноос хойш хорин жилийн дараа Пэгжэ улс мөхсөн бөгөөд 13-р зуунд Монголын эзэнт гүрний дөрөвдүгээр довтолгооны үеэр Хванрйөн хийдийн 9 давхар суврага шатаж устжээ. Дахин сэргээн босгож чадаагүй байна.

아직기 *Ажигги* (阿直岐, Achika) 4-р зууны сүүлийн хагасаас 5-р зууны тэргүүн хагас. Пэгжэ-

гийн Кынцого вангаас Ашинъ вангийн үед соёл болоод эрдэм мэдлэгийг Японд түгээн дэлгэрүүлсэн эрдэмтэн. Японы сурвалж бичиг болох “Японы тэмдэглэл (日本書紀)”, “Эртний хэргийн тэмдэглэл (古事記)” зэрэгт нэр нь гардаг бөгөөд Ажигги-гээс гадна Ажигилса нэрээр гардаг. Японд хүнзийн суртлын ном судрыг

тайлбарлан заадаг байжээ. Ажигги нь Яматогийн засаг газарт бичиг тэмдэглэлийг хариуцсан *ачикигинохүмихито* (阿直史) хэмээх албан тушаалыг хашдаг байжээ.

안록산의 난 **Ань Лушаны бослого** (安祿山-, An Lushan Rebellion) Тан улсын, хүннү угсаатай, цэргийн жанжин Ань Лушан 755 онд цэргээ хөдөлгөсөн бослого. Тэрбээр нийслэл хотыг эзлэж авсныхаа дараа өөрийгөө эзэн хаан хэмээн зарласан байна. Зургаан сарын дараагаар түүний хүч улсын баруун хэсгийн нийслэл Чан ань-ыг эзлэн авчээ. Тэрээр 757 онд алагдаж, эхлүүлсэн бослого нь 763 онд дарагдсан юм. Уг бослогын улмаас Тан улсын хүчин чадал ихэд суларч доройтжээ.

안동도호부 **Аньдоны захиргаа** (安東都護府, Andong Dohobu) Шилла улс Пайгжэ болоод Когүрйөг дарахдаа Тангийн цэрэг зэвсгийн тусламжийг авсан нь эргээд хүнд дарамт болжээ. Тан улс Тайдон мөрний урд хэсгийн нутгийг Шиллад өгнө гэж тохирсон боловч, амласнаа биелүүлсэнгүйгээр үл барам Солонгосын хойгийг тэр чигээр нь эзэгнэх гэсэн санаархал нь илрэн гарчээ. Тан улс Пайгжэгийн газар нутгийг захирахын тулд Үнжиньг тохинуулах яам байгуулаад(665) Пайгжэгийн ард иргэдийг аргадан тайвшруулахын тулд захирагчаар нь Ыижа вангийн хүү Пү Йө рюнг томилжээ. Когүрйөгийн нийслэл Пхйөнянд “Аньдоны захиргаа” байгуулж(668) шууд захирах болсон ба холбоотон Шиллагийн нийслэл Кйөнжүд хүртэл Керим-ийг тохинуулах их яам байгуулж, Мүнъмү ванг Керим мужийн захирагчаар томилжээ. Тангийн энэ мэт шунахай санаархал нь Шилла болоод Тангийн хооронд Солонгосын хойгийн төлөө ширүүн тэмцэл өрнөхөд хүргэжээ. Ань лушаны бослогын улмаас 756 (Кйөндөг вангийн 15-р) онд Аньдоны захиргааг татан буулгасан ажээ.

안승 **Аньсын** (安勝) 7-р зуун. Когүрйөгийн сүүл үеийн вангийн угсааны хүн. Пожан вангийн татвар эмээс төрсөн хүү бөгөөд Когүрйөг мөхсний дараа Көмможам (劍牟岑) гэгч түүнийг вангаар өргөмжилжээ. Кыммажө (金馬渚) гэдэг газарт байхад нь Шиллагийн зүгээс түүнийг Когүрйө ван, Подөг ван (報德王)-гаар өргөмжилж байв. Тан улсын цэрэг довтлон ирэхэд хэрхэх талаар Көмможамтай санал зөрөлдөж, эцэст нь хорлогдож үхжээ.

안시성 **Аньши хэрэм** (安市城, Ansi city) Гурван улсын үед Когүрйөгийн Ляо мөрний сав газар байгуулсан бэхлэлт хэрэм. 645 онд Тан улсын довтолгооныг уг хэрэм дээр няцаасан байна.

안시성 전투 Аньши хэрмийн тулаан (安市城戰鬪) 645 онд Когүрйөгийн цэрэг Тан улсын цэргийг Аньши хэрмээс няцаасан тулаан. Аньши хэрэм бол Ляодуны хойгт орших хэрэм бөгөөд стратегийн чухал байрлалд байв. Суй улсыг залгамжлан гарч ирсэн Тан улс нь дэлхийн эзэнт гүрэн болох зорилгынхоо дагуу гадагш байлдан дагуулалт хийж байв. Энэ үед Когүрйөд Йөнгэ сомүнъ төрийн эргэлт хийн эрх барих болсон бөгөөд гадаад харилцаандаа хатуу бодлого барих болсон байна. Тан улсын тайзун бээр, Йөнгэ сомүнъ-ийг улсынхаа ванг хороосон тул шийтгэнэ гэдэг нэрийдлээр цэргийн довтолгоон өргөн хүрээтэй хийжээ. Ингээд 645 онд Ляодуны хойгийг эзлэж авсан байна. Улмаар Аньши хэрэмд тулж ирээд жар гаруй хоногийн турш өдөрт 5-6 удаа дайраад уг хэрмийг эзлэж авч чадаагүй байна.

안향 **Аньхян** (安珣, An Hyang 1243-1306) Корйөгийн сүүл үеийн эрдэмтэн, сайд. Нууц бичгийн яамны дэс зарагсад Аньбү-гийн хүү бөгөөд 1260 онд Орогсдын шалгалтад тэнцсэнээр алба тушаал дэвших зам нь нээгджээ. Цүнрйөл ван(1274-1308)-гийн үед Аньхян(안향; 安珣) нарын хүчин зүтгэлээр Төрийн сургууль(국학; 國學), Хүнзийн тахилгын өргөө(문묘; 文廟) зэргийг шинэчлэн байгуулж, хүнзийн суртлыг дэмжин хөгжүүлэв. Юань улсаас Күнзийн суртлын шинэ урсгалыг Корйөд нэвтрүүлсэн бөгөөд 1289 онд Цүнрйөл ванг даган Юань улсад очоод ирэхдээ Күнз болон Жүзы-гийн хөрөг зураг, Жүзы-гийн зохиол бүтээлийг авчирчээ.

압록강 **Ялу мөрөн, Үнэгэн гол** (鴨綠江, Yalu river) Пэгдү уулнаас эх аваад Солонгос, Хятадын хилийн заагаар урссаар Шар мөрөнд цутгадаг мөрөн. 803,3 км урттай, нийт сав газрын талбай нь 31,226 km² Солонгосын хамгийн урт мөрөн болно.

애니미즘 **Анимизм** (Animism) Нар, сар, од зэрэг тэнгэрийн эрхэс болон хад чулуу, гол мөрөн, далай тэнгис зэргийг бурханшуулж, байгалийн үзэгдлийг сүнстэй, амьд хэмээн тайлбарладаг балар эртний шүтлэгийн хэлбэр. Байгалийн бүх юмс үзэгдлийг амьтай гэж гэж үздэг үзэл.

어사대 Өсадэ (御史臺 хожмын *Сахонъбү*; 사헌부; 司憲府, Eosadae) Корйөгийн үеийн, төрийн хэргийн зөв бурууг шүүж, түшмэдийн бусармаг зальхай явдал үйлийг засах үүрэгтэй хянан шалгах газар. Түүний сайд нь түшмэд сайд нарыг томилох, хууль тогтоох цуцлах зэрэг чухал хэрэг шийдэхэд гарын үсэг зурж баталгаажуулах эрх үүрэгтэй байсан тул вангийн хэмжээгүй эрхт засаглал тогтохоос сэргийлэх, өөрөөр хэлбэл эрх мэдлийг тэнцвэржүүлэх чухал үүрэгтэй байжээ.

여진 Зүрчид, Зөрчид, Жүрчид (女眞, Yeojin, Jurchen) Манжуурт нутаглаж байсан сушень, мохай нарын үр хойч. Тунгус угсааны аймаг.

역분전 Йөг бүнь жөнъ (役分田, Yeokbunjeon) Корйөгийн Тайзу-гийн 23-р(940) оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн газар өмчлүүлэх журам. Эзэн вандаа хэр үнэнч болох, улс гэрийг байгуулахад ямар гавьяа байгуулсныг шүүн тогтоож, түүнд нь тааруулан тодорхой хэмжээний газар хуваарилж олгох журам.

연개소문 Йөнъ ге со мүнъ (淵蓋蘇文, Yeon Gaesomun ?-666 он) Гурван улсын үеийн Когүрйөгийн 28-р ван болох По Жан вангийн үеийн жанжин., түшмэл. Суй улсыг залган гарч ирсэн Тан улсаас сэргийлж Когүрйө хилийн дагуу мянган ли(400 км) урт хэрэм барьжээ. Энэ үед ноёлогч ангийн дотор хагарал гарч Йөнъ ге со мүнъ гэгч ван болоод вангийн талынхныг хүйс тэмтэрч, өөрийн дарангуйллыг тогтоов (Пожан вангийн тэргүүн он буюу 642 он). Тэрбээр гадаад бодлогодоо эрс хатуу байр суурь баримталж, Шилла болон Тан улсыг эвлэршгүй дайснаа гэж үзэж байв. Жишээлбэл Шиллагийн Ким Цүнъ цү тусламж гуйн ирэхэд, Ханъ мөрний сав газрын хуучин эзэмшил нутгийг буцааж өгөхийг шаардан туслахаас татгалзжээ. Мөн Тан улсын Шилла руу довтлохгүй байх анхааруулгыг эс тоов. Үүгээр шалтаглан Тангийн Тайзун, Когүрйө руу Ляо мөрнийг гатлан дайрав(Пожан вангийн 4-р, 645 он). Ляодун цайз болоод хэд хэдэн хэрмийг эзэлсэн ч, Аньши цайзын байлдаанд ялагдаж ухрахаас өөр замгүй болжээ. Аньши цайз нь уулын нэгэн жижиг хэрэм хэдий ч Тангийн цэргүүд бүх хүчээ дайчлан хоногт зургаа долоон удаа дайрч, жар гаруй хоног бүслэн хаагаад эс дийлжээ. Үүний дараа хэд хэдэн удаа довтолсон ч бүгд амжилтгүй болсон байна.

영고 Йонго (迎鼓, Yeonggo) Эртний Пүёогийн ургацын баярын шинжтэй тэнгэр тахих ёслол.

“Гурван улсын ойллого(三國志)”-ын “Вэй улсын бичиг”-ийн “Дорны бүдүүлгүүдийн шастир”-ын “Пүёогийн зүйл (魏書 東夷傳 夫餘條)”-д “Тэргүүн сард тэнгэрт тахил өргөж, улсын иргэд цуглан хэдэн өдрөөр ууж идэж, дуу дуулан бүжиг бүжих бөгөөд үүнийг йонго хэмээмүй. Энэ үед ял цаазыг шийтгэж, шоронгийн хоригдлыг сулламуй(以殷正月祭天 國中大會 連日飲食歌舞 名曰迎鼓 於是時 斷刑獄解囚徒)” гэжээ. Мөн “Хожуу Хань улсын бичиг”(後漢書)-т үүнтэй төстэй тэмдэглэл бий. “12-р сард тэнгэрт тахил өргөж, өргөнөөр цугламуй. Хэдэн өдрөөр ууж идэн дуу дуулж, бүжиг бүжих ба үүний йонго хэмээмүй”(以臘月祭天大會 連日飲食歌舞 名曰迎鼓)” гэжээ.

영업전 Йон об жонь (永業田, Yeongjeon) Корйөгийн үед феодалын эрх ашгийг хамгаалах хэд

хэдэн журам тогтоосны нэг нь тавдугаар зэргээс дээд зэргийн бичиг, цэргийн түшмэдийн нэг хүү нь эцгийн тушаалыг шууд өвлөх эрхтэй журам байв. Нийгмийн гарлаар ангилах ёсыг эдийн засгийн хувьд баталгаажуулахын тулд улсаас үр хүүхдэдээ шууд өвлүүлэхийг зөвшөөрдөг тариалангийн газрыг хэлнэ.

예맥 Еэмэг (歲貊, Yemaek) Эрт цагт Манжуурт нутаглан амьдарч байсан солонгос угсааны

аймаг. Еэ(歲) болон мэг(貊) гэж хувааж үзэх нь ч бий. Уг хоёр аймгийн харилцаа холбооны талаар судлаачид санал хуваагддаг. Зарим судлаач еэмэг гэж нэг том аймаг байсан гэж үздэг бол зарим нь тусдаа саланги хоёр аймаг гэж үздэг байна.

예부 Ёслолын яам (禮部, Yebu) Шиллагийн үеийн яам. Боловсрол, гадаад харилцаа болон ёслол

хүндэтгэлтэй холбоотой төрийн хэргийг эрхлэн хариуцдаг байжээ. 586 (жиньпийөн вангийн 8-р) онд байгуулагджээ.

오교 Таван ёс (五敎, Ogyosipjong) Тан улсад очиж суралцагсдын тоо олшрохын хэрээр Танд

гарсан бурхны шашны олон урсгал Шиллад ч мөн нэвтэрчээ. Бүддийн шашны кё урсгалын нирваан, винай, будда-байгалийн, аватамсака, дармалакшын таван ёс энэ үед төлөвшин тогтжээ.

옥저 *Огжө* (沃沮, Okjeo, НТӨ 3~285 он) Одоогийн өвөр Хамгийн мужийн хойт хэсэг болон

Түмэн голын сав газраар нутаглаж байсан эртний аймаг. Далайн эргийн дагуух тал нутагт газар тариалан болон далайн загас ан агнуур эрхлэж байжээ. Когүрийөд давс, загас зэргээр алба барьж, дам захирагддаг байжээ. Бэр болохоор сонгосон охиныг бага насанд нь хадмын гэрт оруулан өсгөж байгаад насанд хүрсэн хойно нь сүй бэлэг өгч, ёслон гэрлүүлдэг заншилтай байв. Хүн үхвэл цогцсыг нь өвс юм уу шороогоор хучин түр оршуулж, цогцос ялзран зөвхөн яс нь үлдсэн хойно цуглуулан оршуулдаг заншилтай байжээ.

온조왕 *Онъжо ван* (溫祚王, King Onjo) Пэгжэ улсыг үндэслэгч. НТӨ 18 оноос НТ 28 оныг хүртэл ван

сууринд суужээ. “Турван улсын түүхэн тэмдэглэл”-ийн Онъжогийн домгоос үзвэл, аав нь Когүрийө улсыг үндэслэгч Чүмон, ээж нь Чолбонь Пүйөгийн вангийн хоёрдугаар охин болно. Харин Пирюүгийн домгоос үзвэл, аав нь ар Пүйөгийн ван Хэ Бү рүгийн татвар эмийн хүү болох Үтэ бөгөөд ээж нь чолбонь хүн болох Йёнъта барийн охин Сө со но ажээ. Эндээс үзэхэд Онъжо ван нь Когүрийөгоос нүүдэллэн ирсэн Пүйө угсааныхны төлөөлөл болох нь тодорхой байна. “Турван улсын түүхэн тэмдэглэл”-ийн Онъжогийн домгоос үзэхэд Онъжо ван нь анх Вүирэ цайзад төвлөн суугаад арван түшмэлийн тусламжтайгаар улсаа байгуулсан тул улсынхаа нэрийг Шибжэ гэж нэрлэсэн байна. Энэ үед Мичүхорт нутаглаж байсан Пирюүгийн хүмүүс дагаж орохоор ирснээс хойш улсын нэрээ Пэгжэ гэж өөрчилжээ. Мөн Тонмийөн вангийн бунханг байгуулж, Награнтай харилцах болсон ба мохай нарын довтолгоог хэдэнтээ няцааж байв.

왕건 *Вангөнъ* (王建, Wang Jian 877-943 он) Сун-аг (松嶽) нутгийн феодал Ван Рюнь ба түүний

эхнэр Хань овогтын дундаас 877 онд төржээ. 896 онд Күн-еэ-д дагаж орон жанжин нь болсон бөгөөд Чхүнцөн мужийн нутгийг бүхэлд нь эзэлж, Тэбон-ы нөлөөний хүрээг бэхжүүлжээ. Хожуу Пэгжэтэй хийсэн байлдаанд удаа дараа ялалт байгуулан Чөлла болон Кйөнсан мужийн нутагт Кйөнхвөний цэргийг хэдэнтээ бут цохисон байна. 909 онд Нажүгийн ойр хавийн нутгийг эзлэжээ. 918 онд Күн-еэг зайлуулаад Корйө улсыг байгуулсан байна. Түүнээс хойш 936 оны 9-р сард ерөн мянган их цэргээр Хожуу Пэгжэг буулгаж авчээ. 926 оноос эхлэн Бохайн иргэдийг хүлээн авч,

умард зүгт хил хязгаараа тэлэх бодлого явуулжээ. Нутгийн том толгой феодалуудтай ураг барилдах замаар засаглалаа бэхжүүлэх бодлого явуулж байв.

왕안아골타 Ваньянь Агуда (完顏阿骨打, Wanyan Aguda 1068-1125) Зүрчид үндэстнийг нэгтгэн, Алтан улсыг байгуулсан Тайзу.

왕오천축국전 Энэтхэгийн таван хаант улсад аяласан тэмдэглэл (往五天竺國傳, Wangohcheonchukgukjeon) Ар өвөр улсын үеийн Нэгдсэн ШИллагийн хувраг Хэцо Энэтхэгийн таван хаант улсад аяласан тухайгаа бичсэн аяны тэмдэглэл. Францын хэл шинжээч, эрдэмтэн Пеллио олж, судлагааны эргэлтэд оруулсан байна. Энэтхэг болон Төв Азид оршиж байсан улс орнуудын тухай тэмдэглэл бөгөөд 8-р зууны үеийн аж амьдрал, ёс заншлын тухай бичсэн зохиол болохын хувьд сурвалжийн үнэ цэнэ өндөртэй зохиол юм. Гэхдээ сул тал гэвэл зарим агуулга нь хэт товч, улс орны нэр нь байхгүй, ямар хэлээр ярьдаг, ямар газар усанд амьдарч байсан талаар дурдсан зүйл хомс.

왕인 Ван инь (王仁, Wangin 4-р зууны сүүлийн хагасаас 5-р зууны эхний хагас) Пэгжэгийн соёл болоод эрдэм мэдлэгийг Японд түгээн дэлгэрүүлсэн эрдэмтэн. “Японы тэмдэглэл”, “Эртний хэргийн тэмдэглэл” зэргээс үзвэл Японд хэдийд очсон нь өөр өөр цаг хугацааг зааж байна. “Японы тэмдэглэл”-ээс үзэхэд Ашинь вангийн сүүлийн жилүүдэд Ажигги-гийн санал болгосноор Японд очоод Күнзийн суртлын ном судрыг зааж тайлбарласан гэдэг. Ван инь нь хожим Яматогийн засаг газарт бичиг тэмдэглэлийг хариуцсан *хумино обито* (書首) түшмэлийн албыг хашиж байжээ.

왜 Вэ (倭, Wa) Японыг дорд үзэж нэрлэсэн доромж нэр.

왜구 Вэгү (倭寇, Japanese dwarf pirates) 13-р зуунаас 16-р зууныг хүртэл Солонгосын хойгийн эрэг газар болон Хятадын тэнгисийн эрэг хавиар дээрэм тонуул хийж байсан Японы далайн дээрэмчид. Японы дотоодод цаг төрийн байдал самуурсны улмаас Японы өмнөд нутагт далайн дээрэмчид их болжээ. Энэ үед Зүүн Азийн улс төрийн байдал мөн таагүй байсны улмаас Японы далайн дээрэмчдийг дарахад улс орнууд онцгойлон анхаарал хандуулж чадаагүй бөгөөд ийм нөхцөлд далайн дээрэмчид

улам зохион байгуулалтад оржээ. Солонгосын хойгийн эрэг хавь төдийгүй эх газар руу гүнзгий нэвтэрч, ихээхэн хохирол учруулж байв. Корйөгийн сүүл үе, Чосөн-ий эхэн үед далайн дээрэмчдийн тонуул хамгийн ширүүн байжээ. Ялангуяа Корйөгийн сүүлийн 40 жилд тун ширүүсч, Корйөгийн ван улсыг мөхөн доройтох нэг шалтгаан болсон байна. Корйө болон Чосөн-ий засаг газраас удаа дараа Цushima аралд үүрлэсэн далайн дээрэмчдийг дарахаар цэрэг хөдөлгөж байсан ч дорвитой амжилт ололгүй хар луу жилийн дайн гардаг жил буюу 1592 оныг хүртэл дээрэмчдийн довтолгоон үргэлжилсээр байжээ.

외거노비 Гадуур боол (外居奴婢, Slave living alone) Харьяалагдах албан газар юм уу, эсвэл эзнээсээ тусдаа амьдарч, тариалангийн ажилд зүтгэдэг боолууд. Корйө-гийн үеийн боолчуудын нэлээд хувийг эзнийхээ газрыг боловсруулдаг хөдөөгийн “гадуур боол” эзэлж байсан ба албаны, хувийн ялгаагүй “гадуур боол”-ын амьдралын нөхцөл байдал хамжлагын тариачинаас онц ялгаагүй байлаа. Тэд хувийн өмчтэй, эзэндээ ургацын тодорхой хэсгээр алба барьдаг ба тэдний тоо өсөх хандлагатай байжээ. Корйө-гийн нийгэмд гарсан нэг өөрчлөлт бол “гадуур боолчуудын” нэг хэсэг нь өмч хөрөнгө хуримтлуулж, чөлөөт хүн болон нийгэмд эзлэх байр суурь нь нэг шат дээшилсэн явдал юм.

외사정 Вэсажон (外司正, Extramarital affairs) Шиллагийн үед түшмэдийг зүй бус үйлдэл гаргахаас сэргийлэхийн тулд орон нутагт суулгаад хянуулдаг байсан албан тушаал. 673 (Мүнъмү вангийн 13-р) онд бий болгосон албан тушаал бөгөөд муж болоод күнь-д тус бүр хоёр хүн, нийт 133 албан тушаалтанг суулгажээ.

요 Хидан улс, Кидан улс, Ляо улс (遼, Yo 916-1125) X-XII зууны үеийн Зүүн хойд Азид оршин тогтнож байжээ. Кидан үндэстэн нь анх Лууха голын баруун талаар, Шар мөрний умард саваар (Ордосын Шар мөрөн биш) нутаглаж байсан бололтой бөгөөд яваандаа Шар тэнгисийн эрэг хүртэлх нутагт тархан суужээ. Тэд Сяньби нарын адил дорнод ху нарын удам байсан ба тэдний ихэнх нь өнөөгийн Монгол нутагт төвлөн сууж байгаагүй ч 923 оноос Алтайгаас зүүн тийш Хэрлэн голын хойт бие хүртэл нутгаа тэлж соёл, түүхийн олон зүйл дурсгал Монгол нутагт үлдээжээ.

요동 Ляодун (遼東, Yodon) Ханзны утгаараа Ляо мөрний дорно этгээдийн нутгийг хэлнэ. Ляодуны хүрээ хязгаар нь нэлээд хийсвэр ойлголтод тулгуурлана. Явцуу утгаар Ляодуны хойг хавийг хэлэх бол өргөн утгаараа Манжуурыг, бүр Солонгосын хойгийн умард хэсгийг багтаасан ойлголт болно.

요동반도 Ляодуны хойг (遼東半島, Liaodong Peninsula) Ляодуны хойг нь Шаньдуны хойгийн хамтаар Бохайн буланг хүрээлэн оршдог. Хятадын Ляонин мужид харьяалагдна. Ханзны утгаараа Ляо мөрний зүүн этгээдэд орших хойг гэсэн утгатай.

요역 Биеэр гүйцэтгэх алба (徭役) Жилд нэг удаа тодорхой хугацаанд биеийн хүчний ажилд дайчлах алба. Бурхан тахих тахилын зардлыг нөхөх тариалангийн газар(*чөгжсөнъ*, 積田; 籍田) дээр ажиллах, орд харш, байшин сав босгох, ууланд булш бунхан барих, хэрэм цайз барих болон уул уурхайд ажиллах хөдөлмөр орно.

요하 Ляо мөрөн (遼河, Liao River, Liaohe River) БНХАУ-ын зүүн хойт нутагт орших хамгийн том мөрөн. Хятадын 7 том мөрний нэг юм. Урагшаа Бохайн булан болон Шар тэнгистэй залгах бөгөөд баруун урд талаараа Өвөр Монголын өөртөө засах орны Нэирухө мөрөн болон Хэбэй мужийн Хайрөнхө мөрөнтэй залгана. Хойт өргөргийн 40°30' ~ 45°10' хэмд оршино.

운제 Дайран орох шат, Үүлэн шат (雲梯, Scaling ladder) Хэрмийг эзлэхийн тулд хэрэм давуулан өлгөх боломжтой хийсэн эвдэг шат. Уг шатаар цэргүүдийг хэрэм давуулдаг байжээ.

울주 대곡리 반구대 암각화 Үлжү-гийн Тэгог ри дэх Паньгүдэ хадны зураг (蔚州大谷里盤龜臺巖刻畫, Bangudae Rock Art) Үлсань өргөтгөсөн хотоос холгүй орших Паньгүдэ хадны зураг нь шинэ чулуун зэвсгийн үеийн халим агнууртай холбоотой зураг юм. 1971 онд олж илрүүлсэн бөгөөд 1995 онд Үндэсний соёлын өвийн үнэт зүйлээр бүртгэжээ. Халим болон загас ан агнууртай холбоотой 300 гаруй зураг буй. Тэдгээрийн дундаас халим агнууртай холбоотой зургийг 7000 жилийн өмнөх буюу шинэ чулуун зэвсгийн үед үйлдсэн хэмээн тогтоожээ. Энэ нь дэлхийн

хамгийн эртний, халим агнууртай холбоотой сүг зураг гэсэн үг юм. Өмнөд Солонгосын хувьд балар эртний хадны сүг зургууд дундаас хамгийн эртнийх нь бөгөөд барагцаалбал 7000-3500 жилийн өмнө үйлдсэн хэмээн таамаглаж байна.

움집 Нүхэн сууц (Pit House) Шинэ чулуун зэвсгийн үеийн хүний сууц. Хонхойлж ухсан буйран дээр шууд өвсөн дээвэр тавьж зассан оромж.

원 Юань (元, Yuan) 1271 оноос 1968 оныг хүртэл 97 жилийн турш Хятадын эх газар төдийгүй дэлхийд хамгийн өргөн уудам нутгийг эзлэн оршсон Монголын эзэнт гүрэн. Нийслэл нь Ханбалиг. Оршин тогтносон хугацаа нь маш богино бөгөөд шалтгаан нь зөвхөн цэрэг зэвсгийг хүчээр байгуулсан улс бөгөөд зөөлөн бодлогын хүч дутагдсан гэж үздэг. Ялангуяа ноёлогч ангийн дийлэнхи нь боловсрол тааруу байсантай холбоотой ажээ. Дээр нь дэлхий даяар тарсан тахал өвчин нэрмэжээ.

원호 Вөнхё (元曉, Wonhyo 617-686 он) Шиллагийн үеийн бүддийн шашны хувраг. Нийгмийн гарал нь *югтүнүм* бөгөөд Абрян (Одоогийн Ар Кйёнсан мужийн Кйёнсанъ хотын Абрян мйёнъ) нутгийн хүн. Бага залуудаа сахил хүртэн хувраг болсон бөгөөд өөрийн гэрийг зарж, Цогэ (初開寺) хийдийг барихад хандивлажээ. 650 (Чиньдөг вангийн 4-р) онд Ыисан-ы хамтаар Тан улс руу бүддийн шашинд суралцахаар явсан боловч зорьсон газраа хүрч чадалгүй буцсан байна. Ингээд нутагтаа арав гаруй жилийн турш буддийн шашин номд боловсрон бясалгал хийжээ. 661 (Мүнъмү вангийн 1-р) онд Хятад руу суралцахаар Ыисаны хамтаар дахин замд гарчээ. Гэвч харанхуй шөнөөр нэгэн булшны захад хоноглож, гавлын ясанд тунасан усыг уусныхаа дараа “Бүх зүйл сэтгэлээс шалтгаална” гэдэг үнэнийг ухааран гэгээрэлд хүрчээ. Ингээд Ыисан-аас салж нутаг буцаад үлдсэн амьдралаа олон түмнийг гэгээрүүлэхэд зориулжээ. 654-661 онд Тайзун Мүйөл вангийн хоёрдугаар охин Ёсөг гүнжтэй гэрлэж, Сөлцон-ыг төрүүлсэн бөгөөд энэ хэргийн улмаас шар шувталжээ. 662 онд Ким Юү шинь-ий удирдсан Когүрийөг дайлах цэргийг дагалдан явж, Тан улсын Су Дин фан (蘇定方) жанжины илгээсэн нууцлалтай бичгийг тайлан уншиж, гавьяа байгуулж байжээ. Нас хэвийсэн хойноо Понхван хийдэд шашин номын ажилд зүтгэж байгаад 70 насандаа таалал төгсчээ. Вөнхё лам шашны олон урсгал өөр хоорондоо эвдрэн тэмцэх бус эвлэж зохицох хэрэгтэй гэж үзэж байв. Тэр

үеийн эрдэмт их лам нараас Вөнхё лам л ганцаар Тан улсад очиж, шашны номонд суралцаагүй авч сургаал номлол нь Тан улсад хүртэл хүндэтгэл бишрэлийг хүлээж байжээ. Будда-байгалийн ёсыг голцуу дагадаг байсан гэх боловч, буддын шашны номонд нэвтэрхий тэрбээр “Аватамсака судар”-ыг ч сайн мэддэг байсан тул Аватамсака ёсыг дагадаг гэж үзэх нь ч байжээ. Шашны ганцхан ёсыг туйлшран дагалгүй, олон урсгалуудыг найралдуулан зохицуулж нэгтгэх ёстой гэсэн өвөрмөц үзэл бодолтой түүнийг хожим “Тэмцлийг дарагч улсын багш” хэмээн өргөмжилсөн гэдэг. Вөнхё ламын үзэл бодол нь хэмжээгүй эрхт вангийн засаглал дорхи нийгмийн зөрчлийг үзэл суртлын аргаар шийдвэрлэх гэсэн оролдлогын нэгэн талыг харуулна.

위 Вэй (魏, State of Wei НТӨ 403 ~ НТӨ 225) Хятадын Хавар намрын улсын эхэн үед 140

гаруй жижиг улс байснаа цагийн уртад өөр хоорондоо дайтаж, нэгдэж бутарч явсаар Байлдаант улсын үе ирэхэд арван хэдэн улс үлдэсний нэг нь юм.

Байлдаант улсын долоон баатар гэж нэрлэдэг ханлиг улсын нэг нь болно. Хавар, намрын улсын үеийн Жинь улс гурав хуваагдан задарч, Гурван Жинь буюу Хань, Жао, Вэй улс үүсчээ. Хүн амын тоогоор хамгийн их улс байжээ.

위 Вэй (衛, Wei НТӨ 113уун? ~ НТӨ 209 он) Хятадын Хавар намрын улс, Байлдаант улсын үеийн нэгэн томоохон улс.

위 Вэй (魏, Wei 220 ~ 265) Хожуу Хань улсыг мөхсний дараа үүссэн Хожуу Гурван улсын

дундаас хамгийн хүчирхэг том улс юм. Чао овогтын Вэй улс(曹魏) гэж нэрлэх нь бий.

위만 Вэймань (衛滿, Wiman) ХТӨ IV зууны эцсээр Ко Чосонь нь, Янь улсын довтолгооны үеэр

доройтон суларчээ. Янь, Инь(진; 秦) улстай хүч хавсран, Ляодун-ы хойгийг булаан эзлээд Ляодун муж гэж нэрлэжээ. Ляодун муж, Янь-ийг мөхсөний дараа Инь улсын мэдэлд орж, хятад түшмэд, цэрэг, худалдаачин наймаачид зэрэг холхин явагчид их байв. Инь улс арван жил ч бололгүй мөхөж, түүнийг залган Хань(한; 漢) улс гарч ирэв. Хань улс, мөхсөн Янь улсын нутагт Лү вань(노관; 盧綰)-ыг ван өргөмжлөн илгээсэн боловч Лү вань Хүннүгийн нутаг руу зугатан оджээ. Ийм үймээнт үед

Хятадын нутгаас дүрвэн нүүж ирэгсэд олширчээ. Тэдний нэг Вэй мань гэгч өөрийн мянга гаруй албатыг дагуулан нүүж ирсэнд, Жүнь ван(준왕; 準王) түүнийг хойд хязгаар нутгийг хамгаалах албанд тохоосон байна. Тэнд Вэй мань хэсэг хугацаанд хүчээ бэхжүүлж аваад, Жүнь ванг хөөн зайлуулж өөрөө сууринд нь суужээ. Вэй мань Чосөн нь бусад аймгуудаас цэрэг, эдийн засгийн давуу хүчтэй байсан тул ойр хавийн Жиньбөн, Имдүн зэрэг хэд хэдэн аймгийг байлдан дагуулж дөрвөн зүг хүрээгээ тэлжээ. Ийнхүү газар нутгаа томсгож, хүчирхэгжээд Хань мөрнөөс урагш орших Жинь улсыг Хань улстай шууд харилцахыг хориглож, дундаас нь худалдааны ашиг олохыг зорьсон байна. Хань улсын хувьд энэ нь таатай хэрэг биш байлаа. Тэгээд ч Манжуур хүртэл хүрээгээ тэлсэн Хүннүтэй Вэй мань Чосөн холбоо тогтоовол ямар аюултай болох нь тодорхой байв. Тэгээд Йэ(예; 濊)-гийн газар нутагт Цанхай муж(창해군; 滄海郡)-ийг байгуулж(ХТӨ 128 он), Вэй мань Чосөн-д шахалт үзүүлэх болов. Гэвч энэ төлөвлөгөө нь нутгийхны эсэргүүцлийн улмаас амжилт олоогүй байна. Чосөн-ий жанжинг хорлон алаад зугатсан Сөбха(섭하; 涉何)-г чосөнчүүд өс авч мөн хорлож хөнөөсөн явдал нь Вэй мань Чосөн, Хань улсын зөрчлийг туйлд нь хүргэж, Ү хуанди(무제; 武帝) довтлов(ХТӨ 109 он). Чосөнчүүд жил гаруй эсэргүүцэн байлдсан ч дотоодын хагарлын улмаас Үгө ван(우거왕; 右渠王) хорлогдож үхэв. Их түшмэл Сөнги(성기; 成己) эцсээ хүртэл тэмцээд амжилт ололгүй, улмаар нийслэл Вангөм хот(왕검성; 王儉城) эзлэгдэж, Вэй мань Чосөн мөхжээ(ХТӨ 108 он).

위만 조선 *Вэймань Чосөн* (衛滿朝鮮: Wiman Joseon, НТӨ. 194 он ~ НТӨ. 108 он) ХТӨ IV зууны эцсээр Ко Чосөн нь, Янь улсын довтолгооны үеэр доройтон суларчээ. Янь, Инь(진; 秦) улстай хүч хавсран, Ляодун-ы хойгийг булаан эзлээд Ляодун муж гэж нэрлэжээ. Ляодун муж, Янь-ийг мөхсөний дараа Инь улсын мэдэлд орж, хятад түшмэд, цэрэг, худалдаачин наймаачид зэрэг холхин явагчид их байв. Инь улс арван жил ч бололгүй мөхөж, түүнийг залган Хань(한; 漢) улс гарч ирэв. Хань улс, мөхсөн Янь улсын нутагт Лү вань(노관; 盧綰)-ыг ван өргөмжлөн илгээсэн боловч Лү вань Хүннүгийн нутаг руу зугатан оджээ. Ийм үймээнт үед Хятадын нутгаас дүрвэн нүүж ирэгсэд олширчээ. Тэдний нэг Вэй мань гэгч өөрийн мянга гаруй албатыг дагуулан нүүж ирсэнд, Жүнь ван(준왕; 準王) түүнийг хойд хязгаар нутгийг

хамгаалах албанд тохоосон байна. Тэнд Вэй мань хэсэг хугацаанд хүчээ бэхжүүлж аваад, Жүнъ ванг хөөн зайлуулж өөрөө сууринд нь суужээ. (ХТӨ 194-180). Чосөнъ-ий жанжинг хорлон алаад зугатсан Сөбха(섭하; 涉何)-г чосөнъчүүд өс авч мөн хорлож хөнөөсөн явдал нь Вэй мань Чосөнъ, Хань улсын зөрчлийг туйлд нь хүргэж, Ү хуанди(무제; 武帝) довтлов(ХТӨ 109 он). Чосөнъчүүд жил гаруй эсэргүүцэн байлдсан ч дотоодын хагарлын улмаас Үгө ван(우거왕; 右渠王) хорлогдож үхэв. Их түшмэл Сөнги(성기; 成己) эцсээ хүртэл тэмцээд амжилт ололгүй, улмаар нийслэл Вангөм хот(왕검성; 王儉城) эзлэгдэж, Вэй мань Чосөнъ мөхжээ(ХТӨ 108 он).

위화도회군 Вүихва арлаас цэргээ буцаасан нь (威化島回軍, Wihwado Retreat) Юань улс мөхөж,

Хятадын эх газрыг эзлэсэн Мин улс нь Юаний захиргаанд орсон Цөллйөн даваанаас хойшхи нутгийг эзэмших эрхтэй гэдгээ Корйөд мэдэгдэж, уг нутагт Цөллйөн вүи нэртэй цэргийн анги суулгажээ. Корйөгийн зүгээс үүнийг газар нутагт нь халдсан явдал гэж үзээд Ү ван, Цой йөн нар тэргүүлэн Цөллйёныг байлдан дагуулахаар зорьж цэрэг хөдөлгөжээ. Гэвч цэргийн жанжин И Сөнгэ нь вангийн зарлигийг зөрчиж, Ялу мөрний Вүихва арлаас цэргээ буцаагаад улмаар нийслэл Кэгийёныг эзлэж, Ү ванг сууринаас огцуулаад Цой йёныг цаазлажээ. Энэ хэрэг явдлыг Солонгосын түүхэнд Вүихва арлаас цэргээ буцаасан явдал хэмээн нэрийддэг. Уг хэрэг явдал нь Корйө улс мөхөж, Чосөнъ улс бий болох үндсийг тавьсан байна.

육두품 Юүгтүпүм (六頭品, Yugdupum) Шиллагийн колхүм тогтолцоог (骨品制度) бүрдүүлэх нийгмийн нэгэн анги давхарга. Юүгтүпүм нь ариун ястан(聖骨) болон жинхэнэ ястан(眞骨)-ы удаад орох өндөр зэрэг дэв юм. Уг зэргийг эзлэхэд хэцүү гэдэг утгаар *тыгнань* ‘득난(得難) гэж бас нэрлэдэг байжээ.

육조 Зургаан яам (六曹, Six Ministries of Joseon) Корйө болон Чосөнъ-ий үеийн зургаан яам.

Цэргийн, сангийн, ёслолын, татварын, түшмэлийн, хуулийн яамыг хэлнэ.

융천 Юнцөнъ (融天, Yongcheon) Гай гамшигийн ёр сүүлт одыг, мөн Японы түрэмгий

цэргийг ганц дууны хүчээр хөөн зайлуулсан гэх “Сүүлт одны дуу”-г зохиосон хувраг. Уг дуу нь бидний үед уламжлан ирсэн Гурван улсын үеийн дуу юм.

음서 Ымсө (蔭紱, Eumseo) Корйө-гийн сурвалжит гэр бүлүүд өөрсдийн онцгой эрх ашгийг

тусгайлан хамгаалах зорилгоор хэрэгжүүлсэн журам. Тавдугаар зэргээс дээд зэргийн түшмэдийн болон улс төрд онцгой гавьяа байгуулсан түшмэдийн үр хүүхэд нь төрийн алба тушаалыг шууд эзлэх эрхтэй байв. Уг журам нь Корйө-гийн нийгэм язгуур сурвалжийг эрхэмлэсэн феодалын нийгэм болохыг тодорхой харуулдаг. Зарим үед төрийн эрхийг атгасан сурвалжит гэр бүлийн эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах, өөрсдийн хүч нөлөөг өсгөх зэвсэг болох үе ч байжээ.

응방 Ынбан (鷹坊, Eungbang) Корйө болон Чосөн-ий үеийн шонхор шувуу үржүүлэх албан

газар. Шонхор шувуу үржүүлэх албыг Корйөд 1275(Чхүннйөл вангийн тэргүүн) онд байгуулжээ. 1281 онд *ынбан догам* нэртэйгээр улам өргөжүүлсэн байна. Морьтон үндэстэн монголчуудын хувьд ан ав хийдэг шонхор шувуу нэгэн төрлийн эд хөрөнгө болдог байжээ. Монголчууд Корйөгоос шонхор шувуугаар алба өргөхийг шаардсан тул уг албан газрыг байгуулсан байна. Мөн монгол язгууртнуудын тансаг амьдралыг шохоорхсон Чхүннйөл вангийн хувийн хүсэл зориг бас нөлөөлсөн гэж үздэг. Шонхор шувуу өсгөх газрын корйө түшмэдүүд Юан улсын зарлигаар далайлган, энгийн олныг хэлмэгдүүлж зовоох явдал гарч байжээ.

의창 Ыйцан (義倉, Uichang) Энгийн цагт тариа будаа нөөцлөн хадгалж байгаад өлсгөлөн

болсон үед хувааж өгч тусладаг сан. Корйөгийн үед буюу 986(Сөнжон-ы 5-р) онд байгуулагджээ. Хоол хүнсээр үнэгүй хангах сан, намар нь буцааж авахаар үр тариа зээлүүлэх сан гэж хоёр сан байжээ. Чосөн-ий үе уг журмыг тэр чигээр нь үргэлжлүүлж, Сэжуны үед ихэд өргөтгөсөн байна. Жүнжон-ы үеэс үндсэндээ татан буугджээ.

이부 Түшмэлийн явдлын яам (吏部, Ministry of Personnel) Корйөгийн зургаан яамны нэг.

Бичгийн түшмэдтэй холбоотой хэрэг явдлыг захиран шийтгэх яам.

이사금 Исагым (泥師今, Isageum) Шиллагийн эхэн үеийн вангийн цол. Гуравдугаар ван буюу

Юүри вангийн үеэс арван зургадугаар ван буюу Хырхэ вангийн үеийг хүртэл хэрэглэжээ. Бөө, тахилч, залгамжлагч гэсэн утгатай хэмээн таамагладаг. Цолны

өөрчлөлт хувьсалт нь аймгийн холбооны хөгжлийн шатнаас анхны вант улс болох хөгжих явцыг харуулна.

이자겸 И Жа гйөм (李資謙, Yi Ja-gyeom) Корйөгийн эхэн үеийн сайд, бичгийн түшмэл. Хэзээ төрсөн нь тодорхойгүй. 1126(Ынъжоны 4-р) онд нас баржээ. Вангийн хадам талын гэр бүлийн хүн бөгөөд ымсө журмаар алба тушаал дэвшжээ. Еэжон, Инъжон вангуудад охидоо хатан болгон өгснөөс хойш, ялангуяа Инъжон-ыг ван сууринд суухад тусласнаасаа хойш ордонд их эрх мэдэлтэй болсон байна. И Жа гйөм болон Цөг Цүнъ гйөн нарыг зайлуулах оролдлого гарсан боловч эсрэгээр И Жа гйөм тэргүүтнүүд ордонд гал тавьж, олон хүнийг хороожээ. Дараа нь өөрийгөө ван өргөмжилж, Инъжү-гийн И овогтын шинэ төр улс байгуулахыг мөрөөдөж байснаас үзэхэд хэр хүчирхэг байсныг мэдэж болно. Хожим Цөг Цүнъ гйөний явууллагаар цөлөгдөж, цөллөгт нас баржээ.

이제현 И Жэ хйөнъ (李齊賢, Yi Je-hyeon 1287-1367 он) Корйөгийн сүүл үеийн эрдэмтэн, сайд. Кйөнжү нутгаас гаралтай. 1302 онд орогсдын шалгалтанд тэнцсэнээр алба тушаал ахих зам нь нээгджээ. 1314 онд Юаньд очиж, эртний ном судар судлаж байжээ. 1320 онд Цүнсөнъ ван хилсээр цөлөгдөхөд Юаньд очиж, Цүнсөнъ вангийн буруугүй болохыг ятган сэнхрүүлсний учир 1323 онд ван цөллөгөөс суллагдаж байжээ. 1339 онд Шим ян ван Ко, Цүнсүг ванг гүтгэн мэдүүлсэн хэрэг гарах үед мөн Юаньд очиж тайлбарлаж байв. 1343 онд Юаний элч Цүнхэ ванг барьж аваад явахад Юаньд очиж ванг суллуулах хүсэлт тавьж байжээ. Цүнсөн ван(1308-1313) угсаа залгамжлах ванхүү байхдаа Пайг И жөн(백이정; 白頤正) нарын хамт Юаны нийслэлд очиж, хүнзийн сурталт эрдэмтэдтэй нөхөрлөж байжээ. Хожим ван сууринаас огцорсон хойноо Юаны нийслэлд “Түмэн судрын танхим”(만권당; 萬卷堂) байгуулж, И Жэ хйөнъ(이제현; 李齊賢) нарын хамт хүнзийн сурталтнуудтай ойр дотно холбоотой байсан зэрэг нь Корйө-гийн хүнзийн суртлын хөгжилд их нөлөөлсөн байна.

이차돈 И Ца донъ (異次頓, Ichadon 506-527 он) Шиллад бүддийн шашныг нийтийн шашин

болгоход амь биеэ зориулсан хүн. Түүний тухай “Гурван улсын түүхэн тэмдэглэл”, “Гурван улсын нөхсөн судар” зэрэг сурвалж, “И Ца донь-ы гэрэлт хөшөө” -ний бичиг зэрэгт дурдсан байдаг бөгөөд Йөмцог, Кө Ца донь, Цө до зэрэг нэрээр гардаг. Пөбхын ван бээр ван сууринд сууснаасаа хойш бүддийн шашныг дэмжиж, сүм хийд барин хурал ном хуруулахыг хүссэн боловч албат түшмэд нар нь ихэд эсэргүүцжээ. Энэ үед вангийн хүсэл зоригийг таньж мэдсэн И Ца донь ванд ингэж айлтгажээ. “Цөнгёнрим гэдэг газарт сүм барьж байна гэдэг цуурхал тараавал албат түшмэд нар ихээр бухимдан дургүйцэж вантанд эсэргүүцэл илэрхийлнэ. Тэр үед миний толгойг авах аваас зайлшгүй жирийн бус зүйл болж, олноор дагаж орох болно” гэжээ. Вантай ийнхүү нууцаар тохиролцсоны дагуу И Ца донь сүм барьж эхлэхэд албат түшмэдүүд эсэргүүцэн И Ца донь-ыг цаазлахаар болов. И Ца донь “Намайг цаазлах үед жир бус хэрэг болно” гэж хэлэх бөгөөд үнэхээр ч толгойг нь автал цагаан өнгөтэй цус олгойдож, хав харанхуй болоод тэнгэрээс цэцгэн бороо орж, газар ихээр чичрэн хөдлөжээ. Үүнийг харсан албат түшмэдүүд өөрсдийн харанхуй мунхаг болохыг ухаарч бүгдээр бүддийн шашинд дагаж орсон байна. 817 онд Хэрюүн нар толгойлон И Ца донь-ы бунханг ихээр барьж, том гэрэлт хөшөө босгосон бөгөөд уг хөшөө нь БНСУ-ын Кйөнжүгийн Үндэсний Музэйд хадгалагдаж буй хөшөө гэж үздэг.

일연 Ирийонь (一然, Il-yeon) Корйөгийн сүүл үед амьдарч байсан хувраг. “Хварог”, “Кэсон Жабжө”, “Гурван улсын нөхсөн судар” зэргийг бичжээ. 1206 онд төрөөд 1289 онд нас баржээ. 1219 онд Сөраг уулын Жиньжөнх хийдэд шавилан суусан байна. Монголын довтолгооны дараа Мүжү сүмд байхдаа гэгээрсэн гэх бөгөөд Өмнөд Тэнгисийн Чөнрим хийдэд Их хөлгөн судар бүтээхэд гар бие оролцжээ. Вөнъжон-ы зарлигаар Канхва арлын Сөнъвөл хийдэд сууж, шашны ном номлох болсон ба их багш инүлийн урсгалыг залгамжилжээ. 1277 оноос Цөндө арлын Үньмүнх хийдэд суухдаа “Гурван улсын нөхсөн судар”-аа бичиж эхэлсэн байна. 1283 онд “Улсын багш” цолоор өргөмжлөгджээ.

임진왜란 Хар луу жилийн Японы халдлага (壬辰倭亂, Japanese invasions of Korea) 1590 онд Чосөн-өөс Япон руу Хван Юн гил, Им Сөн ил нарыг элчээр илгээхэд Тоётоми бичгээр “Мин улсыг дайлах гэж буй тул замчил” гэж шаарджээ. Түүний дараа жил

Ханьсөн-д Японы элч ирж, “Минг дайлах тул зам тавь” гэж шууд шаардсан байна. Чосөн-ий засгийн газар Мин улсад яаралтай элч илгээн мэдэгдэж, өмнөд хил хязгаарыг чангатган бэхлэхийг оролджээ. Гэвч бараг хоёр зуун жилийн турш хилийн хамгаалалтыг хайхрахгүй орхиж ирсэн тул энэ нь тийм амар хэрэг биш байв. Эрх баригчид гадны түрэмгий санаархал нэгэнт ил болчихоод байхад ч итгэж ядсан мэт олигтой арга хэмжээ авахгүй байв. Энэ хооронд Японоос заншлаач тандуулч нарыг илгээн Чосөн-ий дотоод байдлын талаар нарийн чухал мэдээг цуглуулж, өрнөдийн боловсронгуй зэвсгээр цэргээ зэвсэглэж эхлэжээ. 1592 (Сөнжо вангийн 25-р) онд Японы цэргүүд Пүсань(부산; 釜山)-д буув. Пүсань-ы цэргийн хуаран, Тонрай хэрмийг эзлээд, бараг эсэргүүцэл үзэлгүй Ханьсөн рүү дөхөж ирэхэд засгийн газар, Шинь риб(신립; 申稜)-ээр удирдуулсан цэрэг илгээсэн ч ялах найдлага байсангүй. Ван болоод их түшмэдүүд яах учраа олохгүй байсаар сүүлдээ Ханьсөн-г орхиж умар зүг зугатан дайжив. Үүнд хилэгнэсэн ардууд боолын данс хараа хадгалдаг Чан-е вөнх хийд ба вангийн ордонг галдан шатаажээ. Япончууд эх газарт хөл тавиад хорьхон хоногийн дараа нийслэлийг эзлэхэд ван болоод сайд түшмэдүүд дахин Кайсөн-өөс Ыижү(의주; 義州) рүү зугатан очоод Мин улсаас тусламж гуйж, цэрэг илгээхийг хүсэв. Засгийн газрын цэрэг ялагдаж, эмх замбараагаа алдав. Эх газарт ийм байхад, тэнгисийн байлдаанд харин байдал өөр байв. Ялангуяа Чөлла зүүн тэнгисийн захирагч(전라좌수사; 全羅左水使)-ийн И Сүнъ шинь(이순신; 李舜臣) жанжин Японы довтолгоог урьдчилан таамаглаж, “*Көбүгсөн*” хэмээх байлдааны хуягт усан онгоц хийх зэргээр байлдах бэлтгэлтэй байсан тул Огпхо(옥포; 玉浦), Танпхо(당포; 唐浦) боомтууд, Ханьсаньдо(한산도; 閑山島) зэрэг газар ээлж дараалан ялалт байгуулжээ. Үүний дараа Чосөн-ий усан цэрэг тэнгисийн тулаанд бүрэн ноёлох болж, дайсны усан ба хуурай замаар хоёр талаас эзлэх төлөвлөгөөг нурааж чадсан байна. Нөгөө талаар япончууд Хятад руу довтлох нь илт байсан тул Мин улс энэ дайнд оролцохгүй байж чадахгүй байв. Тун удалгүй Мин улс цэрэг илгээж хоёр улсын цэрэг хамтран байлдаж эхэлсэн нь Чосөн улсад тус болсон нь маргаангүй. Байдал ашиггүй болж ирэхэд Япончууд эвийн хэлэлцээр байгуулахыг санал болгов. Чосөн-ий засгийн хэрэгсээгүй боловч Мин улс дайныг сунжруулахгүйн тулд дангаар хэлэлцээр хийхээр болсон байна. Япончууд хэлэлцээрийг бараг гурван жил сунжруулан, тэр хооронд дахин

довтлохоор бэлтгэлээ базаажээ. Улаагчин тахиа жил(정유; 丁酉; 1597) дахин довтлосон ч Чосөнъ үүнд бэлтгэлтэй байсан тул шийдвэртэй няцаан тулалджээ. 1598 оны 8-р сард Тоётоми үхсэн тул Япон цэргээ буцаан татаж, долоон жил үргэлжилсэн дайн дажин дуусав. Энэ дайны хор гамшиг асар их байв. Тариалангийн газар үгүйрэн хоосорч хүн амын тоо цөөрөв. Олон тооны урчууд, шаазанчид Японд олзлогдон хүргэгдэж, өрнөдийн боолын наймаачдад худалдагдах явдал ч байжээ. Гэвч ард түмэн эх орноо хамгаалахын төлөө сайн дураар босч тэмцэн, японы түрэмгийлэгчдийг хөөн зайлуулсан юм.

장군총 Жангүнъ (Жанжин) булш (將軍塚, Janggunchong) Когүрйөд анхандаа булшийг пирамид хэлбэрээр чулуу өрж хийдэг байжээ. Хятадын Жилинь мужийн Чи ань хотын ойролцоо ийм хэлбэртэй хэдэн мянган булш байдаг ба хамгийн том нь өргөнөөрөө 31.5 метр, өндөр нь 12.4 метр хүрэх Жангүнъ(Жанжин) булш болно. Эхэн үеийн чулуун булшинд аажмаар Хятадын соёлын нөлөө тусч, чулуун ханат булш болон өөрчлөгджээ. Энэ нь газарт тоосго мэт зассан чулуугаар ханыг нь доторлосон тасалгааг шороогоор булж, дээр нь шороо бөмбийлгөж зассан булш юм.

장보고 Чан Бого (張保皋, Jangbogo ? ~ 841) Шиллагийн цэргийн жанжин. Хындөг ван(흥덕왕; 興德王)-гийн 3-р(828) онд Цөнхайжинъ хуаранг бариулжээ. Чан Бого Тан улсад очиж цэргийн эрдэмд боловсорч байхдаа далайн дээрэмчид энгийн ард, тариачдыг хулгайлж, гадаад улсад боол болгон худалдаж буйг мэдээд нутагтаа харьж Хынъдөг ванд айлтган, өмнөд тэнгисийн гол цэг Вандо аралд Цөнхай жинъ хуаранг байгуулж, захирагч нь болжээ. Тэр түмэн цэрэг захирч, Тангийн далайн дээрэмчдээс тэнгисийн эрэг хавийн нутгийг хамгаалахын зэрэгцээ Тан, Японтой тэнгис гатлан худалдаа хийж байв. Чан Бого төрийн хэрэгт ч оролцож, үүрэг гүйцэтгэж байсан. Үжинг(Шинъмү ван) том феодалуудын өөр хоорондын тэмцэлд ялагдаад тусламж гуйж ирэхэд нь цэргээ илгээж, Минъ-э(민애왕; 閔哀王) ванг хөөн зайлуулж ван сууринд нь суулгаж байв. Мүнъсөн вангийн үед Чан Бого охиноо вангийн хатан болгохыг оролдоход хэдэн том язгууртан түүнийг хорлож

алсан(Мүнхсөн ван 8-р, 846он) ба Цөнхайжинь хуаран ч татан буугджээ(Мүнхсөн ван 13-р851он).

장수왕 Чансү ван (長壽王; Jangsu 413-491) Далан есөн жил ван сууринд сууж, Квангайто их ван эцгийнхээ үйл хэргийг үргэлжлүүлжээ. Энэ үе бол Когүрийөгийн цэцэглэн мандалтын үе байв. Чансү ван, Хятадын Өмнөд, Умард ханлиг улсууд(양조; 兩朝)-тай тэгш харилцаж, энэ хоёрын нэгдлийг саатуулах бодлого барьжээ. 427 онд, нийслэлийг Пхйөнянд шилжүүлж, шинэ хот байгуулсан ба уулын хөндийгөөс гарч, өргөн уудам талд улс төр, эдийн засаг, соёл бүхий л талаар хөгжиж чадахуйц нийслэл барьж, шинэчлэлт хийхийг зорьж байв.

전시과 Жөнъ ши гва (田柴科, Chonsikwa) Корйө-гийн эдийн засгийн тогтолцоонд *Жөнъ ши гва* буюу Цалин пүнлүүний газар гэж нэрлэж болох газар өмч-лөх журам томхон байр эзэлнэ. Уг журам нь Тайзу-гийн 23-р(940) оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн “*йөг бүнъ жөнъ*”(역분전; 役分田) журмаас үүсэлтэй. Эзэн вандаа хэр үнэнч болох, улс гэрийг байгуулахад ямар гавьяа байгуулсныг шүүн тогтоож, түүнд нь тааруулан тодорхой хэмжээний газар хуваарилж олгодог журмыг “*йөг бүнъ жөнъ*” гэж нэрлэж байжээ. Кйөнжон-ы тэргүүн (976)онд *Жөнъ ши гва* гэж нэрлэсэн ба анхандаа нэрийн өөрчлөлт төдийгөөс хэтэрсэнгүй. Түшмэлийн авьяас чадвар төдийгүй нийгэм дэх холбоо хэлхээ, зан чанар хүртэл олон нарийн төвөгтэй шалгуурыг дамжисны дараа тарианы газартай хамт, түлээ бэлдэж болох газар хамт хуваарилж олгодог байсан тул ийн нэрлэжээ. Тэгсээр Могжон-ы тэргүүн(998) онд анх удаа Сөнжон-ы үеийн тогтолцоон дээр үндэслэн, түшмэдийн алба тушаалын өндөр намын дагуу арван найман зэрэг дэвийг тогтоож, тариалангийн болон зэрлэг газар хуваарилах нэгдсэн журам тогтов. Уг журмаар олгох газар нь нэг ёсны түшмэлийн цалин пүнлүү гэсэн үг юм. Тиймээс эзэмшигч нь үхвэл улс буцааж хурааж авдаг бөгөөд уг газрын тариалангийн гувчууртай холбоотой бүх асуудлыг улсаас эрхэлдэг, өөрөөр хэлбэл тариачнаас түшмэд шууд гувчуур татах эрхгүй, улсын сангаар дамжуулан авдаг байжээ. Энд бас цэргийн алба хаагчдад цалин пүнлүүний оронд газар олгох журам багтаж байв.

정동행성 **Дорныг дайлах төлөөний яам** (征東行省, Goryeo under Mongol rule) Корйөгийн сүүл үед Японыг байлдан дагуулахын тулд Юань улсын зүгээс Корйөд байгуулсан албан газар. Албан ёсны нэр нь Дорныг дайлах дундад бичгийн яам (征東行中書省) болно. 1280 (Цүнрйөл вангтийг 6-р) онд Японыг байлдан дагуулах зорилгоор байгуулсан авч уг хэрэг бүтэлгүй болсноос хойш үүрэг нь өөрчлөгдсөн ч нэр нь хэвээр байсаар байв. 1283 онд хоёр дахь удаагаа, 1285 онд гурав дахь удаа дахин байгуулсан боловч төд удалгүй татан буугджээ. Уг яамны сайд сайд болон *сынсан* тушаалыг Корйөгийн ван хавсран гүйцэтгэдэг байжээ. Хубилай хааныг нас барсны дараа Японыг байлдан дагуулах анхны зорилго нь үгүй болж, Юань улсын эзэн хаанд шинэ оны мэнд дэвшүүлэх элч илгээдэг ёслолын байгууллага болж хувирчээ. 1299 оноос Корйөгийн төрийн дотоод хэргийг хянаж, хөндлөнгөөс оролцдог шинжтэй байгууллага болж өөрчлөгджээ.

정사암 **Чонса ам** (政事巖, Jeongsaam) Пэгжэгийн үед төрийн хэрэг хэлэлцэн, тэргүүн сайд буюу жуапйөн(佐平)-ыг сонгодог байсан хадан цохиот газар. “Турван улсын нөхсөн судар”-т *Чонса ам*-ыг Пэгжэгийн сүүл үеийн нийслэл Саби (одоогийн өвөр Чүнчөн мужид)-ийн ойролцоо Хо-ам хийдийн ойролцоох газар гэжээ.

정안국 **Чөн ань улс** (定安國, Jeongan) Хятаны мөхөөсөн Бохай улсын иргэд Ялу мөрний сав газар Тай овогтны төр улс байгуулж, Бохай улсыг дахин сэргээхийг оролдов. Үүнийг хожуу Бохай улс гэж нэрлэдэг ба удалгүй Йөл овогт(열씨; 列氏)-ны төр тогтож улсын нэрийг Чөн ань улсгэж өөрчилжээ. Тай овогт вангийн угсааныхан тэргүүтэй тавин мянга гаруй Бохай-гийн язгууртан Корйө руу дүрвэн ирж, Корйө-гийн ноёлогч давхаргын нэгэн хэсгийг бүрдүүлэх болсон ба соёлын хөгжилд ч хувь нэмэр оруулжээ.

정토사상 **Ариун газрын шүтлэг** (淨土思想, Pure land) Шиллагийн үед голцуу феодалуудын гүнээ итгэж биширдэг шашны урсгалын хамт энгийн ард түмний талархлыг хүлээсэн урсгал зэрэгцэн оршиж байсан нь Буддын ариун дагшин орны тухай шүтлэг болно. Улсын вангаас хамгийн доод давхаргын боолчууд хүртэл Ариун

орон байдагт итгэж байсан боловч ялангуяа ядуу зүдүү, дарлагдсан ардууд хамгийн их итгэл найдвар тавин халуунаар хүлээж авчээ. Учир нь буддын шашны нарийн ээдрээтэй ёсонд нэвтрээгүй ч Аюуш бурханд мөргөм үү гэсэн утга бүхий “*На му амитха бүл*” гэдэг уншлагыг олон уншиснаар баруун зүгт Аюуш бурхны морилох Ариун дагшин оронд төрж чадна хэмээн итгэсэнд оршино. Ариун газрын шүтлэгтнүүд хорвоогийн амьдрал нэгэнт зовлон мөн тул хойт насанд диваажинд төрүүлж өгөхийг залбиран гуйдаг байв. Тийн залбирсаар тоогүй олон зовлонт хүмүүн хадан гэрээ бараадсан ба амьд сэрүүнээр тэнгэрт халин нисэж Ариун газарт очсон тухай домог хүртэл гарчээ. Газар сайгүй тархсан энэ шүтлэгийг феодалын нийгмийн эсрэг ард түмний үзэл суртлын идэвхгүй тэмцлийн хэлбэр гэж болох юм. Ариун газрын шүтлэг Шиллагийн буддын шашинд их өөрчлөлтийг авчирсан ба түүнийг өргөн тараасан хүн бол Вонхё лам байв. Вонхё лам, шашны номонд нэвтэрхий эрдэмт лам гэж алдаршсан ч, газар сайгүй тосгон тосгоноор хэрэн явж, Ариун газрын шүтлэгийг түгээснээрээ илүү алдаршсан гэдэг. Түүний «*Ю шим анъраг*» бүтээлд Ариун газрын шүтлэгийн тухай тодорхой туссан байдаг. Түүнд, Ариун газрын утга учир эгэл хүмүүний тусын тулд болохоос Бодисадвагийн төлөө бус гэсэн нь бий. Вонхё ламыг шашнаа түгээн дэлгэрүүлснээс хойш шиллачуудын арван хүн тутмын найм, ес нь буддын шашинд сүслэх болжээ.

제술업 Утга зохиолын шалгалт (製述業, Jesul-eob) Түшмэдийг төрийн албанд шалгаж авах зорилготой Орогсдын шалгалт нь Утга зохиолын, Сонгодог бичгийн(명경업; 明經業), Холимог(잡업; 雜業) гэсэн гурван төрөл байв. Утга зохиолын шалгалт нь дотроо Хятадын яруу найргийн нэг төрөл шүлэг *ши*(시; 詩), шүлгийн холбоц *нү*(부; 賦), өргөлийн магтаал *сон*(송; 頌), төрийн бодлогын талаарх санал *цайг*(책; 策) гэсэн хэдэн төрөл байжээ.

제왕운기 Эзэд хаадын магтуу (帝王韻紀, Jewang ungi, Songs of Emperors and Kings) Корйөгийн сүүл үед И Сын хюү-гийн зохиосон түүхэн найраглал. 1287 (Цүнрйөл вангийн 13-р) онд зохиосон бөгөөд дээд, дэд хоёр дэвтрээс бүрдэнэ. Дээд дэвтэрт нь Хятадын түүхийг, дэд дэвтэрт Солонгосын түүхийг өгүүлжээ. Солонгос улсын түүхийг

Тангунъ вангөм-өөс эхлэсэн тул “Турван улсын нөхсөн судар”-ын хамтаар хамгийн эртний түүхийг өгүүлсэн зохиол гэдгээрээ оццлогтой. Тухайн үед гадны түрэмгийлэлийн эсрэг үндэстний ухамсарыг сэрээхийн тулд солонгос үндэстний өвөг дээдэс, улсын язгуур үндэсийн тухай үзэл ойлголтыг бэхжүүлэхийг зорьсон гэж үздэг. Мөн эртний үлгэр домог, яриа хүүрнэлийг ихээр оруулсан бөгөөд. “Турван улсын түүхийн бичиг”-г орхигдуулсан зүйлс их байдгаараа түүхийн үнэт хэрэглэгдэхүүнд тооцогддог. Үндэсний соёлын 418-р үнэт зүйлээр бүртгэсэн бөгөөд 1360 онд Кйөнжүд барласан эх нь Тонгүг их сургуулийн номын санд хадгалагдаж буй.

제위보 Чэвүбо (濟危寶, Jewibo) Корйөгийн үед буюу 963(Кванжон-ы 14-р) онд ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор байгуулсан сан. 1391 онд татан буулгажээ.

조계종 Чоге ёс (曹溪宗, Jogye Order) Цэргийн эрхтний ноёрхлын үед Корйө-гийн буддын шашинд шинэ чиг хандлага үүсэв. Өөрөөр хэлбэл буддын зен урсгалын дотор *Чоге* урсгал бүрэлдэн тогтсон явдал юм. Ыицөнь лам буддын *Кё*, *Сөнь*(Зен) хоёр урсгалыг зохируулан нэгтгэх хэрэгтэй гэж дуугарч байсан ч үнэн хэрэгтээ зен урсгалыг *кё* урсгалд нэгтгэхийг оролдож байжээ. Тэрбээр өөрийн *Цөньтай* урсгалын ёс сургаалыг номлохдоо *зен* буддын Есөн уулын лам нарыг урвуулах бодлого явуулав. Гэвч Цэргийн эрхтнүүд төр барих тэр үес зен буддын Есөн уулын урсгал нэгдэж, шашны дэгийнхээ нэрийг *Чоге ёс*(조계종; 曹溪宗) гэж өөрчлөн нэрлэсэн байна. Тэд “*са*(사; 社)” хэмээх *Чоге ёсны* дэг сургуулийн төвүүдийг бий болгожээ. Хамгийн том нь Чөлла мужийн *Сүсөнь-са*(수선사; 修禪社, хожмын *Сонгван са*; 松廣寺), Канжин-ий Пайгрйөнъса(백련사; 白蓮社) болно. *Сүсөнь-са*-г үндэслэсэн Улсын багш Жи нүл(지눌; 知訥; 1158-1210) лам зен буддын сургаал дээр үндэслэн *зен* ба *кё* хоёр урсгалыг нэгтгэх онолын суурийг тавьсан гэдэг. Өөрөөр хэлбэл Жи нүл ламын хөгжүүлсэн *Чоге* урсгалын сургаал нь феодалын шашин гэж нэрлэж болох *Цөньтай* урсгал(천태종; 天台宗)-ын эсрэг байр суурьтай юм. Жи нүл ламыг залгамжлан *Чоге* урсгалыг цааш хөгжүүлсэн хүн бол *Сүсөнь* хийдийн хоёрдугаар хамба лам Хйэ шим(혜심; 慧諡; 1178-1234) юм. Улсын багш Хэйшим *Кё*, *Сөнь* хоёр урсгалын нэгдлээс цааш нэг шат ахиж, буддын шашныг хүнзийн

сурталтай нэгтгэх оролдлого хийжээ. Энэ нь Корйө-гийн үзэл суртал, аажмаар буддын шашнаас Шинэ хүнзийн суртал руу шилжих шилжилтийн үедээ орсон болохыг харуулна. Өмнөд Сүн(남송; 南宋) улсын Шинэ хүнзийн суртал Корйө-д нэвтрэн орж, буддын шашинд нөлөөлсний илрэл гэж үзсэн ч болох юм.

조공 Алба барих (朝貢, Tribute) Зүүн Азийн улс орнуудын уламжлалт харилцааны нэг хэлбэр.

Хятадад юм уу, эсвэл хил залгаа улсуудтай харилцахын тулд элч илгээж, алба барьдаг байв. Гадна талдаа эзэн ба түшмэг улсын харилцаа гэж болох ч харилцан ашигтай улс төрийн үйл ажиллагаа байжээ гэж хэлж болно.

주몽 Чүмон, Жүмон (朱蒙, Jumong) Когүрийөг үндэслэгч. Өргөмжит нэр нь Тонмйөнсөн ван.

ХТӨ 37 онд Чүмон-ыг дагасан пүйөчүүд Ялуу мөрний дунд хавь, Дунга голын сав газар дах Хвань инь(환인; 桓仁) нутагт суурьшиснаар Когүрийө улс төвхнөсөн гэж домогт өгүүлдэг. Умраас нүүж ирсэн ноёлогчид, уугуул нутгийхныг захиргаандаа оруулан төр улсын үндсийг тавьжээ. Домгоос үзвэл, хойт Пүйөд тэнгэрийн хааны хүү гэж биеэ нэрийдсэн Хэмусү, лусын охин Юхва хоёрын дундаас Жүмон төрсөн байна. ЮхВаг бүсгүй хүний журмыг үл сахисан хэмээн лусад хөөгдөж, эзгүй газар явахад нь Пүйөгийн Кымва ван ордондоо дагуулан аваачжээ. Удалгүй Юхва бүсгүй нэгэн том өндөг төрүүлж, өндөгнөөс Жүмон хүү гарчээ. Жүмон морь сургахдаа гарамгай, нум сумаар мэргэн харвадаг аж. Гэвч эх хүү хоёр Пүйөгийн вангийн ордонд гадуурхагдах болсон тул эхийн хүслээр өмнө зүг явж, загас, өчүүхэн яст мэлхийнүүдээр туслуулан, мөрөн гаталж, Чолбөнд улсаа байгуулжээ.

주역 Зурхайт ном (周易, I Ching) “Дөрвөн ном, таван бичиг”-ийн нэг нь бөгөөд Күнзийн

суртлын хамгийн эртний бөгөөд агуулгын хувьд хамгийн ээдрээтэй номд тооцогддог.

주자가례 Жү ши-гийн өрх гэрийн ёс (朱子家禮, Jujagarye) Өмнөд Сүн улсын күнзийн

сурталтан Жү ши-гийн бичсэн зохиол. Корйөгийн сүүл үеэс уг судрын нөлөөгөөр Корйөд гэр бүлийн бунхан(가묘; 家廟) барих болж оршуулга, гашуудал, тахилга, хуримын ёслолд буддын шашны зан үйл гүйцэтгэхээ больж эхэлсэн байна.

주희 Жү ши (朱熹, Zhu Xi 1130 ~ 1200) Өмнөд Сүн улсын гүн ухаантан, Күнзийн сурталтан.

Күнзийн сурталын шинэ урсгалыг системчилэн эмхтгэхэд нэгэн насаа зориулжээ.

중방 Чунбан (重房, Jungbang) Корйөгийн үеийн цэргийн эрх барих дээд, зөвлөлдөх байгууллага.

중서성 Чун сө сөн, Дундад бичгийн яам (中書省, Zhongshu Sheng) Корйө-гийн засаглалын тогтолцоог ван болон сурвалжит гэр бүлийн эрх ашгийг хамгаалах, бэхжүүлэх байр сууринаас тогтоожээ. Сөнжон-ы үед сурвалжит гэр бүлүүд төрийн эрхийг атгасан юм. Тиймээс үндсэндээ Сөнжон-ы 2-р(983) оноос Мүнъжон-ы 30-р(1076) он хүртэлх хугацаанд төр захиргааны байгууллагын бүтэц бүрэлдэн тогтжээ. Улс төрийн дээд эрхийг барих *Жун сө сөн*(중서성; 中書省), *Мүнъ ха сөн*(문하성; 門下省), *Сан сө сөн*(상서성; 尙書省) хэмээх гурван байгууллага байв. Энэ гурваас *Жун сө сөн*, *Мүнъ ха сөн* хоёр голлох үүрэгтэй тул нийлүүлж *Жун сө мүнъ ха сөн*(중서문하성; 中書門下省) эсвэл *Жайбү*(재부; 宰府) гэж нэрлэж байжээ. Уг хоёр байгууллагын сайдын нэг нь төрийн бодлогыг тогтоож, шийдвэр гаргах, нөгөө нь зөвлөх, хянах үүрэгтэй байв.

중추원 Чун цү вөнъ, Нууц бичгийн яам (中樞院, Privy Council хожмын *Цүмилвөнъ*; 추밀원; 樞密院, *Цүбү*; 추부; 樞府) Вангийн зарлигийг олон түмэнд дамжуулах, сайд түшмэдийн айлтгалыг ванд уламжлах болон цэргийн нууц хэрэг эрхлэх Ордны бичгийн хэрэг эрхлэх газар. Корйөгийн Сөнжон-гийн үед анх бий болжээ.

지눌 Чи нүл (知訥, Jinul 1158-1210) Сүсөнъ хийдийг үндэслэсэн Улсын багш цолтой бүддийн хувраг. Зен буддын сургаал дээр үндэслэн *зен ба кё* хоёр урсгалыг нэгтгэх онолын суурийг тавьсан гэдэг. Чи нүл ламын хөгжүүлсэн *Чоге* урсгалын сургаал нь феодалын шашин гэж нэрлэж болох *Цөнътхай* урсгал(천태종; 天台宗)-ын эсрэг байр суурьтай юм. Жи нүл ламыг залгамжлан *Чоге* урсгалыг цааш хөгжүүлсэн хүн бол Сүсөнъ хийдийн хоёрдугаар хамба лам Хйэ шим(혜심; 慧諶; 1178-1234) юм. Улсын багш Хэйшим *Кё*, *Сөнъ* хоёр урсгалын нэгдлээс цааш нэг шат ахиж, буддын шашныг хүнзийн сурталтай нэгтгэх оролдлого хийжээ. Энэ нь Корйө-гийн үзэл суртал, аажмаар буддын шашнаас Шинэ хүнзийн суртал руу шилжих шилжилтийн

үедээ орсон болохыг харуулна. Өмнөд Сүн(남송; 南宋) улсын Шинэ хүнзийн суртал Корйө-д нэвтрэн орж, буддын шашинд нөлөөлсний илрэл гэж үзсэн ч болох юм.

지증왕 Чижын ван (智證王, King Jijeung 500-514) Гурван улсын үеийн Шиллагийн 22-р ван.

Сожи марибгань угсаа залгах үр хүүхэдгүй үхэхэд бөл дүүгийн хувиар 64 насандаа ван сууринд суужээ. Энэ үеэс үхрийг газар тариаланд ашиглаж, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлсэн ба язгууртныг оршуулахад амьд хүнийг хамт оршуулах ёсыг хоригложээ. 503 онд Сара, Саро, Шилла гэхчлэн хэдэн янзаар дууддаг байсан улсын нэрийг Шилла болгожээ. Нутгийн үг болох *марибган*-ыг хэрэглэхээ болиод хятад маягаар ван цолыг хэрэглэх болжээ. Орон нутагт засаг захиргааны нэгжийг цэгцэлж, 512 онд Үсань улсыг байлдан дагуулсан бөгөөд өмнө нутагт бага нийслэл байгуулан шууд захирах болсон байна. Ван сууринд сууснаас хойш 15 жилийн дараа 78 насандаа өөд болжээ.

직지심체요절 Чигжи шимцэ ёжөл (直指心體要節, Jikji) Корйөгийн сүүл үеийн хутагт лам

Кйөнхөний эмхтгэн бичсэн бүддийн шашны ном. Корйө-д анх Кожон-ы 21-р(1234) онд “Эрт эдүгээгийн ёслолт бичиг(상정고금예문; 詳定古今禮文)” гэдэг номыг хорголжин хэвлэлээр хэвлэсэн анхны ном гэж үздэг. Харамсалтай нь энэ ном бидний үед уламжлан ирээгүй боловч Ү вангийн 3-р(1377) онд Цөнжү-гийн Хындөг хийд(흥덕사; 興德寺)-д хэвлэсэн *Чигжи шимцэ ёжөл* хэмээх судар бүрэн бүтэн хадгалагдан үлдсэн нь одоо байгаа дэлхий дээрх хамгийн эртний хорголжин хэвлэл гэдгээрээ үнэ цэнэтэй юм. Одоо Францын Парисын Үндэсний Номын Сангийн Дорно дахины сурвалж бичгийн санд хадгалагдаж буй. ЮНЕСКО-гийн дэлхийн бичгийн соёлын өвд бүртгэгджээ. Гуттенбэргийн хорголжин хэвлэлээр хэвлэсэн Библи судраас даруй 75 жилийн өмнө буюу 1377 онд хэвлэгджээ.

진골 Жинхэнэ ястан (眞骨, Jingol) Шиллагийн колхүм тогтолцооны тэргүүн зэрэг.

Жинхэнэ ястан нь Ким овогтнууд хэрнээ вангийн угсааны бус хүмүүс бөгөөд “Ариун ястан” устан үгүй болсон хойно ван угсааг залгах болжээ.

진국 Жинь улс (辰國, Jin) НТӨ 3-2 дугаар зууны үед Солонгосын хойгийн төв болон өмнөд хэсэгт оршин

тогтнож байсан улс. Жинь улсын нэр түүхийн сурвалжид анх, Тайдон мөрний сав

газар Вэй мань-ы Чосөнъ улс нутаглаж байсан ХТӨ II зууны үед тэмдэглэгджээ. Энэ үед Жинь улс Хятадын Хань улсад бичиг илгээж, харилцаа тогтоохыг санал болгож байжээ. Энэ нь Хятадаас төмрийн соёлыг нэвтрүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлагаас урган гарсан бололтой. Вэй мань-ы Чосөнъ улсын тавьсан хоригоос болж бүтээгүй. Гаднаас олноор нүүдэллэн ирэгсэд нутгийн иргэдтэй нэгдэж, улам хүчирхэгжисний дүнд Жинь улс нь Ма Хань(마한; 馬韓), Жинь Хань(진한; 辰韓), Пйөнъ Хань(변한; 弁韓) нэртэй Гурван Хань(삼한; 三韓) болж задрав. Энэ үед нэгэнт төр улс бүрэлдэн тогтож байсан болохыг өвөр Кйёнсан мужийн Тахо ли-д хийсэн малтлагаар олдсон эх хэрэглэгдэхүүн, олдвор баталдаг.

진대법 Жинь дэ бөб (賑貸法, Jindaebep) Когүрйө-гийн хаврын хахир зэлмүүн цагт үр тариа зээлдүүлж, намар ургац хураах үед буцааж авдаг журам. Улсаас энэ мэт олон янзын арга хэмжээ авсан ч ноёлогч ангийн эрх ашгийг урьтал болгодог тул туйлын хязгаарлагдмал шинжтэй тул тариачны амьдрал онц дээрдсэнгүй. Ялангуяа “*жинь дэ бөб*” нь язгууртнууд, чинээлэг тариачдын үр тариа өндөр хүүтэй зээлдүүлдэгийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн хэрэг болж, эцэстээ тариачдыг улам их сорон мөлжих мөлжлөгийн нэг хэлбэр болсон юм.

진한 Чинь Хань (辰韓, Jinhan) Солонгосын хойгийн төв хэсэгт оршин байсан Гурван Хань улсын нэг. Ерөнхийдөө НТ 1-4 дүгээр зууны үед, одоогийн Тэгү, Кйөнжү хавиар нутаглаж байсан 12 улсыг Чинь Хань гэж нэрлэдэг. “Гурван улсын ойллого”-ын “Вэй улсын ойллого”-оос үзвэл Кйөнжүгээр нутагтай Саро улс (斯盧國) хамгийн том нь байсан бөгөөд Кижө(己祗國), Пүлса (不斯國), Кынги (勤耆國), Нанмиримидон (彌離彌凍國), Йөмх (冉奚國), Күнъми (軍彌國), Йөдам (如湛國), Хоро (戶路國), Чүсөнъ (州鮮國), Майөнъ (馬延國), Үюү (優由國) гэсэн арван хоёр аймаг улс байжээ. Том аймаг нь 4-5 мянган өрх, жижиг нь 600-700 өрхөөс тогтож байв.

진흥왕 Жиньхын ван (眞興王, King Jinheung 540-576) Гурван улсын үеийн Шиллагийн 24-р ван. Жиньхын ван(540-576)-гийн үед Шилла байлдан дагуулалтаа идэвхжүүлж Жиньхын вангийн 12-р(551 он) онд, Пайгжэгийн Сөн вантай эвсэн, дотоодын

тэмцэлд хүч нь доройтсон Когүрийөг довтлон, Хань мөрний эхээр нутагласан Когүрийөгийн эзэмшил арван мужийг эзлэв. Улмаар Хань мөрний доод сав газрыг эзлээд байсан холбоотон Пайгжэгийн цэргийг үлдэн хөөж, бүхэлд нь өөрийн болгожээ. Үүнд хилэгнэсэн Сөн ван Шилла руу довтлосон боловч өөрөө Кваньсань хэрмийн байлдаанд амь үрэгджээ. Тийнхүү зуун хорь гаруй жил үргэлжилсэн холбоо задарчээ. Хань мөрний сав газрыг эзлэх нь хүн хүч, эд баялаг төдийгүй, баруун тэнгисээр дамжин Хятадтай шууд харилцах гарцтай болдог чухал ач холбогдолтой юм. Жиньхын вангийн 23-р(562 он) онд Кориён-ы Тай Каяаг мөхөөж, үржил шимт Нагдон голын сав газрыг эзлэв. Зүүн хойт зүгт Хамхыны тэгш тал хүртэл давшжээ. Жиньхын вангийн байлдан дагуулалтыг Цаннийөн, Пүгхань уул, Хван цо рйөн, Ма үнь рйөнд буй гэрэлт хөшөөний бичигт тодорхой дүрсэлжээ.

집현전 Мэргэдийн ордон (集賢殿, Hall of Worthies) Корйөгийн үеийн, улсын ванд үйлчилэх үүрэгтэй албан газар. Ном судар, албан бичиг баримт зэрэгтэй холбоотой ажил болоод ном хаялцах, бичгийн түшмэдийг төрийн албанд шалгаруулан авах зэрэг ажлыг хариуцан эрхлэдэг байжээ. Анх Кйөндөг ордон (慶德殿) гэж нэртэй байсныг 1021 (Хйөнъжон-ы 12-р) онд Йөнъйөн ордон (延英殿) хэмээн өөрчилсөн бөгөөд 1136 онд дахин Мэргэдийн ордон болгож өөрчилжээ. Улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан зарим үед үйл ажиллагаа нь буурч, заримдаа идэвхиждэг байв.

차차웅 Цаца-үн (次次雄, Namhae Chaung) Шиллагийн хоёрдугаар ван Намхэ-гийн цол. “Турван улсын нөхсөн судар”-т “Намхэ *көсөгань*-ыг мөн *цаца-үн* хэмээмүй. Энэ нь хүндэтгэлийн цол бөгөөд зөвхөн *имгым* хэрэглэнэ. *Цаца-үн*-ийг бас *чацүн* (자충, 慈充) хэмээмүй. Ким Дэмүнь ийн өгүүлжээ. *Цаца-үн* нь нутгийн хэлээр бөө зайранг нэрлэх үг. Бөө зайран нь чөтгөр шулмыг дээдэлж, тахилгыг эрхэмлэдэг учраас айж эмээн хүндэтгэн дээдлэх тул эцэстээ эрхэм дээд хүмүнийг *чацүн* хэмээн нэрлэжээ” гэж буй. *Чачүн* гэдэг нь багшийг хүндэтгэсэн нэр, мөн лам хуврагийг хэлсэн үг ажээ. *Шижо* Пагхйөггөсэ-г *көсөгань* хэмээн цоллодог нь улс төрийн шинжтэй цол, Намхэ ванг *цаца-үн* гэж цоллодог нь тахилын буюу шүтлэгийн

шинжтэй цол ажээ. Өөрөөр хэлбэл, Шиллагийн эхэн үеийн шүтлэг ба улс төр нийлэг байх үеийн онцлогийг харуулсан цол юм.

천리장성 Цөлл хэрэм (千里長城, Cheolli Jangseong) (1) Когүрийөгийн сүүл үеэр умард хилийг батлан хамгаалах зорилгоор байгуулсан хэрэм. 631 (Йөнрү вангийн 14-р) оноос эхлээд 16 жилийн дараа барьж дуусгасан уг хэрэм нь зүүн хойт нутгийн Пүйө хэрэм (夫餘城)-ээс эхлээд Сүнхва мөрөн (松花江)-өөс Ляо мөрөн (遼河)-ийг дагаж баруун урд зүгт Бохайн булан (渤海灣)-гийн Писа хэрэм (卑沙城) хүрдэг байна. (2) Корйөгийн эхэн үед хятан, зүрчид зэрэг умард зүгийн нүүдэлчдийн довтолгооноос хамгаалахын тулд умард хязгаарт чулуу овоолж барьсан хэрэм. 1033 (Төгжон-ы 2-р) оноос барьж эхлээд 1044 (Чөнжон-ы 10-р) онд дуусгажээ. Нийт урт нь мянган ли (нэг ли нь дөрвөн зуу гаруй метр) бөгөөд одоо ч Ыижү зэрэг газарт туйр нь бий.

천마도 Тэнгэрийн морьны зураг (天馬圖, Jangni cheonmado, Painting of Heavenly Horse on a Saddle Flap) Эмээлийн гөлөм дээр зурсан зураг. Уртаашаа 75cm, өргөнөөрөө 53cm, зузаан нь 6mm орчим бөгөөд 1973 онд Кйөнжүгийн Хваннам дон-ы 155 тоот бунхан (Тэнгэрийн морьны бунхан)-аас олджээ. 1982 оны 11-р сарын 16-ны өдөр БНСУ-ын Үндэсний соёлын 207-р үнэт зүйлээр бүртгэж, Кйөнжүгийг Үндэсний Музэйд хадгалж байгаа ажээ.

천마총 Тэнгэрийн морь бунхан (天馬塚, Cheonmachong) Ар Кйөнсан мужийн Кйөнжү хотод буй Гурван улсын үеийн Шиллагийн бунхан. Тэнгэрийн морин зурагтай гөлөм олдсон тул “Тэнгэрийн морин бунхан” буюу Цөнъмацон гэж нэрлэдэг. Дэлхийн соёлын өвд бүртгэлтэй.

천산대렵도 Тэнгэр уулан дахь агнуурын зураг (天山大獵圖, Cheunshandaeryeobjido) Корйөгийн сүүл үед, Конминъ ван зурсан хэмээн таамагладаг ан агнуурын сэдэвтэй зураг. 24,5 X 21.8 см хэмжээтэй. Торгон дээр зурсан өнгөт зураг. БНСУ-ын Үндэсний Музэйд хадгалаатай буй. Сөүлийн Их Сургуулийн номын санд мөн адил нэртэй бүтээл байдаг боловч зурсан арга барил нь өөр тул нэг зураачийн бүтээл гэж үздэггүй байна. Тарган морь унаад давхиж буй хүчирхэг эрчүүдийн нүүр царай, хувцас хунар, морьдын тоног хэрэгсэл зэргийн өнгө будгийг нарийн

гаргаж, уран нарийн дүрсэлсэн гэж өндөр үнэлдэг.

천태종 Цөнътхай урсгал (天台宗, Tiantai) “Корйө-гийн Гурван сав ном”-ыг Кё урсгалын ном

судрыг цэгцлэн нэгтгэсэн зүйл гэж хэлж болно. Буддын шашны Кё ба зен урсгалыг хослуулах хэрэгтэй гэж үзэж байсан Ыйцөнъ хүртэл өөрийн Хөлгөн судрын түүвэртээ нэг ч зен урсгалын ном судар оруулаагүй ажээ. Энэчилэн Корйө-гийн язгууртан феодалууд Кё урсгалыг илүү дагаж байсан ч нутгийн эрхтнүүдийн хүчээр тогтносон Корйө улсын нийгэмд зен буддизм байр сууриа эзэлсээр байв. Буддын шашны дээрх хоёр урсгал зэрэгцэн оршиж байсан нь аяндаа хагарал тэмцлийн үүдийг нээж өгчээ. Үүнийг гэтлэн давах, буддын шашны ертөнцийг өөрчлөн сайжруулах гэсэн оролдлогын илрэл нь *Цөнътхай* урсгал(천태종; 天台宗) бий болсон явдал юм. *Цөнътхай* урсгалыг анх Кванжон-ы үед (949-975) “*Цөнътхайн* дөрвөн ёс(천태사교의; 天台四敎儀)”-ыг бичсэн Чэ гванъ (제관; 蹠觀) үндэслэжээ. Эхэндээ Корйө-д бус Хятадад голцуу үйл ажиллагаагаа явуулж байсан тул бие даасан урсгал болж чадаагүй байна. Хожим Ыйцөнъ-ы үед бие даасан шашны урсгал болон төлөвшиж, түгэн тархжээ. Ыйцөнъ нь Мүнъжон-ы дөрөвдэх хүү бөгөөд бага залуугаасаа буддын ном судар уншиж судлан нэвтэрхий болсон ба хүнзийн суртал, даосын шашины номыг ч сайн мэддэг байв. Тэрбээр Сүн улсад очиж *ХВаом*, *Цөнътхай* урсгалын дэг ёсонд суралцасныхаа дараа Корйө-д ирээд, буддын шашины маргаантай асуудлыг шийдэх, өөрөөр хэлбэл *Кё*, *Сөнъ* хоёр урсгалыг нэгтгэх оролдлого хийжээ. Сэтгэлийн урвах холбирохыг ялж, ямагт үнэнийг эрэлхийлэх аваас бат нот сэтгэл нь цэцэн мэргэн ухаан болж, юм үзэгдлийн цаад учрыг нэвт харах болно гэдэг номлол *Цөнътхай* урсгалын гол үзэл санаа болно.

철기시대 Төмөр зэвсгийн үе (鐵器時代, Iron Age) Солонгосын архиологийн судлалд төмөр

зэвсэг хэрэглэж эхлэсэн НТӨ 300-гаад оноос Гурван улс бүрэлдэн тогтсон НТ-ын 300 оныг хүртэлх үеийг төмөр зэвсгийн үе гэж үздэг. Ингэхдээ хоёр үе болгон хуваадаг бөгөөд НТӨ 300 оноос НТӨ 100 он хүртэлхийг төмөр зэвсгийн эхэн үе, НТӨ 100 оноос НТ 300 он хүртэлх үеийг төмөр зэвсгийн хожуу үе гэдэг ажээ. Зарим судлаачид нэгтгээд Гурван улсын үе (三韓時代) гэж нэрлэх нь ч бий.

철령위 Цөллйөн вүи (鐵嶺衛, Cheollyeongwi) гэдэг нь Корйөгийн сүүл үе болох 1387 (Ү вангийн 13-р) онд Хятадын Мин улсын зүгээс Ляодунд байгуулсан цэргийн байгууллага юм. Юань улс мөхөж, Хятадын эх газрыг эзлэсэн Мин улс нь Юаний захиргаанд орсон Цөллйөн даваанаас хойшхи нутгийг эзэмших эрхтэй гэдгээ Корйөд мэдэгдэж, уг нутагт Цөллйөн вүи нэртэй цэргийн анги суулгажээ. Корйөгийн зүгээс үүнийг газар нутагт нь халдсан явдал гэж үзээд Ү ван, Цой йөн нар тэргүүлэн Цөллйөныг байлдан дагуулахаар зорьж цэрэг хөдөлгөжээ. Гэвч цэргийн жанжин И Сөнгэ нь вангийн зарлигийг зөрчиж, Ялу мөрний Вүихва арлаас цэргээ буцаагаад улмаар нийслэл Кэгийөныг эзлэж, Ү ванг сууринаас огцуулаад Цой йөныг цаазлажээ. Ийнхүү Корйө улс мөхөж, Чосөнь улс бий болох үндсийг тавьсан байна.

첨사부 Цөмсабу (詹事府, Cheomsabu) Корйөгийн үеийн, зүүн ордны аж ахуй болон бичгийн хэргийг эрхлэх албан газар.

첨성대 Цөмсөндэ (瞻星臺, Kaesong Chomsongdae) Ар Кйөнсан мужийн Кйөнжү хотын Иньван дон-д байрлах Одон орон ажиглах, чулуугаар барьсан цамхаг. 9,5 м өндөртэй, сууриараа 4,93 м, оройгоороо 2,85 м өргөнтэй. Шиллагийн Сөндөг хатан вангийн үед (632-647) барьсан гэж үздэг. БНСУ-ын үндэсний соёлын 31-р үнэт зүйлээр бүртгэжээ. Азид хамгийн эртний одон орон ажиглах цамхаг бөгөөд од эрхэс ажиглах багажийг уг цамхагт байрлуулаад 24 улиралд гарах одны өөрчлөлтийг ажигладаг байжээ.

첨의부 Хуйвийн сайдын яам (僉議部, Cheom ui bu) Корйөгийн сүүл үеийн, төрийн эрх барих дээд байгууллага. 1275 (Цүнрйөл вангийн тэргүүн) онд Юань улсын шахалтаар Корйөгийн төрийн байгууллагуудад өөрчлөлт оруулжээ. *Жүн сө сөн, Мүнх ха сөн, Сан сө сөн* хэмээн гурван байгууллагыг нэгтгэн Хуйвийн сайдын яам болгожээ. 1356 (Конминь вангийн 5-р) онд татан буулгаж, урьдын хэвээр *Жүн сө сөн, Мүнх ха сөн, Сан сө сөн* гэсэн гурван яамтай тогтолцоогоо дахин сэргээжээ.

청 Чин улс, Дайчин гүрэн (淸, Great Qing 1636 оны 4-р сар ~ 1912 оны 2-р сарын 12-ны өдөр) Хятадын түүхэн дэх хамгийн сүүлчийн нэгдсэн хаант улс. 1636 онд төрийг нь

төвхнүүлсэн бөгөөд 1912 он хүртэл гурван зуу гаруй жилийн туршид оршин тогтножээ.

청동기시대 Хүрэл зэвсгийн үе (靑銅器時代, Bronze Age) НТ-ын 1000 жилийн хавьцаа хээгүй ваар сав болон хүрэл зэвсэг хийж эхлэсэн үе. Солонгосын хойгоос хүрэл зэвсгийн үеийн булш бунхан ихээр олддог.

청해진 Цөнхэжинь (淸海鎭, Cheonghaejin) Цөнхэ гэдэг нэртэй цэргийн хуаран. Хындөг ван(흥덕왕; 興德王)-гийн 3-р(828) онд Чан По го, Цөнхайжинь хуаранг бариулжээ. Чан По го Тан улсад очиж цэргийн эрдэмд боловсорч байхдаа далайн дээрэмчид энгийн ард, тариачдыг хулгайлж, гадаад улсад боол болгон худалдаж буйг мэдээд нутагтаа харьж Хынъдөг ванд айлтган, өмнөд тэнгисийн гол цэг Вандо аралд Цөнхэ жинь хуаранг байгуулж, захирагч нь болжээ. Тэр түмэн цэрэг захирч, Тангийн далайн дээрэмчдээс тэнгисийн эрэг хавийн нутгийг хамгаалахын зэрэгцээ Тан, Японтой тэнгис гатлан худалдаа хийж байв.

최무선 Цой Му сөнъ (崔茂宣, Choe Museon 1325 -1395 он) Корйөгийн сүүл үед хвапхо хэмээх их бууг зохион бүтээж, Японы далайн дээрэмчдийг хөөн зайлуулахад гавьяа байгуулсан түшмэл. Йөнжү (永州) нутгаас гаралтай. Цой Дон сүнъ-ий хүү бөгөөд Юань улсын И вөнъ гэгчээс дарь хийх аргыг сурчээ. 1377 (Ү вангийн 3-р) онд Галт зэвсгийн хэрэг эрхлэх газар (火筒都監) байгуулагдахад дарь болон галт зэвсэг хийх ажлыг эрхлэж байжээ. Энэ үедээ хийсэн их буугаа ашиглаж, 1380 онд Насэ, Шим Дөг бү нарын хамтаар Чинъпхо (鎭浦)-д үүрлэсэн Японы далайн дээрэмчдийг бут цохьжээ. “Дарь боловсруулах арга (火藥修鍊法)” хэмээх ном бичсэн бөгөөд бидний үед уламжлан ирээгүй байна.

최승로 Цой Сын ро (崔承老, Choe Seungno 927-989 он) Кйөнжү нутгийн югтүпхүм гаралтай бичгийн түшмэл бөгөөд Корйөгийн улс төрд “юг-дүпхүм” гаралтай хүнзийн сурталт эрдэмтэд чухал үүрэг гүйцэтгэх болсны хамгийн нэртэй төлөөлөгч нь юм. Цой Сын ро төвлөрсөн засаглалт феодал улсыг бий болгохыг хүсэн зорьж байжээ.

Тэрбээр Шиллаг бууж өгөх үед Корйө-гийн албат болсон тул нутгийн эрхтэнүүдтэй адилгүй, хөдөөд өөрийн гэсэн тулах түших хүчгүй, эрдэмтэн хүн байв. Тиймээс түшмэл хүний хувьд зэрэг тушаал дэвших сонирхолтой байсан бөгөөд, энэ нь түүний улс төрийн үзэл бодлыг аяндаа феодалын төвлөрсөн засаглалыг дэмжих чигт хандуулжээ. Тэр бас вангийн хэмжээгүй эрхийг эсэргүүцэж байв. Язгууртнуудын бодол санааг үл хайхардаг хэмжээгүй эрхт ванд дургүй тэрбээр феодалууд төр улсыг удирддаг тийм нийгмийг бүтээн бий болгохыг хүсч байжээ. Цой Сын ро-гийн ийм үзэл бодол нь Сөнжон(성종; 成宗; 981-997)-д өргөсөн хорин найман зүйл бүхий санал(*Шимүцайг*; 시무책; 時務策)-д тодорхой тусчээ.

최영 Цой Йөн (崔瑩, Choe Yeong 1316-1388 он) Корйөгийн сүүл үеийн гавьяат сайд, цэргийн түшмэл. Корйөгийн сүүл үед Японы далайн дээрэмчид болон улаан алчууртны босогчдыг хөөн зайлуулахад гавьяа байгуулжээ. Конминъ ванг хорлох гэж оролдсон Хын Ван са-гийн самуун, Цой Юүгийн самуун зэргийг түвшитгэжээ. 1388 онд Йөм Хын бан, Им Гйөнъ ми нарын тэрслүү нарыг дарсан бөгөөд охиноо Ү вангийн хатан болгожээ. Мин улс Цөллөны нуруунаас хойшхи газар нутгийг өөртөө харьяалахаар завдахад гучин найман мянган цэргийг удирдан Ляодунг эзлэхээр хөдлөжээ. Гэвч энэ хэрэг нь И Сөн гэ-гийн эсэргүүцлийн улмаас бүтэлгүйтсэн бөгөөд хожим нь И Сөн гэ-д баригдан цөлөгдөж байгаад цаазлуулжээ.

최우 Цой Ү (崔瑀, Choe U ?-1249 он) Корйөгийн цэргийн түшмэлийн засаглалын 2-р үеийн эрх баригч. Цой Цүн хөнъ-ий хүү бөгөөд 1219 онд Цой Цүн хөнъ-ийг нас бармагц залгамжлан төрийн эрх барьжээ. Төрсөн дүү болох Цой хян нарын эрх булаацалдаж болзошгүй хүчинг улс төрийн цэвэрлэгээ хийн зайлуулсан бөгөөд Монголын довтолгооноос сэргийлж, хил хязгаар нутагт бэхлэлт хэрэм барьж, цэрэг дайчлах зэрэг арга хэмжээ авчээ. 1225 онд Чөнбан хэмээх албан газрыг байгуулж, түшмэдийн хэргийг эрхлүүлсэн байна. 1230 онд төрсөн дүү Цой хяны бослогыг дарж, 1231 онд Монголын довтолгоон эхлэхэд нийслэлийг Канхва арал руу нүүлгэжээ. 1234 онд Хон Пог вөнъ-ий бослогыг Сөгйөнд даржээ. 1243 онд Корйөгийн Их хөлгөн судар болох найман түмэн модон барыг үйлдэх ажлыг эхлүүлсэн байна. 1247 онд өөрийн хөвүүн Цой Манъ жөнъ-ийг залгамжлагчаараа сонгожээ.

최충헌 Цой Цүн хөнъ (崔忠獻, Choe Chung-heon 1149-1219 он) Корйөгийн үед цэргийн

түшмэлийн засаглал тогтоосон цэргийн түшмэл. Цэргийн түшмэдийн бослого Корйө-гийн нийгмийг эрс өөрчилсөн юм. Цэргийн эрхтнүүд ноёрхох болсон нь нийгэмд түгшүүртэй, тайван бус байдлыг бий болгожээ. Ийм үед гарч ирсэн Цой Цүн хөнъ, ванд арван зүйл бүхий шинэчлэх төлөвлөгөө өргөн барьсан байна. Үүнд: том феодалуудын зоргоороо байгуулсан олон яам, тамгын газрыг цөөрүүлж, нутгийн жижиг түшмэдүүдийн алба гувчуур хураах эрхийг хасах зэрэг зүйл оржээ. Гэвч энэ нь сайхан үг төдийгөөс хэтэрсэнгүй, үнэн хэрэгтээ зөвхөн өөрийн ноёрхлыг бэхжүүлэх үндэс суурийг бэлдсэн хэрэг байв. Өөрийн эсрэг талынхан төдийгүй зарлиг тушаалыг эс дагасан ойр дотныхныгоо ч устгаж, вангийн шадар хүмүүс, вангийн хүүг алс хол цөлсөн байна. Цой Цүн сү, Паг Жинъ жай(박진재; 朴晋材) нар тийнхүү золиос болсон хүмүүс юм. Вангийн засаглал нэр төдий болж, үнэн хэрэгтээ бүх эрхийг Цой Цүн хөнъ атгав. Тэрбээр Мйөнжон, Хыйжон хоёр ванг сууринаас нь огцруулж, Жинъжон(진종; 神宗), Хыйжон(희종; 熙宗), Канжон(강종; 康宗), Кожон(고종; 高宗) дөрвөн ванг өргөмжилжээ. Ван сууринд хэнийг өргөмжилж, хэнийг огцруулах нь түүний мэдлийн асуудал байв. Хэдий тийм боловч Ван овогтны вангийн засаглалыг хэвээр байлгасан нь нийгэмд угсаа гарлыг эрхэмлэх үзэл бат бэх оршсоор байсны учир бололтой. И Ый бан, Цой Цүн сү зэрэг урьд өмнөх цэргийн эрхтнүүдээс түүний ялгагдах тал нь бичгийн түшмэдийг дуурайж, вангийн угсааныхантай ураг барилдаж, вангийн худ болох замаар эрх мэдэл олох гэж оролдолгүй, өөрийн хүчинд дулдуйдсан явдаг юм. Цой Цүн хөнъ сүм хийдийн хүчийг сулруулав. Тухайн үед сүм хийд нь ван, бичгийн түшмэдүүдтэй холбоотой цорын ганц цэрэг зэвсгийн хүчтэй газар байв. Хэдэн мянган лам цэрэг Кайгён-ыг довтолж, цэргийн эрхтний ноёрхлыг нураахаар боссон удаатай. Тийм учир Цой Цүн хөнъ лам нарыг, ялангуяа вангийн татвар эмээс гарсан хүү болох “согунъ(소군; 小君)²¹” нарыг ордноос хөөн зайлуулжээ. Мөн тариачид, боолчуудын бослогыг цэргийн хүчээр дарахын зэрэгцээ аргадан тайвшруулах арга хэмжээ авав. Түүний үр дүнд тариачны бослого нэг хэсэгтээ дарагджээ. Цой Цүн хөнъ-ий хүчин чармайлтаар нийгэм улс төрийн байдал тогтворжиж, түүний хүү Цой и(최이; 崔怡)-гийн үед цэргийн эрхтний ноёрхол улам бэхжиж, засаг захиргааны тогтолцоо боловсронгуй болов.

최치원 Цой Ци вонъ (崔致遠, Choe Chung-heon 857-? он) Шиллагийн сүүл үеийн *югтунхум*

гаралтай күнзийн сурталтан. Цой Гйөн ил-ийн хүү бөгөөд 868 онд Тан улсад суралцахаар явж, 874 онд Тангийн Орогсдын шалгалтад тэнцэж байжээ. 894 онд Чиньсөн хатан ванд тухайн цаг үеийн тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар арван зүйл бүхий санал дэвшүүлсэн гэдгээрээ алдартай. Күнзийн суртал төдийгүй зен буддизм, бумбын шашин, Фэншуйн ухааны талаар өргөн мэдлэгтэй байжээ.

추밀원 Цүмилвонъ, Нууц бичгийн яам (樞密院, Chumil-won) Корйөгийн үеийн, вангийн

зарлигийг олон түмэнд дамжуулах, сайд түшмэдийн айлтгалыг ванд уламжлах болон цэргийн нууц хэрэг эрхлэх, мөн ордны харуул хамгаалалт, цэргийн зэвсэг зэргийг хариуцсан газар. Анх *Чун цү вонъ* (중추원; 中樞院) гэж байснаа хожим *Цүбү* (추부; 樞府) гэж нэрлэх болсон бөгөөд Сөнжон-гийн үед анх бий болжээ.

춘추관 Он дарааллын бичгийн газар (春秋館, Chunchugwan) Корйөгийн сүүл үеийн, улс төр,

засаг захиргааны хэрэгтэй холбоотой зүйлийг бичиж тэмдэглэх хэргийг хариуцсан албан газар. “Он дарааллын бичгийн газар”(춘추관; 春秋館)-ын түүхч түшмэдүүдийн бичсэн эдгээр ном судрыг бүрэн бүтэн байлгахын тулд Сөүл, Сөнжү(성주; 星州), Чөнъжү(전주; 全州), Цүнжү дөрвөн газарт Номын хөмрөг(사고; 史庫)-т хадгалжээ. Үе үеийн вангуудын гайхамшигт үйл хэрэг, хойч үед үлгэр дуурайл болох зүйлсийг он дарааллын бичгээс түүн авч тэмдэглэснийг “Төрийн эрдэнэт толь”(국조보감; 國朝寶鑑) гэдэг бөгөөд анх Сэжо-гийн 4-р(1458) онд хэвлэн гаргасан байна. Мөн Тайзу-гаас хойшхи Корйө-гийн вангуудын түүхийг бичихэд их анхаарал тавьж, “Корйө улсын түүх(고려사; 高麗史)”-ийг Сэжон-ы үед эхлэн бичээд Мүнъжон-ы тэргүүн(1451) онд дуусгажээ.

타제석기 Үзүүр мэс (打製石器, Crushed stone tools) Хуучин чулуун зэвсгийн үеийн чулууг

буталж хийсэн чулуун зэвсэг. Хүн төрөлхтөний хэрэглэсэн хамгийн анхны багаж зэвсэг гэж үзэх нь бий.

탐라총관부 Тхамра арлын хэрэг эрхлэх газар (耽羅總管府, Tamna Prefectures) Тхамра нь Чэжү

арлын хуучин нэр бөгөөд Монголын ноёрхолын үед булаагдсан нутагт байгуулсан захиргааны байгууллага юм. Юань улс нь Чэжү арал руу зугатан суурин суусан Гурван тусгай цэргийн үлдэгдэл хүчинг дараад Тхамра улсыг захирах газар(耽羅國招討使)- ыг байгуулсан бөгөөд 1275 онд Тхамра арлын хэрэг эрхлэх газар болгон өөрчилжээ.

태학 Тхэхэг (太學, Taixue) Когүрйөгийн Сосүрим вангийн 2-р он буюу 372 онд байгуулагдсан

улсын, боловсролын байгууллага. Төрийн хөвгүүдийн сургуулийн салбар бөгөөд тавдугаар зэргээс дээш түшмэлийн хүүхэд элсэж, суралцах эрхтэй байжээ. Күнзийн суртал, утга зохиол, байлдах эрдэм зэргийг заадаг байв. Когүрйө улс нь байгуулагдсан эхэн үеэсээ бичиг үсэгтэй байсан гэдгээс үзэхэд эртний Пүйөгийн үеэс хэрэглэж ирсэн ханз бичиг хэрэглэж байжээ хэмээн судлаачид таамагладаг. Когүрйө нь Хятадын эртний улсуудтай хил залган оршиж, эх газрын соёлыг эхлэн хүлээж авч байснаараа ханз бичгийг эрт үеэс хэрэглэж байсан бололтой. Гэвч сурвалжид улс байгуулагдсанаас хойш бараг дөрвөн зуун жилийн дараа сургууль байгуулж байсан тухай тэмдэглэл гарч байна. Сосүрим ван Хятадтай дайсагнасан харилцаатай байсныг эцэс болгож, Чянь Яньтай найрсаг харилцаа тогтоогоод эх газрын соёлыг хүлээн авч, улсын хүчин чадлаа бэхжүүлжээ. Улмаар бүддийн шашныг хүлээн авч, боловсролын байгууллага болох Тхэхэг-ийг нийслэл хотдоо байгуулсан байна. Энэ сургуульд язгууртны үр хүүхдүүдэд күнзийн суртал, ханз бичиг, нанхиадын утга зохиол, зэвсгийн эрдэм зэргийг заадаг байжээ.

팔관보 Пхалгванъ сан (八關寶, Palgwanbo) Корйөгийн үед , пхалгванъ хурлын зардал мөнгийг

хариуцдаг байсан сан. Мүнъжон-ы үед анх байгуулагджээ.

팔관회 Пхалгванъ хурал (八關會, Palgwanhoe) Нэгдсэн Шиллагийн үеэс эхтэй Корйөгийн үед

улам өргөжин хөгжсөн, тэнгэр тахих тахилын шинжтэй бүддийн шашны хурал. 551 (Жинъхын вангийн 12-р) онд анх Шиллад уг ёслолыг хийж эхлэсэн бололтой. Корйөгийн тайзугийн 10 зүйлт сургамжид уг хурлыг чухалчилан дурдсан байдаг бөгөөд Йёнъдын хурал хэмээх хурлын хамтаар төрийн чухал хоёр ёслолын нэг нь

байжээ. Жил бүрийн билгийн тооллын 10-р сарын 15-д хурдаг, ардын зан үйлтэй холилдсон шинжтэй уг шашны ёслолын үед дуу дуулж бүжиг хөгжим үүсгэн, олон Бурхадых баясуулж, улс орон, вангийн угсааныхныг амар амгалан, сайн сайхан байлгахыг залбиран гуйдаг байв. Корйөгийн эхэн үед ихэд өргөн дэлгэр тэмдэглэдэг байсанаа Хйөнъжон-ы үеэс буурч эхлэжээ. Корйөгийн сүүл үе хүртэл төрийн хамгийн том ёслол байсан бөгөөд Чосөнъ-ий вант улс байгуулагдснаас хойш тэмдэглэхээ больжээ.

팔만대장경 Найман түмэн модон барын их хөлгөн судар (八萬大藏經, Eight Great Medicines)

Кожон-ы 23-р (1236) онд Цой овогтын засаг газраас Их хөлгөн сударын албан газрыг байгуулж, модон барыг хийх ажилд оржээ. Бурхан багшийн сургааль, винайн ёс, Бурхан багшийн шавь нарын үг сургааль гэсэн гурван хэсгээс тогтох бөгөөд найман түмэн модон бар дээр 53 сая үсэг сийлсэн ажээ. Цой Ү тэргүүтэй ноёлогч ангийхан хөрөнгө мөнгө гаргаж, эгэл жирийн иргэд мод огтлон зөөж, мужаанууд модон барыг харуулдан бэлдэжээ. Лам хувраг, бичгийн хүмүүс сайн чанарын цаасан дээр модон бар дээр сийлэх сургааль номыг бичсэн байна. Энэ явцад дээд доод, хар ламгүй бүх л давхаргынхан улс орны амар амгалан, хүний аз жаргалын төлөө нэгэн сэтгэлээр мөргөн залбирчээ. Тийнхүү Монголын түрэмгийллийн үед корйөчуудыг оюун санааны хувьд нэгтгэсэн зүйл бол найман түмэн модон барын их хөлгөн судар болжээ. Монголтой ид байлдаж байсан 1251 онд их хөлгөн судрыг бүтээж дууссан байна. 16 жилийн нөр их хөдөлмөрийн үр дүнд бүтжээ. Уг хөлгөн судрыг ЮНЕСКО-гийн дэлхийн соёлын өвд бүртгүүлсэн байна.

팔조법금, 팔조법금 Найман зүйлт хориг хууль (八條之敎, Eight Prohibitions) Ко Чосөнъ-ий

хууль. Энэхүү найман зүйл хуулиас бидний үед мэдэгдэж буй нь гурван зүйл хууль болно. Уг турван зүйл нь “Хан улсын бичиг (漢書)”-ийн “Газрын ойллого (地理志)”-т байдаг бөгөөд нэгдүгээрт, хүн алсан хүнийг даруй цаазлана, хоёрдугаарт, бусдыг хохироосон этгээд хохирлыг тариа будаагаар барагдуулах ёстой, гуравдугаарт, бусдын эд зүйлийг хулгайлсан эрэгтэй хүнийг боол, эмэгтэй хүнийг шивэгчин болгоно гэжээ. Эхэхүү баримт нь Ко Чосөнъ улсад нийгмийн анги давхарга хэдийн бүрэлдэн тогтсон байсныг харуулах чухал мэдээ болно. Үүнээс гадна Ко Чосөнъ-д “хууль журам хатуу тул эмс охид ариун

явдалтай, садар самуун явдалтан байхгүй” хэмээн тэмдэглэснээс үзэхэд садар самууныг хориглосон зүйл анги байсан гэж таамагладаг. Үүнээс хойш Хятадын Хан улсын хууль ёс, соёл зэрэг нэвтэрснээр аж төрөх хэв маягт их өөрчлөлт орж, хуулийн зүйл анги жар гаруй зүйл болон олширсон гэж “Хан улсын бичиг”-т тэмдэглэжээ.

편년체 Он дарааллын түүх бичлэг (編年體, Biannianti) Түүхэн тэмдэглэлийг он, сар, өдрийн дэс дарааллаар бичих арга. Дорно дахины түүх бичлэгийн хамгийн эртний, түгээмэл арга бөгөөд бидний үед уламжилж ирсэн хамгийн эртний он дарааллын бичлэгийн аргаар бичсэн түүх бол Күнзийн Лу улсын түүхийг бичсэн “Хавар, намар” юм.

한 Хань улс (漢, Han dynasty НТӨ 202 он ~ 220 он) Хятадад эртний Чинь улсын дараа тогтсон нэгдсэн хаант улс. Чин улсын төр унасны дараа эрх мэдлийн төлөөх тэмцэл Шянь Юй, Лю Бан нарын хооронд өрнөснийг Чу Хань-ий дайн гэж түүхэнд нэрлэдэг. Энэ дайнд Лю Бан ялж улсаа Хань хэмээн нэрлэжээ. Лю Бан Чан-ань хотыг нийслэлээ болгоод өөрөө хаан суужээ. Тэрбээр Хятадын түүхэнд Хань Гаозү нэрээр алдаршсан байна. Хань улс хожим Гурван улс болон задарчээ. (220 он ~ 280 он).

한서 Хань улсын бичиг (漢書, Book of Han) Хань улсын түүх бөгөөд уг зохиолыг Зүүн Хань улсын түүхч Бан Гу голлон бичжээ. Хань улсын үүсгэсэн өндөр дээдэс Лю Бангаас Юйпиндиь Ван Мангийн үеийг хамарсан Баруун Хань улсын 200 гаруй жилийн түүхийг өгүүлнэ. “Түүхэн тэмдэглэл”-ийн хэв маягийг дуурайсан ч түүхэн хүмүүсийн намтрыг цадигчлан оруулж, эрүүгийн хууль, таван махбодь, газарзүй, урлаг утга зохиол гэсэн бүлгийг нэмж оруулсан нь уран зохиолын гэхээс илүү түүхэн тал руу жин дарсан зохиол болно.

항마군 Ад чөтгөрийг дарах цэрэг (降魔軍, Hangmagun) Корйөгийн үед зүрчидийг дарах зорилгоор байгуулсан тусгай цэрэг. 1104 онд Юүнъ гванъ-ы санаачилгаар байгуулжээ. Тусгай цэргийн анги дотроо Бурхны морьт цэрэг(신기군; 神騎軍), Бурхны явган цэрэг(신보군; 神步軍) бас Ад чөтгөрийг дарах цэрэг(항마군; 降魔軍) гэсэн гурван хэсгээс бүрджээ. Морьт, явган цэрэг нь голцуу *янбанъ*, чөлөөт тариачдаас, Ад чөтгөрийг дарах цэрэг нь лам нараас бүрдсэн байна.

해동통보 *Хэдонтхонбо* (海東通寶, Haedongtongbo) 1102 (Сүгжоны 7-р) онд цутгаж, гүйлгээнд оруулсан

зоосон мөнгө. Уг зоосыг гүйлгээнд өргөн дэлгэр ашиглахын тулд олон төрлийн арга хэмжээ авсан хэдий ч Ежон-ы үед *хэдонтхонбо* тэргүүтэй олон зоос гүйлгээнд ашиглагдахаа больжээ. Энэ нь нийгэм эдийн засгийн сул тааруу нөхцөл, мөнгөн дэвсгэргийн үнэ цэнийн талаархи ойлголт муу байсан зэрэгтэй холбоотой.

향가 *Хянга* (鄉歌, Hyangga) *Хянцал* үсгээр бичсэн Солонгосын эртний яруу найргийн төрөл. Утга уянгын

шүлэг. Бөөгийн дуудлага, шившлэг маягийн дуу нь Шиллад *Хянга* хэмээх ардын дууны нэгэн төрөл болон хөгжсөн бөгөөд түүний ая дан, ур техникийг орчин үеийн урлаг судлаачид ихэд өндөр үнэлдэг юм. *Хянга* дууг голцуу *хваран* юм уу буддын лам нар зохиосон тул хүний амар амгалан байдал, зол жаргалыг хүсэж, залбиран гуйсан утгатай байх нь элбэг. Мөн буддын шашны утга агуулгатай байх нь элбэг.

향교 *Хянгё* (鄉校, Hyanggyo) Корйё болон Чосён-ий үеийн, орон нутгийн күнзийн сургууль. *Хянгё*-д

орон нутгийн тамгын газарт ажиллах түшмэл, албан хаагчийг бэлдэхийн зэрэгцээ жирийн иргэдийн үр хүүхдэд боловсрол олгодог байжээ.

향리 *Хянри* (鄉吏, Hyangri) Корйёгийн орон нутгийн засаг захиргааны нэгжүүдэд төвийн

зургаан яамыг хуулбарласан зургаан “*нан*(방; 房)” гэж байсан бөгөөд тэнд тухайн орон нутагтаа үе улиран сууж ирсэн жижиг түшмэл болох “*хянри*(향리; 鄉吏)” нар ажилладаг байв. Уг ажил албаа үе өвлөн эрхэлдэг байсан ба тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагын ажлыг биечлэн гүйцэтгэдэг тул вангийн засаглалыг төлөөлөх захирагчийг орон нутгийн “*янбань*”нарыг төлөөлөх “*хянцөн*” түшмэлтэй холбох үүрэг гүйцэтгэдэг байжээ. Корйё-гийн үеийн “*хянри*” түшмэд вангийн ордонд хэргэм цол дэвшин язгууртан болох боломжтой байсан бол Чосён улсын үеийн “*хянри*” нар нийгмийн гарлаар ялгаварлагдан, “*янбань*” болох боломжгүй болсонд ялгаа нь оршино.

혜민국 **Иргэнийг ивээх газар** (惠民局, Hyeminguk) Корйёгийн дунд үед буюу 1112 онд

байгуулсан иргэдийг эмчлэх газар.

혜초 Хе цо (慧超, Hyecho 704-787) Өвөр, ар улсын үед Энэтхэгт аяласан тэмдэглэл болох

“Энэтхэгийн таван хаант улсад аяласан тэмдэглэл”-ийг бичсэн хувраг. 719 онд Тан улсад байхдаа энэтхэг ламаас нууц тарнийн ёсонд суралцжээ. Тэгээд багшийнхаа заавраар Энэтхэг рүү шашны ёсонд суралцахаар явжээ. Дөрвөн жилийн турш Энэтхэгээр аялаад буцаж ирсэн хойноо нууц тарнийн ухааны ном судар судлах, бүддийн сургаалийг ханз бичгээр орчуулах ажилд шамджээ. 780 онд бүддийн шашны ном судар орчуулахаар Одэ ууланд очиж суусан гэснээс хойш түүний тухай мэдээ тасарчээ.

호부 Орх явдлын яам (戶部, Amulet) Корйөгийн үеийн зургаан яамны нэг. Орхийн бүртгэл, алба гувчуур, мөнгөн тэмдэгт, үр тарианы хэргийг хариуцдаг байжээ.

호족 Нутгийн эрхтэн (豪族, Hujok) Шиллагийн сүүл үе, Корйөгийн эхэн үед нийгмийг өөрчлөх хөдөлгөөнийг манлайлсан орон нутгийн улс төрийн хүчин юм. Нутгийн эрхтнүүд их хэмжээний газар эзэмшдэг, эдийн засгийн хүч чадалтайн дээр хувийн цэрэгтэй байлаа. Тийм учраас төвийн засаглалтай төстэй албан газар байгуулж, түүгээрээ орон нутгийнхныг захирдаг байжээ. Түүгээр зогсохгүй нутгийн эрхтнүүдийн өвөрмөц соёлыг бий болгожээ. Нутгийн эрхтнүүд Корйөгийн вант улсыг төвхнөхөд голлох үүрэг гүйцэтгэсэн бөгөөд нэг хэсэг нь яваандаа төвийн засаглалд дэвшиж, сурвалжит гэр бүлүүд болсон бол нэг хэсэг нь орон нутгийн түшмэд болсон байна. Орон нутгийн түшмэлүүд нь орогсдын шалгалтаар дамжин төвийн засаг захиргаанд дэвшин ажиллах үүд хаалга нээлттэй байлаа.

홍건적 Улаан алчууртны босогчид (紅巾賊, Red Turban Rebellion) Юань улсын сүүл үеэр Хэбэй мужид эхлэн гарсан тариачны босогчид. Таних тэмдэг болгон толгойдоо улаан алчуур зүүсэн тул улаан алчууртны босогчид гэж нэрлэжээ.

홍익이간 Хон-иг инъгань (弘益人間, Hongik Ingan) “Хүн төрлөхтний тусын тулд” гэсэн утгатай үг бөгөөд Солонгост төрт улс үүсэх үеэс хэрэгжүүлсэн, улс төрийн дээд зарчим. Солонгосын хойгт анх удаа тогтсон төрт улс болох Ко Чосён-ыг байгуулсан Тангүн-ий төрт ёсны үзэл бөгөөд дөрвөн мянга гаруй жилийн туршид Солонгосын улс төр, боловсролын дээд үзэл суртал болох хөгжиж иржээ. “Гурван

улсын нөхсөн судар”-ын Тангүн-ий домогт Хон-иг иньгань хэмээх уг анхлан гардаг бөгөөд түүнээс үзвэл, Хван-инь хэмээх тэнгэрийн бурхны хөвүүн болох Хван-үн нь хүний ертөнцөд бууж очихыг ямагт хүсэмжилдэг байжээ. Аав нь хүүгийнхээ энэ хүсэл зорилгыг мэдээд хүүдээ “*цөнь бү инь*” (천부인; 天符印) гурвыг өгч, газарт буулгав. Хвань үн гурван мянган албатаа дагуулан Тэбэг уулын орой дахь *Шиньдань* (신단수; 神檀樹) модны дор “бурхны хот”-оо байгуулжээ. Тийнхүү “салхины бурхан, борооны бурхан, үүлний бурхан”-ыг захирч, үр тариа, амь нас, өвчин зовлон, ял шийтгэл, буян нүгэл гэхчилэн хүний гурван зуун жаран төрлийн үйлийг удирдаж, хүн төрөлхтнийг захирсан гэнэ. Баавгай байснаа хүн болж хувирсан бүсгүйтэй Хвань үн гэрлээд төрүүлсэн хүү нь Таньгүн бөгөөд Таньгүн “Хүн төрлөхтний тусын тулд” гэдэг үзлээр төрт улсаа байгуулжээ. 1948 онд БНСУ-ыг тунхагласнаас хойш уг үзэл нь боловсролын үндсэн зарчим болсон бөгөөд Боловсролын хуулийн 1-р зүйлд “хүн төрлөхтний тусын тулд гэдэг үзлийн дор боловсролыг хөгжүүлэх бөгөөд ард түмнийг нийтэд нь хүний хөгжлийн хувьд төлөвшүүлж...” хэмээн заажээ.

화랑도 *Хварандо* (花郎徒, Hwarangdo) Шиллагийн үеийн хүүхэд залуусыг боловсруулж хөгжүүлэх бүлэглэлийн нэр. Чанд нарийн бүлгийн зохион байгуулалтай байсан бөгөөд күнзийн боловсрол олгохын зэрэгцээ цэргийн сургуулилт хийлгэж, харилцааны урлагт сургадаг байжээ. Бүлгийн удирдагчийг *хваран* гэх бөгөөд бүлгийн гишүүдийн тоо дээд тал нь мянга хүрч байжээ. Улс орон үймээн самуунтай хүнд үед шилдэг боловсон хүчин шаардлагатай байсан цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцсан бүлэг байв. Тиймээс хагас улсын, хагас хувийн шинжтэй байгууллага байлаа. Гэхдээ Гурван улсыг нэгтгэснээс хойш энэхүү шинж чанар нь нэлээд хувьсан өөрчлөгджээ. Хварандо гэдэг нь цэцэг мэт үзэсгэлэнтэй эр хүн гэсэн утгатай. *Хварандо* нар нь Гурван улсыг нэгтгэх болон нийгмийн гарлаар хатуу ангилдаг колхүм тогтолцоот нийгмийн зөрчил тэмцлийг зохицуулахад ихээхэн хувь нэмэр оруулсан байна.

화백 *Хвабайг* (和白, Painter) Шиллагийн үед төрийн хэргийг хуралдан шийддэг байсан язгууртны хурал. Нийт ноёлогч ангийн төлөөлөгч болох “*сандайдын*” хэмээх сайд

(Пөбхын вангийн 18-р(531) онд бий болгосон) хурлыг удирддаг байжээ. Овгийн байгууллын үед чухал хэргийг овгийн хурлаар шийддэг байв. Шиллагийн “*хвабайг*(화백; 和白)” нь түүний тод жишээ юм. Овгийн ахлагч нь ямар нэг зүйлд буруутвал даруй огцрох бөгөөд эхэн үеийн Пүйө(부여; 扶餘)-гийн вангийн жишээн дээр харж болно.

황룡사 Хванрён хийд (皇龍寺, Hwangnyongsa Temple) БНСУ-ын ар Кёнсан мужийн Кёнжу хотод буй Гурван улсын үед буюу Шиллагийн 24-р ван болох Жиньхын вангийн үед барьсан хийд. Бидний үед хийдийн буйр туурь л улджээ. Хийдийг улс орны амар амгаланг билэгдэн барьсан тул хэмжээний хувьд ч том. Хванрён хийдийн есөн давхар суварга нь есөн улсыг нэгтгэн дагуулж, алба бариулахын билэгдэл болохын хувьд шиллачуудын хүсэл эрмэлзлийг тусгажээ.

효경 Ачлалт ном (孝經, Classic of Filial Piety) Күнзийн суртлын 13 номын нэг. Эртны Хятадын ёс суртахууны тухай өгүүлсэн ном.

후고구려 Хожуу Когүрьё (後高句麗, Later Goguryeo 태봉, 泰封, Taebong) Хожуу Когүрьё улс бас Тхайбон гэж нэрлэдэг. Вөнъжү-гийн Янгил-ийн албат байгаад хожим бие даасан Күн йэ нь татвар эмийн хүү тул язгуур гарал дорой хэмээн вангийн ордонд адлагдсан хүн байв. 894 онд Мйөнжү(명주; 溟州; Канрын; 강릉)-г дайрч эзлэх үед түүний цэрэг гурван мянга хүрч байв. Цэргүүдтэйгээ хамт бэрхийг туулж, ял шагналыг зөв шударгаар шийтгэдэг хэмээн олны хүндэтгэлийг хүлээж, жанжин цол хүртжээ. 896 онд Сон-аг(송악; 松岳; Кайсөн; 개성) нутгийн том эрхтэн, Ванрюн, түүний хүү Вангёныг талдаа элсүүлж, эзэмшил нутгаа өргөтгөв. 900 онд хойгийн төв хэсгийг бүхэлд нь эзэлсэн Күн йэ “Шилла, Тангийн цэргийг даллан ирүүлж, Когүрьёг мөхөөсөн учир нийслэл Пхйөнян-ы буйр ав хомрогын газар болж, өтгөн өвс ургасан нь өшивч баршгүй хэмээн, Когүрьё улсыг дахин сэргээх уриан дор Хожуу Когүрьёг байгуулснаа зарлав(Хю-гон вангийн 5-р, 901 он). Түүний дараа улсаа Мажинь(마진; 摩震) гэж өөрчлөн нэрлэж, нийслэлийг Цөрвөнъ руу нүүлгэн шилжүүлснээ дахиад улсын нэрийг Тхайбон(태봉; 泰封) гэж сольжээ

Тариачин цэргийн удирдагч Күн йэ нь ван болсноосоо хойш харгис хэрцгий, шунахай этгээд болон хувилав. Тариачдыг хайр найргүй мөлжин, тансаг гоё орд

харш бариулан, өөрийгөө амьд Майдар бурхан, хүүдүүдээ Бодисадваа хэмээн өргөмжилсөн гэнэ. Салхинд гарахдаа хээнцэр ганган хувцас, алтан титэм өмсөөд, торгоор бүрхсэн морь унаж, хүүхэд, эмэгтэйчүүдээр дуу дуулуулан дагалдуулдаг байв. Өөрийн зарлигийг үл дагагсад болон сэжиглэсэн бүхнээ энгийн ард, албат шадар нараа төдийгүй үр хүүхдээ хүртэл хайр найргүй алж устгадаг байжээ. Тийнхүү гэмгүй хүнийг тоо томшгүй хороож, даган орж ирсэн шиллачуудыг толгой дараалан хороосон нь олон түмэн, ойр дотныхон бүхний дургүйцлийг төрүүлэв. Ийм нөхцөл байдалд олны дэмжлэгийг хүлээсэн Вангөнъ түмэн цэрэг хөдөлгөн, вангийн ордныг дайрч, төрийн эрхийг булаан авав(918 он). Күн йэ хувцсаа сольж өмсөөд, зугатаж ууланд бүтсэн боловч Пү-ян гэдэг газар баригдаж алуулжээ. Ийнхүү хорин найман жилийн дараа Тхайбон улс түүхийн тавцнаас арилав.

후백제 Хожуу Пэгжэ (後百濟, Later Baekje) Нэгэн үе Шиллагийн баруун өмнөд тэнгисийн эргийн цэрэгт алба хааж, гавьяа байгуулж явсан Кйөнъ хвөнъ, тариачны дайн улс даяар өрнөмөгц тариачин цэргийн толгойлогч болжээ. 892 онд Кйөнъ хвөнъ-ы цэрэг, Кйөнжү-гийн баруун өмнөд талын тосгодыг дайрах үеэр боссон тариачид ирж нэгдсээр сар хүрэхгүй хугацаанд таван мянга гаруй хүнтэй болжээ. Кйөнъ хвөнъ даруй Мүжинъ-жү(무진주; 武珍州; одоогийн Кванжү)-г эзэлж, гол түшиц газраа болгон улмаар шинэ шинэ газрыг өөрийн болгов. Одоогийн өвөр Чөлла муж өвөр Цүнцөн мужийн нутгийг эзэлсэн Кйөнхвөнъ 900 онд Ванъсанъжүг нийслэлээ болгож улсаа Хожуу Пэгжэ(후백제; 後百濟) гэж нэрлэв. Кйөнъ хвөнъ, Хожуу Пайгжэг тунхаглахдаа, Шилла нь Тангийн харийн эзэрхийлэгчтэй нийлж Пайгжэг мөхөөснийг дурдан, “Пайгжэ улсыг дахин мандуулсан” болохыг онцлон зарласан нь тухайн нутгийн ард түмний Шиллагийн вант улсын эсрэг санаа сэтгэлийг ашигласан хэрэг бололтой. Кйөнъ хвөнъ арван хүүтэй байснаас дөрөвдүгээр хүү Кымган(금강; 金剛) бие том, ухаан сэргэлэн гэж өөрийгөө залгамжлуулжээ. Үүнд дургүйцсэн гурван ах нь Шингөм, Янгөм, Юнгөм нар хуйвалдаан зохиож, эцгийгээ Кымсан хийдэд хориод, хүн явуулж, дүүгээ хорлуулжээ. Дөч гаруй жилийн хүнд бэрхийг туулан хийсэн үйл хэрэг нүдэн дээр нь нурж унахыг тэвчиж чадалгүй Кйөнъ хвөнъ, Корйө руу зугатаж, Вангөноос тусламж эржээ. Вангөнъ, Кйөнъ хвөнъ-д өндөр цол хэргэм шагнаж, Янжүг идэх хот болгон тасалж өгөөд, туйлаас

хүндэтгэв. Хэсэг хугацааны дараа Кйөнъ хвөнъ-ий хүргэн, Хожуу Пайгжэгийн жанжин асан Йөнгю-тэй нууцаар харилцаж, Вангөнъ, Кйөнъ хвөнъ хоёр зөвлөлдөн зуу гаруй мянган цэрэгтэй Ар Пайгжэг довтлов. Гэнэтийн довтолгоонд бэлтгэлгүй байсан тул даруй эзлэгдэж, Шиньгөм тэргүүтэй ах дүү гурав баригдан алуулав. Энэ гунигт төгсгөлийг нүдээр үзсэн Кйөнъ хвөнъ хүндээр өвчилж, удалгүй Хвансанъ-д нас эцэслэжээ. Ийнхүү Шиньгөм-ын ван байсан нэг жилийг оруулаад, дөчин тавхан жилийн богинохон түүхийг Хожуу Пайгжэ улс туулжээ.

후삼국시대 Хожуу Гурван улсын үе (後三國時代, Later Three Kingdoms period) Нэгдсэн Шилла

задарч, Хожуу Пэгжэ, Хожуу Когүрйөг залгамжилсан Корйө зэрэг гурван улс зэрэгцэн оршсон 900-936 оны хоорондох үеийг хэлнэ. Шиллагийн вангийн засаглалыг эсэргүүцэн боссон тариачны хөдөлгөөнийхөн дундаас нэг хэсэг нь орон нутгийн эрхтнүүдтэй хүч хавсран, өргөн уудам газар нутаг эзэлж, шинэ феодал улс байгуулж эхлэв. 900 онд Кйөнъ хвөнъ Хожуу Пайгжэг, 901 онд Күн йэ Хожуу Когүрйөг байгуулснаар Хожуу гурван улсын үе эхлэв. 918 онд Күн йөг хөөж зайлуулсан Вангөнъ улсаа Корйө хэмээн нэрийджээ. 935 онд Кйөнъ хвөнъ Корйөд зугатан очиж, Шиллагийн Кйөнсүнъ ван мөн Вангөнъд дагаж оржээ. 936 онд Вангөнъ хожуу Пэгжэг эзлэснээр Хожуу Гурван улсыг нэгтгэжээ.

훈요 십조 Арван чухаг сургамж (訓要十條, Hunyo Tenjo) “Корйөса”-д бичиж үлдээсэн

Корйөгийн Тайзу үр хойчдоо захиж үлдээсэн гэх арван зүйлийг хэлнэ. “Арван чухаг сургамж”-даа угсаа залгах хожмын вангуудад улс төр, үзэл суртлын талаар дагаж мөрдөх хэрэгтэй зүйлсийг бичсэн байна.